

## ТОЛЬ

### “БУРХАН БАГШИЙН СУРГААЛ, ОШО БОГДЫН ТАЙЛБАР”

### “ОШО БОГДЫН АЙЛДВАР”

#### *АЖИГЛАХ*

Бясалгал бол сэтгэлд хууртахгүй сонор хянуур байхын нэр /Ошо Очир огтлогч, х 92/. Будда: “Сэтгэлийн амсуурга бүхэн цахилгаан цахихтай адил. Тэр бүгдэд уягдалгүй зүгээр л ажигла. Юу хүртэгдэж байна, түүнийг дурд: “өвдөлт өвдөлт”, “гоо сайхан гоо сайхан”, “хайр хайр” гм. Дурдаад л гүйцээ. Дурдан санах ухамсраас бусад нь мөнх бус үзэгдэл /тэнд, х 93/. Дотоод огторгуйн ажиглагч бай /тэнд, х 94/. Чамайг арилахад хамаг амьтан ч арилдаг. Би чи-гийн ялгаа үгүй нэгэн бүхэл болдог /тэнд, х 95/. Амьсгал бүрээ ухамсарлаж, үйлдэл бүрээ гэрчил. Амьдралын хэмнэл бүрийг ажигла. Нэг ч үйлийг ухамсаргүйгээр эс үйлдэх нь саммасти /үнэн зөв дурдал, тэнд, х 14-15/.

#### *АЗ ЖАРГАЛ*

Ямар ч болзол үгүй зүгээр л таашаан баясахаас өөр аз жаргалд хүрэх зам үгүй. Жаргал бол гүн энгүүн байгаллиг төрөлх чанар болохоос хийж бүтээдэг зүйл биш. Жаргал бол чиний мөн чанар /АГ 13, Нирваан, х 151/.

Хэдий буруу замаар ангижирсан ч солиотон бол оюун бодлоос ангижирсан нэгэн. Тэр өнгөрснийг дурсаж, ирээдүйг санаашрахгүй, цаг хугацаанаас алдуурч цаггүй мөнхөд амьдардаг. Ямар ч амбиц, хүсэл шунал байхгүй, хаашаа ч чиглэхгүй, юунд ч яарахгүй. Солиот, егүзэр хоёрын төстэй тал энэ. Егүзэр солиотоос ч жаргалтай, эрүүлээс эрүүл, тэрээр эсрэг тэсрэгийн өв тэгш шүтэн барилдлага юм /АГ 13, Нирваан, х 154/.

#### *АЙДАС*

Бодол айдсаас ургадаг. Дотроо ялихгүй айдас, шалихгүй бодолд ээдрэх юм бол хоосон чанарт үйлдэж чадахгүй /Эртний сайхан аялгуу АГ 15, х 81-83/.

Хүн бүхэн тэнгэр заяатан мөртөө барлагийн барлаг мэт амьдардаг. Хүн бүр эрдэнийн сан өвөрлөж төрсөн мөртөө үгээгүй гуйранч шиг амьдардаг. Хий дэмий айдас зовнилоос ангижрах хирээр чи түүнийг ухамсарлах болно. Айдас төрөх үед түүнийг нууж хаах юмуу нухчин дарах хэрэггүй. Айдастайгаа нүүр тулж нүд цавчилгүй ажигла. Айдсын гүн хөндий рүү ширтээд л бай. Мэдээж хөлс чийхарч, яс хавталзам жихүүдэс төрж, үхэл шиг санагдахвий. Амьдрахын тулд чи үхлийг олон удаа мэдрэх ёстой. Аажмаар хараа тодорч ухамсар сэргэнэ. Тэр хирээр айдсын манан замхрах болно. Айдас нэгэнтээ замхрах юм бол үхэшгүй гэдгээ ойлгоно. Үхэл үнэндээ байхгүй. Үхэл бол хамгийн хуурмаг илбэ. Үхэшгүй гэдгээ ганц агшин ч атугай харж чадвал өөр бясалгал дадал шаардлагагүй. Тэр л амсуураар амьдарч, тэр л туршлагаараа үйлд. Өнө мөнх амьдралын үүд өмнө чинь нээгдэнэ.

Бид бие цогцдоо хэтэрхий уягдаж байдаг. Түүнээсээ болж үргэлжийн айдаст автаастай. Бие махбод үхэж мөхөх жамтай. Харин чи бол үхлээс хэтийдсэн оршихуй. Чи бол бие биш, биегүй мөн чанар. Чи бол үзэгдлээс ангид үзэгч, гэрчлэгч. Үхэл замхарч айдас арилахад Есүсийн хэлдгээр өгөөмөр баян Бурханы хаант улс тодорно. Бурханы орон дотор чинь бий /Эртний сайхан аялгуу АГ 15, х 84/.

## **АЛДАС**

Авшиг авчхаад орхиж одох нь ариун дээдийг доромжилсон алдас /АГ 11, х 35/.

## **АМАР АМГАЛАН**

*Үзэх: Махамутар*

Дотоод сэтгэлийн чимээ аниргүй амгалан. Энэхүү амгалан байдал нь дотоодод тань ямар ч чичиргээ үгүй тийм гүнзгий амгалан. Та ердөө ганц ч долгис үүсээгүй усан сан шиг бүхий л биеэрээ амгалан, дотооддоо төв хэсэгтээ амгалан байна /Ошо Зэн – Гэгээрэхүйн бясалгал, х 21/.

Амар амгалан, чимээгүй байдал бол ямар нэг юмыг илүүд үзэхээсээ болж зовох үзэгдлийг ойлгох явц юм. Амар амгаланг илүүд үзсэнээрээ зовох болно. Илүүд үзэхгүй бол ямар ч зовлонгүй, аяндаа амар амгалан болно /тэнд, х 44/.

## **АМЬДРАЛ**

*Үзэх: Зүгээр байхуй, Инээд*

Амьдрал бол Бурханы соёрхсон гайхамшигт бэлэг. Сэрсэн хүн л түүнийг харна. Хүслийн манант нүдээр түүнийг харах боломжгүй /АГ 11, х 63/. Амьдрал бол илбийн наадам. Нэг тоглоомоос нөгөөд шилжиж, хувьслын бүхий л хэлбэрт орж туршсан /мод, бар, хүн, өт хорхой гм/. Амьдралын бүхий л ангийг дүүргэж, хүний бүх хичээлийг дүүргэж гэмээ нь чи амьдралын цөм рүү орох боломжтой. Тэр бол Бурхан буюу Нирваан. Оршихуйн замаас өөр суралцах зам байхгүй /АГ 11, х 27/. Оршихуй энэ агшинд өмнө чинь халгиж цалгиж байна. Харин нүд чинь хаа хол тэнгэрийн хаяаг тэмтчиж явна. Амьдрал дотор чинь ундраастай. Чи л өөрөө гэртээ алга /тэнд/.

Амьдрал бол логикгүй зэрлэг. Амьдралд эсрэг тэсрэг тал угтаа байхгүй. Өдөр нь шөнө болж, шөнө нь өдөр болно. Бүх зүйл бүх зүйлдээ сүлэлдэнэ. Чи амрагтаа уусч, амраг чинь чамд уусна. Үр хүүхэд чинь бие даасан бодгаль ч та нарын нэгэн хэсэг хэвээр. Хил зааг нь тодорхойгүй. Харин логик хил зааг тогтоох гэдэг. Тэр амьдралыг 2 хэсэгт зааглаж хуваадаг. Амьд чанарыг золиослон байж логик тодорхойг хүртдэг /Эртний сайхан аялгуу, АГ 4, х 168/. Логикоос зүүгдээд байвал амьдралаас нэг мэдэхэд гээгдэх болно. Амьдралд ямар ч хил зааг байхгүй. Ангилал зөвхөн толгой дотор чинь байдаг. Амьдрал бол зэрлэг ой, ургуулж торддог цэцэрлэг биш /х 171/. Ахуй бодлыг чинь дагахгүй. Харин чи ахуйг дагахаас аргагүйд хүрэхэд ягшмал ухааны бүтэц хөзрийн байшин шиг нурна. Ахуйн өчүүхэн салхинд ордон чинь замхарна. Бүхэл бол эсрэг тэсрэгийн нэгдэл төдийхэн биш, түүнээс ч үлэмж. Энэ бол зүрхний дээд тоо. Тиймдээ ч хайрын хүн та нарын нүдэнд галзуу мэт харагдана. Учир нь та нар толгойгоороо үйлддэг бол тэр зүрхээрээ үйлддэг. Тэрээр амьдралтай зүрхээрээ нэгдсэн. Юу ч тохиолдсон зөв гэж мэдэрнэ. Дахиж тэр амьдралтай дайтахгүй, оршихуйд зүгээр л итгэж зөнгөөрөө урсана. Үхэл дотор хүртэл инээж, дуулж, баясах болно. Үхэл хүртэл түүнд Бурханд золгох үүд болно. Тэрээр хуваагдал үгүй нэгэн бүхлээр амьдрах болохоор жинхэнэ эрүүл хүн. Ердийн байдлаараа чи нэг хүн биш үй олон бодгаль. Дотор чинь олон хүн бужигнаж жолоо атгахын төлөө, хаан болохын төлөө тэмцэлдэнэ /Эртний сайхан аялгуу, АГ 15, х 172-173/. Сэтгэл оюунууд гэж олон тоогоор илэрхийлвэл зохино. Гагцхүү зүрх нэгэн бүхэл. Зүрхэндээ ойртох хирээр олон зан чинь сарниж нэгэн чанар тодорно. Зүрхэнд амлалт хэрэггүй. Толгойд төвлөрсөн солио, зүрхэнд төвлөрсөн солиог Баруунд ангилж чадахгүй. Зүрхэнд төвлөрсөн солиотон бол угтаа эрүүл хүн, Бурханы хүн /х 174/.

Амьдрал чинь бүхэлдээ номын мөр болоогүй цагт номлол бүхэн худал. Үйлдэл бүр чинь үнэний илгээлт болоогүй цагт, чи өөрөө номын биелэл болоогүй цагт юм бүхэн хуурмаг /Эртний сайхан аялгуу, АГ 15, х 112/.

Жинхэнэ хүүхдүүд байна. Бас идэр залуу, өтөл буурай боловч нялхас байна. Хүүхэд гэдгийг нас биеийн хэмжүүрээр бүү ойлго. Хотэй шиг хүн чихэр тараангаа хэлнэ: “Хорвоогийн амьдралд уялдан зууралдаад яах вэ. Энэ бол тоглоом наадам төдий. Өнгөт ертөнцөд хэт битгий авт. Чихэр шиг амсаад л хана. Өөрийгээ мартан донтвол чи үүрд балчраараа үлдэнэ. Чихэрт шим тэжээл үгүй шиг үзэгдээд өнгөрөх зуурдын хорвоод үнэн үгүй шүү” /Эртний сайхан аялгуу, АГ 15, х112/.

Амьдрал гэж боддог зүйл чинь зуурдын тоглоом, зүүдний явдал төдийхэн болохоор үхэн хатан зууралдаж, үнэнд тооцон мунхаглах хэрэггүй /АГ 15, х 113/.

Шавь Ошо Богдоос асуужээ: “Амьдрал надад маш уйтгартай санагдаж байна. Юу хийвэл дээр вэ?”. Ошо богд: “Чи дэндүү ихийг хийчихсэн байна. Амьдрал хэмээх энэхүү тансаг бүжиг цэнгүүнийг уй гунигт урвуулжээ. Мунхаглал бол ажиггүй, хайхрамжгүйн утга. Чи шувуудыг, моддыг, цэцэгсийг, хүмүүсийг хайхардаггүй юмсанж. Түүнээс биш харж л чадвал амьдрал бол зогсолтгүй инээж баясмаар наадам. Гаднаа биш ч дотроо чи инээж хөхөрсөөр явахсанж. Амьдрал уйтгартай биш, оюун ухаан л уйтгартай. Чи буруу орон зайд, буруу үзэл бодол дунд амьдарч байна. Мэдлэг амьдралыг хүртэхүйн саад. Мэдлэгээ хойш тавь. Хоосон тунгалаг нүдээр харах юм бол амьдрал үргэлжийн сюрприз. Би хаа нэгтээх диваажин яриагүй. Энгийн амьдрал өөрөө ер бус. Хүүхэд уйлах, нохой хуцах, тогос бүжих... аар саархнаас ч Бурханы оршихуйг нээж болно. Гэвч мэдлэгийн хөлхөнд бүрхэгдсэн учраас чи түүнийг харж чадахгүй байна. Оюун ухаанаар амьдардаг хүн хамгийн ядуу хүн. Оюун ухаанаас хальж сэтгэлийн хаалга цонхоо нээсэн хүн ертөнц дээрх хамгийн баян хүн. Өнгөрсөнтэй зууралдаж, мэдлэгт уягдаж, ой санамж оюун ухаандаа хашигдсанаас энд-одоог алдаж байгаа юм. *Эргээд хүүхэд бол! Энэ бол бясалгалын утга учир: Эргээд хүүхэд болох, үл мэдэгч болох, цагаан цайлган болох. Тийм учраас Багш: “Мэдэхгүй нь хамгийн ойрхон” гэж хэлдэг*”. Эгогоос ангижир, оюун ухаанаас гэтэл, гэхдээ арш нар оюун ухааныг огт хэрэглэж болохгүй гэсэн утгаар бус түүнд уягдахаа больсон үед л түүнийг зүй ёсоор, илүү чадварлаг ашиглаж чадахыг онцолдог /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 20- 23/. Ачаа болгож үүрэхгүй л бол амьдрал өмнө чинь нээлттэй /тэнд, х 49/. Христийг, Буддаг ч бүү дага, гагцхүү амьдралыг л дага /тэнд, х 52/.

Хэв загварт орсон амьдралын үйл бүхэн буруу. Саньяасин /огоорогч/ гэсэн хэв загвар ч байх ёсгүй. Дурын хэлбэрт орж чадах ус шиг байвал зохино. Ямарваа хэв загварт баригдалгүй, сул чөлөөтэй байж тухайн нөхцөлдөө зохир. Орчин үргэлж өөрчлөгдөж байдаг. Гадагшаа чиглэх хэрэг гарвал гадагшаа чиглэ. Дотогшоо орох боломжтой үедээ дотогшоо уус. Ийм уян хатан чанар бол саньяас юм. Тэрээр урсгал сөрөхгүй. Ийм тийм байх ёстой гэсэн үзэл загварчлал үгүй. Энэ бол жинхэнэ сахил – зарчим. Зарчим чамайг чөлөөлнө /тэнд, х 72/. Үзэх: *Оюун ухаан, Эго.*

### **АМГАЛАН АЖИРСАН**

*Амгалан ажирсан гэдэг нь нөгөө эрэгт хүрсэн гэсэн үг. Өөр утга нь үнэмлэхүй бясалгалд хүрэх 8 үе шатын 8 –д хүрсэн нэгэн. Түүнчилэн ирсэн /Татхагата/-тэй утга нэг /Ошо Очир огтлогч, х 15/.*

### **АМЬСГАЛ**

Гэгээрлийг ойлгоё гэвэл илүү ихийг авахын тулд өгөх ёстойг сана. Амьсгалаа илүү их гарга, энэ бол хөрөнгө хуваалцах, хөрөнгө өгөх юм /Ошо Зэн – Гэгээрэхүйн бясалгал, х 41/.

### **АРГА, БИЛИГ**

*Үзэх: Барамид 7. Арганд мэргэн*

Бурхан Багш: “Бурханы төгс бэлгэ билиг нь буяны чуулган, аргын мөр лүгээ шүтэн барилдаж бүтдэг. Иймд бодисадва зөвхөн хоосон чанарт шүтэх учиргүй. Өглөг буян тэргүүтэн арга талд ч дулдуйдах учиртай. Майдар аа! Бодьсадва 6 барамидийг бүтээх нь төгс төгөлдөр гэгээрлийн төлөө юм. Би бодьсадын замаар явах үедээ 6 барамид төгөлдөр буяны үйлийг бүтээж явлаа. Бурханы аугаа үйлсийг арга, билиг хосолж байж бүтээнэ.” /АГ 11, х 139/. Бодисадва арга, билгийг хэрхэн бүтээх вэ хэмээх асуултанд Бурхан Багш: “Бодисадва амьтан бүрийг харахдаа нигүүлсэнгүйн амьсгалыг мэдэрч, түүнд орших нь арга юм. Амирлах хийгээд улам амирлахуйд уусан бясалгах нь билиг юм. Бодисадва арга ухаанаар буяны ном бүхнийг хураана. Билиг ухаанаар би-үгүй, бодгаль үгүй хоосон чанарт нэвтэрнэАрга ухаанаар хамаг амьтанд гэгээрлийг түгээнэБилиг ухаанаар жолоодсон аргад шүтэх хэрэгтэй /АГ 11, х 141/.

Бага хөлгөн бол их нигүүсэл үгүй аргын хувьд төгөлдөр бус зам. Тиймээс бага хөлөгтөн гагцхүү амирлах хязгаарт уягддаг. Харин бодьсадын арга зам, билиг төгөлдөр тул 2 хязгаарт үл орших төгс гэгээрэлд хүрдэг юм. Тэрээр билгийн хүчээр орчлонд үл автах ба аргын хүчээр амирлангуйн хязгаарт үл унана. Бага хөлөгтөн шиг туйлшрах ёсгүй. Бодьсадва нар нирваан чанарыг онох боловч түүнийг зорилго болгохгүй. Учир нь нирваанд уягдвал бодь хутгаас няцсан хэрэг гэж үзнэ. Гагцхүү аргад дулдуйдвал бодьсадва эгэл ертөнцийн хүлээсэнд үлдэх болно. Иймд билиг ухаанаар жолоодсон аргад шүтэх хэрэгтэй /АГ 11, х 140/.

Будда: “Хамгийг болгоогч бурханы билиг бол нигүүслийн үндсээс ургадаг. Бодь сэтгэлийн угаас төрдөг. Мэргэн аргад дулдуйдан эцэс чинадад хүрдэг юм” /АГ 11, х 143/.

## ***АРДЧИЛАЛ***

*Үзэх: Огоорол*

Хүнийг өөр хэн нэгэнтэй адил болгох гэдэг үнэхээр фашист үзэл. Эсрэг хүйстнүүд бусдын ижил хүйстэн байхыг зөвшөөрөхгүй гэнэ. Бусдын амьдралыг шийдэх эрхийг хэн та нарт өгсөн юм бэ. Жинхэнэ ардчилал бол хувь хүний амьдралыг олонх цагдахгүй байхын нэр. Ардчилал бол хувь хүний гэхээсээ илүү шашинлаг үзэгдэл юм. Энэ бол амьдралыг харах шинэ зөн хараа. Хэрэвзээ бусдад төвөг дарамт болохгүй л бол хүн амьдралын бүх талбарт эрх чөлөөтэй, өөрийнхээрээ байх эрхтэй. Үүнийг л ардчилал гэнэ. Бусдад заяагдсан өгөгдлийг хүндэлж явах хэрэгтэй /АГ 15, Эртний сайхан аялгуу, х 179/.

## ***АРХАД***

*Хэн нэгэн эс болох тэрхүү ухамсрыг Архад гэнэ /Ошо Очир огтлогч, х 63/. Архад бол хэн нэгэн байхаа больж, би-үгүй хоосон чанар болсон гэгээрэл /тэнд, х 60/.*

## ***АСУУДАЛ***

*Үзэх: Сэтгэл*

## ***АХУЙ***

Барууны терминологи ахуйг хүлээн зөвшөөрөхөд үндэслэдэг. Буддынх ахуйг үгүйсгэхэд үндэслэдэг /Ошо Богдын тайлбар, П.Бадралын орчуулга, Чинадын чинадад, х 33/.

## ***АЯЛГУУ***

Ошо: Би мянган бээрийн тэртээх үүлсийг харж, нарс модны дотроос эгшиглэх эртний сайхан аялгууг сонсож чадна. Энэ бол Ум буюу Аумкар буюу үнэмлэхүй аялгуу. Анахата буюу цохилтгүй анир, үүсгэл үгүй дуун. Тэрхүү аялгуу чиний дотор ч, гадна ч түгээстэй. **Чи түүнээс үүдсэн.** Физикчид бүх юм эрчмээс үүссэн гэдэг бол арш нар анираас бүх юм үүссэн гэдэг. Физикт анир ч гэсэн эрчим. **Анирдахаас өөр хийх юм чамд үгүй. Анирдахуй бол бүх бясалгалын утга** /Эртний сайхан аялгуу, АГ 15, х 157/. **Ум-ын эгшиглэнг анирдаагүй цагт чи үнэнийг таних боломжгүй. Тэр бол оршихуйн зүрхэн лугшилт, Бурханы сүмд орох үүд хаалга** / АГ 15, х 157/. Аялгуу та хоёрын дунд бодлын хана л саад болдог. Хэдий тийм ч аялгуу чам руу нэвтэрсээр л байдаг. Тэр чиний бүхий л оршихуйг элбэн энхрийлж, тэтгэн тэжээсээр байгаа. Зүрх чинь бүхлийн зүрхтэй нэгэн хэмээр лугшиж буй. Бүхлийн хэмнэлээс зүрх чинь гажих үед чи зовж шаналж өвддөг. Бүхэлтэй нэгэн айзамд байхдаа эрүүл саруул, амар амгалан байдаг / АГ 15, х 158/. Тийм учраас тэрхүү аугаа тэнгэрлиг найрлаас бүү алдуур. “Бурхан бол хайр” гэдгийн утга тэр мөн. Хайрлах юм бол түүнийг хүртэнэ /х 159/.

Эртний сайхан аялгууг анирдахын тулд өөрөө алга болсийм шиг нам гүм болох ёстой. Орших, эс оршихын зааг арилахад чамайг аялгуу хүрээлнэ. Тэр бол Оршихуйн зүрхэн лугшилт, Бурханы сүмд орох үүд юм /АГ 15, Эртний сайхан аялгуу, эхний хуудас /.

## **БАГШ**

Үзэх: Зэн

**Багш бол Бурханы тухай мэдлэгтэн биш, Бурханыг зүгээр л мэддэг хүн.** Багш бол тойргийн хүрэнээс төв рүү хийх үсрэлтийн туршлага, бас гэрч юм. Тиймээс Багшид үлэмжийн их итгэл хайр, нээлттэй зүрхээр хандах учиртай. Багш өөрийгээ танихад чинь тусалдаг. Тэрээр чамд Вед, Куран, Библи өгөхгүй, зүгээр л өөр рүү чинь шидчихнэ. Өөрийн дотоод эх сурвалж, бурхан чанараас ундаалахыг ойлгуулна. Тэрээр чамайг судар номоос чөлөөлж, бусдын тайлбараас ангижруулдаг. Мухар сүсэг, сохор таамгаас гэтэлгэдэг. Үзэл суртал, философ, шашин, теологоос салгадаг. Товчдоо, тэрээр чамайг үгийн ертөнцөөс чөлөөлж өгдөг. Учир нь үг бол садаа. Хайр гэдэг үгтэй зууралдвал хайрын амсуурыг мартдаг. Бурхан гэдэг үгэнд уягдсанаас Бурхан бол нэр томъёо биш Оршихуй гэдгийг огоордог. Багш та нарыг үгээс чөлөөлж аниргүмийн төлөвт аваачина /АГ 14, Ай даа энэ шүү дээ!, х 10/.

Их Багш Дайэ: “Богд мэргэдийн сургаал та нарыг ‘Ай даа, энэ шүү дээ’ гэж дуу алдахад хүргэх тэр зүйлийг л тайлдаг. Агшин зуур арилан гийж, бие, сэтгэл, сүнс бүхэлдээ цаглашгүй баяр хөөрөөр бялхах мөчид ‘Ай даа, энэ л байж! Аллэллүяа!’ гэж чи өөрийн эрхгүй дуу алдана /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 7/. ‘Ай даа, наадах чинь шүү дээ!’ гэж Багш л гэрчилдэг. **Багшийн үйлс гэрэл түсгаснаар эхэлж, гэрчилснээр өндөрлөдөг. Багш гэрчилдэг болохоос баталдаггүй. Энэ ялгааг бясалга. Бурханыг гэрчлэхээс өөр батлах, үгүйсгэх боломжгүй. Бурхан бол онол таамаг биш, илт үзэх буюу амсүүрга юм** /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 8/.

Багш нарын зам мөр үнэхээр ер бус. Багш бол нууцлаг гайхамшиг: Тэрээр хорвоод амьдрах мөртөө хорвоод харъяалагддаггүй. Бие дотор амьдрах мөртөө бие цогц биш. Оюун ухааныг ашиглах мөртөө оюун ухаан биш. Цаг хугацаанд амьдрах мөртөө цаггүй мөнхөд хамаарах. Та нар шиг өлсөхдөө хооллож, цангахдаа ундаалж, ядрахдаа унтах мөртөө дотоод гүндээ тэс өөр орон зайд сэлдэг. Гаднаа амьдрал нь жирийн хүнтэй адил харагдавч дотроо төрөл, үхлээс хэтийдсэн байдаг /АГ 14, Ай даа энэ шүү дээ!, х 41/.

## **БАГШ, ШАВЬ**

Үзэх: Багш

Багшийг ойлгохын тулд дотно элгэмсэл хэрэгтэй. Нөхөрлөл чинхүү хайр болж хувирахад Багш, шавийн хооронд ан гав үлдэхгүй. Тэд нэгэн хэмнэлд орж, амь нэгтэй лугших болно. Жинхэнэ ойлголцол энд бий. Хүлээс бүхнийг тайлж, хүртэхүйн хязгаараас давсан тийм сэхээрэл. Багшийн нүд рүү харах, үгийг нь сонсох, үйл хөдөлгөн – дохио зангааг нь чи хараад л оюун ухааны орчуулгагүйгээр ойлгоно /АГ 15, х 29/. Эхний шат: оюутан /үзэгч -мэдлэг хураагч/, 2 дахь шат: шавь /үзэгчээс оролцогч болж мэдлэгээс мэдэхүйг чухалчилна. 3 дахь шат: **өөрийгээ Багшид өргөл болгосон хайртан. Хоёргүй нэгдэлд орж, Багшийн шавхагдашгүй эх булгаас ундаалж, бурханлигаар хөлчүүрэгч.**

## **БАРАМИД**

Ошо Богдын тайлбар /АГ, Нирваан/:

### **1. Өглөг барамид**

Ердийн сэтгэл бол харамч зантай. Юу л байна өмчилж зууралддаг авиртай. Ийм сэтгэлтэй бол эндэх болно. Харамч сэтгэл бол хаагдмал сэтгэл. Энэ эрэгт байхдаа аль болох өгөхөд суралц. Буй бүхнээ бусадтай хуваалц. Аливааг өмчлөх нь оршихуйд тэрсэлж буй гэмт хэрэг. Түүнийг ашиглаж болно, өмчилж болохгүй. Будда юу өгөхийг хэлээгүй. Юу өгөх нь сонин биш. Гол нь бусадтай хуваалцах нь чухал. Дуу, бүжгээ хуваалцаж болно. Астрал хайр, бясалгал, туршлага, эд мөнгө, орон байр, хоол, хувцас, бие цогцсообусдад зориулж болно. Өглөг үйлдэх нь чухал. Нөгөө эрэг рүү элбэрэл хайр, энэрэл нигүүслээс өөр юм авч явж чадахгүй. Ертөнц бол чиний тусгал. Өгөөмөр байвал чинь ертөнц бас өгөөмөр, харамч бол ертөнц бас тэгэж хандана. Будда: “Оршихуйд итгэвэл чинь оршихуй чамд итгэнэ. Юуг ч өмчлөхөө больсон цагт л үнэний замаар явж чадна”.

Буян номыг ч өмчилж болохгүй. Иймд бясалгалын амгаланд нэвтрэх аваас тэр даруй бусдад өглөг болгон түгээ гэж Будда захидаг. Дэргэд чинь хэн ч байхгүй байсан нүдээ аниад гэгээн жаргаланг бүх ертөнцөд цацраах хэрэгтэй.

Бясалгал, гэгээрэлд ч өмчлөгч байж болохгүй.

Будда хөршөөсөө бусдад л буясалгалын анхилгаа түгээх гэсэн шавьд: “Хэн нэгнийг гадуурхвал яаж хамаг амьтан, хотол ертөнцөд түгээх билээ. Өс хонзонгоос болоод чи хөршдөө адис буянаа түгээж чадахгүй байна. Үнэн хайр өш хонзонг мэдэхгүй. Эхлээд хөршийнхээ дээрээс буяны хураа буулга. Тэгсэн цагт өргөлийг чинь хотол ертөнц хүлээн авна. Хөршдөө элгэмсүү хандсан цагт л ертөнц чамд элгэмсүү хандана” /Нирваан, х 41/.

Будда: “Бясалгалаа түгээхгүй бол алдана. Бясалгалын төлөвт хүрсэн даруйдаа хуваалцах хэрэгтэй” /Нирваан, х 42/. Хэрэв түүнийг түгээж чадахгүй байгаа бол жинхэнэ бясалгалд хүрээгүйн шинж. Бясалгал гэж эндүүрсэн хуурмаг төлөвт хүрсэн аж. Учир нь бясалгагч төлвийн мөн чанар нь хуваалцах буюу түгээхүй юм. Бясалгал чинь нигүүсэл болж цацрахгүй л бол чи буруу зүгт явж байна. Өглөг бол чинадын эрэгт хүрэх замд хөсөг болох эрхэм чанар /Нирваан, х 42/.

Хайр л байхад хагалттай. Ямар ч асуудал үүсэхгүй. Хайр асуудал гээч юмыг мэдэхгүй.

Өөрийгээ танъя гэвэл өмчирхлийн үндсийг таслах хэрэгтэй. Будда: “Үхэлд баригдахаас өмнө өглөг болгон тараа” /Нирваан, х 43/. Хэн нэгэнтэй хуваалцаж байгаа чинь Бурхантай хуваалцаж байгаа хэрэг. Буй бүхэнд Бурхан чанар бий. Мод услахад модон доторх цангасан Бурхан баярлана. Хүн, амьтан, мод, ургамалд хийж байгаа чинь оршихуйд хийж байгаа зүйл. Хүн өгөхийн хэлийг мартсан /Нирваан, х 44/.

Өөртөө буй бүхнийг өглөг буянд зориул. Гэхдээ цоорхой сав шиг байж болохгүй. Цоорхой байх, өглөгч байх хоёр ялгаатай. Цоорхой үедээ чи зүгээр л алддаг. Хүртэх юм юу ч үгүй.

Харин өглөг үйлдэх үедээ чи эглийг өгөх ялдамд эгэлгүй дээдийг хүртдэг. Алдах юм юу ч үгүй /Нирваан, х 48/.

## 2. *Сахил*

Гүн утга нь зохицол төгөлдөр амьдрахуй. Ямар амьдрал зохицол төгөлдөр байж чадах вэ? Гагцхүү хайрын амьдрал, нигүүслийн амьдрал, талархлын амьдрал, бусдад анхаарал халамж тавьдаг хариуцлагатай амьдрал л тийм байж чадна. Хүчлэн дуурайх бус дотоод амьдрал л ингэж өөрчлөгдвөл гадаад ахуй түүнийг дагалдана. Зах хүрээг хүчилснээр төвд нөлөөлөхгүй. Амаа хамхилаа гээд чимээгүй болохгүй. Дотроо чимээгүй амгалан бол гаднаа мөн тийм байна. Энэ бол эрэлчний ойлгох амин чухал аньс юм шүү. Будда: “Жинхэнэ сахил дотоод ухаарлаас үүснэ” /Нирваан, х 44-45/.

## 3. *Хүлцэл тэвчээр*

Алсын их аянд адгуу загнаж болохгүй. Адгаж яарваас хэзээ ч чинадын эрэгт хүрэхгүй. Цаггүй аялалд цаглашгүй хүлцэл хэрэгтэй. Адгуу сэтгэл чангарч чивчирдэг. Сэтгэлээ суллаж тайван хүлээцтэй бай. Хир хүлцэнгүй байхаас цаг хугацаа хамаардаг. Хүлцэлгүй зангаа бүрмөсөн хаяж, агшин хоромдоо бүрэн дүүрэн оршоод байвал нэг л өдөр түүнийг нээнэ. Тэр үргэлж дэргэд чинь байгаа. Гагцхүү адгаж яарч, үсчин хийссэндээ л харахгүй байгаа юм. Гүн гүнзгий тайвширч, анир чимээгүй суухдаа гэв гэнэт сэрэхвий. Өрөө чинь түүгээр дүүрч, бүх ертөнц Бурханаар халгихыг харна /Нирваан, х 45/.

## 4. *Эрч хүч, зориг самбаа /Хичээл*

Амьдралын эрчим хүчийг бүү дэмий үр. Хязгааргүй эрчим заяавч цоорхой сав шиг явдгаас тогтоож чаддаггүй. Нам жим байж л тогтоох сав болно.

Будда бясалгалаа Зиан гэдэг байсан нь дияан гэсэн санскрит хэлний пали хувилбар. Уг үгнээс хятадын Чан, японы Зэн үүсжээ. Зэнгийнхэн: “Бясалгал бол юу ч хийхгүй зүгээр суухын нэр” гэдэг Бодь модны дор гэгээрэх үедээ Будда юу ч хийгээгүй. Нам гүм зүгээр суухад энерги алдагдах цоорхой үгүй болж, эрчим хүч хуралдан өгссөөр оройн хүрдэнд хүрдэг. Оргилд хүрсэн эрчмийн тэсрэлтээр цэцэг цомирлигоо нээдэг. Будда ийнхүү дэлгэмэл бадамлянхуа болжээ /Нирваан, х 47/. Бэлгийн энергийг суллах хэрэггүй, суллавал чи хосон хоцорно. Хурмал энерги дээш ахисаар оршихуйн оргилд хүрдэг. Энэ бол самадийн утга юм /Нирваан, х 47/.

Эрчим хүч хуримтлуул гэдэг нь харамч зан биш /Нирваан, х 45/.

## 5. *Дияан /Бясалгал*

Дуугүй суух, зүгээр байхуй. Анир чимээгүй суугаад амьдралын урсгалыг ажигла. Мод, одыг халиа. Эсвэл хамрын үзүүр, хүйсэндээ чиглэ. Нүдээ аниад зүгээр л дотоод байгалиа тольд. Юмс урсаж л байг, чи зүгээр л халиаж суу. Будда: “Орь ганцаар чинадад хүрэх аялалд онцгой эрдэм бол нам гүм суухуй”. Хоосон сэтгэл бол Бурханы төвхөн. Хоосон байх юм бол чөтгөр чам руу шургалж чадахгүй. Бодол арилахад гадна тал ч арилж чи цэвэр дотоод ахуй болдог. Үнэн бол субъектив чанар гэсний учир энэ /Нирваан, х 49/.

## 6. *Билиг ухаан*

Мэдлэг бол туршлагад харгаздаггүй, билиг туршлага дээр үндэслэдэг. Зөвхөн өөрийн амсаж хүртсэнд дулдуйд. Ганцаар үлдэх үед гаднаас ирсэн, бусдаас авсан бүхэн гээгдэж, гагцхүү чиний юм чамт ай үлдэнэ. Будда: “Аппо дийпо Бхава – өөрөө өөртөө гэрэл бол”. Билиг бол чиний өөрийн туршлага. Өөрийн гэрэл л үнэнч түшиг. Бясалгалаар олдсон ахуй ойлголтыг орхих аргагүй. Тэр чиний өмч биш, оршихуйн чинь хувь хэсэг. Оршихуй болж хувирсан туршлага /ахуй ойлголт/-ыг билиг гэдэг /Нирваан, х 51/.

## 7. *Арганд мэргэн*

Аливаа арга хэрэгслийг уяа хүлээс болголгүй ашиглаж сур.

Будда: “Голыг гатлаад завиа орхи”. Бясалгал, сахил гм арга хэрэгслийг ашиглах үедээ ашиглаад орхих ёстойгазар нь сэтгэл хоргодолгүй орхи.

Будда: “Бүх арга хэрэгслийг дасал болохгүйгээр ашиглаж, цаг нь болохоор орхи” /Нирваан, х 50/.

**8. Бууж өгөхүй**

Эхлээд чадах бүхнээ хийх ёстой. Дараа нь идэвх зүтгэл бүхнээ орхиж алдрах ёстой. Энэ алдрал дунд үнэнтэй учирна. Бүрэн төгс бууж өгсөн цагт Үнэн өөрөө морилно /Нирваан, х 52/.

**9. Эрх хүч**

Бууж өгсний дараа эрх хүч бүрдэнэ. Ялгааг хар. 4 дэхийг эрч хүч гэсэн. 9 дэх бол ердийн эрч хүч бишер бусын эрх хүч. Эгогоо орхиж бууж өгсөн хойно гэв гэнэт далдын нууцлаг эрчмээр дүүрнэ. Хүний бус Бурханы хүчээр халгина /Нирваан, х 53/.

**10. Төгс ухамсар буюу бэлгэ билиг /билиг билгүүн/**

Юмсын мөн чанарыг харахуй. Бурханлиг эрчим, бүхэл оршихуйн хүчийг хүртсэнээр бүх зүйлийн утгыг ойлгож, мөн чанарыг тольдоно. Энэ бол Нирваан юм.

**БИ**

Би гэдэг үгийг Будда нар ч хэрэглэдэг. Чингэхдээ би-д уягдаж, бодит ахуйгаас алдууралгүйгээр үг төдий хэрэглэдэг /Ошо Очир огтлогч, х 76/. Хүслээс салаагүй хүн бодлоос салахгүй. Будда: “Хүсэл бол зулын тос” /Ошо Очир огтлогч, х 90/. Сэтгэлийг ноцоож буй тос нь хүсэл юм /тэнд, х 89/. Дөлтэй тэмцэлгүйгээр зүгээр л түүнд шатахуун юүлэхээ зогсоо /тэнд, х 89/. Сэтгэлийг илбэ ховс гэж харах учиртай /тэнд, х 90/. Будда шиг хүмүүс орчлон ертөнцийг бодит бус гэж ярьдаг. Тэдний үгийг чи буруу ойлгодог. Тэд сав шим ертөнцийг бодит бус гэж хэлээгүй. Гагцхүү чиний бодит ахуй биш боддог сэтгэлийн ертөнц чинь бодит бус гэдгийг хэлдэг /тэнд, х 92/. Сэтгэлийн бүрхүүлээс салсан цагт бүх юм бодит болно. Чи Түүнчилэн чанар дотор амьдрах болно /тэнд/.

**БИ ҮЗЭЛ**

Үзэх: Эго, Би хэн бэ?

Хэрвээ чи сүнсэнд итгэдэг бол энэ ертөнцийг огоорсон ч диваажинг хүсэмжлэх нь гарцаагүй. Би-гээс ангижраагүй болохоор хүсэл шунал цувирсаар. Би-г баримтлах нь мөнх бусыг мөнхөд эндүүрэх мунхаглал /АГ 13, Нирваан, х 139/. Арьс биеийг чинь ертөнцөөс зааглаж байна. Арьснаас дотогш чи, гадагш ертөнц байна. Арьсгүй бол чи орчин тойрноосоо ялгарч чадахаа байна. Гэхдээ арьс чи биш. Эго сэтгэлийг чинь хэв загварт хашиж агуулдаг. Түүнгүйгээр чи өөрийгээ, бас бусдыг ялгаж чадахаа байна. Гэхдээ чи өөрөө эго биш /АГ 13, Нирваан, х 130-131/.

“Минийх” гэсэн үзэл бол үндсэн хор юм /Ошо Зам мөр, жам ёс, х 114/. Бодит ахуйд минийх гэх үзэл огт байхгүй. Минийх гэнгүүт амьдрал чинь бүхэлдээ өрсөл тэмцэл, тэгээд зовлон болж хувирна. Чиний өмч – чиний хүрээ. Эндээс юмыг ангилж ялгаж эхэлнэ. Ертөнц нэгэн бүхэл. Бүх юм өөр хоорондоо шүтэн барилдаж оршдог. “Би тугаар” гэх бүр чи үхмэл болдог. Дотор үндэслэсэн нэг л буруу үзлээс амьдралын бүх л хандлага буруу зүгт эргэдэг. “Би” гэгч нь өмчирхлийн хамгийн хатуу талсжсан хэлбэр. Би гэж хэлсэн даруй бодит ахуйгаас тасарч байгаа юм. Будда: “Урсгал аясаар бай” / Ошо Зам мөр, жам ёс, х 116/. Зүгээр л чимээгүй суу гэхийг зааж заалгаад байхаар юу байна. Тийм атал чаддаггүй. “Би” чинь суларч байж бясалгалд орж бодит ахуйг харна. Чиний жинхэнэ төв бол чинийх биш бүхлийн төв /х 117/. Гэвч бид зохиомол уйтан төвдөө төвлөрч амьдардаг. Өөрийгээ ажигла. 1 % нь ч чиний дотоодоос ургаагүй, зүгээр бусдын



санаа онооны цуглуулга. Бүддэ: “Төв дүнд зогс” / Ошо Зам мөр, жам ёс, х 122/. Хоёр туйл руу бүү савч, бүү туйлшир гэсэн үг /мөн тэнд/.

Өөрийгээ мэддэг гэж бодох нь балчрын шинж. Хурмал мэдлэг, тогтсон дүгнэлтээр хариу үйлдэл хийх нь балчрын шинж. Мэдлэг, дүгнэлтэнд хүлэгдэлгүй, тухайн орчин нөхцөлдөө зохирох /хариу үйлдэлгүй байх нь Г.Л/ эрийн цээнд хүрсний шинж. Өчигдрийн мэдлэгээр өнөөдөртэй нүүр тулаад байвал хэзээ ч амьдлог байж чадахгүй. Учир нь амьдрал бол агшин зуур ч давтагдахгүй урсгал. Хэдийчинээ хэвшмэл мэдлэгээр үйлдэнэ, төдийчинээ балчир түүхий болно. Хүүхэд юу ч мэдэхгүй, ямар ч дадал зуршилгүйгээр энд-одоод зохирч үйлддэг. Хүүхэд 8 нас хүрэхдээ насан турш сурах зүйлийнхээ бараг 70%-ийг сурсан байдаг /АГ 15, Эртний сайхан аялгуу, П.Бадралын орчуулга, 2016/.

Эго хоосон чанарт амьдарч чадахгүй. Эго бол тогтмол эд юмс биш эрчлээс юм. Эрчилж зангирах тусам тэлж томорно. Тэмцэл тулаан л түүнд хэрэгтэй. Эгод асуудал хэрэгтэй. Үүнийг л сэхээрчих юм бол сэхээрлийн агаарт уулс эргээд дов болж, дов жижгэрсээр нэг мэдэхэд эргэн тойрон цэвэр хоосон чанар хүрээлнэ. Гэгээрэл гэж үүнийг л хэлдэг. Асуудал гээч юм огт байхгүйг гүнзгий ухамсарла. Шийдэх асуудалгүй болмогц зүгээр л амьдарч эхэлнэ. Идэж, унтаж, хайрлаж, дуулж бүжиглэнэ. Өөр юу хийх билээ дээ. Чи Бурхан болж жинхэнэ ёсоор амьдрах болно. Хэрэв Бурхан байдаг бол түүнд нэг л зүйл тодорхой: Түүнд ямар ч асуудал байхгүй. Бурхан юу хийдэг вэ? Зүгээр л уярч хайлж, амьдралаар халгиж цалгих. Энэ агшиндаа амьдраад үз. Ингэж амьдрахын хирээр асуудал замхрахыг харна. Хоосон чанар аясаараа дэлгэрнэ. Хэрэв хүмүүс арай ахиу дуулж бүжиж, инээж баясагсан бол эрчим хүч нь ундарч, элдэв зовлон төвөг нь аяндаа сарнихсан. Тиймээс би маш их бүжиглэхийг шаарддаг. Бүжиг чинь тавирал хайлан болох учиртай. Бүх эрчим хүч чинь бүжиг болон хувираг. Гэнэт чи толгойгүй болсноо мэдэрнэ. Толгой тархинд түгжигдсэн энерги зүг бүрд халгиж, уран сайхан дүр зураг, үйл хөдөлгөөнийг урлана. Бие цогц чинь хатуу ягшмал юм байхаа больж уясч хайлна. Хил хязгаар замхарч сансар ертөнцөд уусч нэгдэнэ. Бүжигчин бол дүр хэлбэрийн хүрээнээс хальж энергийн үзэгдэл болж хувирдаг. Урсаж хайлах тусам амьдлаг, жавхаалаг болно. Амраглах, бүжиглэх, идэх, унтах үйл бүхнийг аль болох төгс үйлд /АГ 15, Эртний сайхан аялгуу, П.Бадралын орчуулга, 2016, х 28-29 /.

## **БИЕ МАХБОД**

Бие махбодь бол чиний оршихуйн үндэс суурь. Бие махбоддоо дайсагнаж хандвал амьдрал чинь там болж хувирна. Юуны өмнө чи бол бие махбодь. Бие махбодиос халин гарах боломжтой ч энэ бол дараа болох зүйл. Одоох бодит байдлаа ухаар. Бие махбодид дайсагнах нь Бурханд дайсагнасан хэрэг. Биеэсээ холбоо таслах нь бодит ахуйгаас холбоо тасалсан хэрэг. Бие бол чиний гүүр, чиний сүм. Гүн хүндэтгэл чин бишрэлтэйгээр түүнд хандагтун. Бие махбодь шиг уран нарийн адбиш нууцлаг юм юу байна вэ? Уул ус ургамал цэцэг нар сарыг бахдан бишрэх мөртлөө юунд өөрийн бие махбодийг бахдан биширдэггүй юм бэ? Биеэс чинь уран гоо ургамал цэцэг байхгүй. Биеэс илүү гайхамшигтай гараг эрхэс байхгүй. Хамгийн ойр дотно хамгийн чухал нандин тэр зүйлээ хайхраагүй хүн өөр юуг үнэлж хайрлаж чадах юм бэ?

Эхлээд өөртөө үнэнхүү дурлаж байж л хүнийг дурлуулж чадна. Өөртөө таалагдаж байж л өрөөлд таалагдана. Хувь мөн чанараа сэрж мэдэрч биширч дээдэлсэн хайраас бусад бүх хайр үүсдэг. Царай муутай шувуу царай муутай гөрөөс байдаг бил үү? Тэд ямар ч гоо сайхны засал хийдэггүй мөртлөө хэзээд цог жавхлантай харагддаг юм. Өөрсдийгөө байгаагаар нь хүлээн зөвшөөрсөн болохоор тэр.

Өөрийгөө хүлээн авсан тэр л агшинд чи үзэсгэлэн гоо болно. Бие цогцдоо сэтгэл хангалуун талархалтай хандаж гэмээ нь бусад хүн чамд тэгэж хандана. Хэн нэгний араас гүйх хэрэггүй.

Өөрөөсөө зугтах гэж оролддог хүмүүс бусдын араас хөөцөлдөж явдаг. Хүмүүс өөрсдөө чам дээр ирэг. Өөртөө чинхүү дурласан цагт өөр хүн чамд дурлахгүй байхын аргагүй болно /Гантрын дуудлага номоос/.

## **БИЛИГ УХААН**

Үзэх: Барамид 6. →Билиг ухаан, Зэн

### **БИ ХЭН БЭ?**

Би хэн бэ? Бол угтаа асуулт биш. Учир нь үүнд хариулт байхгүй. Үүнийг тарни шиг хэрэглэдэг. Энэ бол өдөөлт болохоос асуулт биш. Ямарваа хариулт хүлээхгүйгээр “Би хэн бэ?” гэж үргэлж дотроо лавла. Оюун ухаан үй түмэн хариулт хэлнэ: “Чи бол амьдралын зүрх, мөнхийн сүнс. Би бол Бурхан” гм хөврөхвий. Тэр бүхнийг бүү тоо. “Неги нети” – энэ ч биш, тэр ч биш гэж хариулт бүрийг няцаах ёстой. Оюуны сэтгэх боломжит бүх хариултыг няцааж чадвал ид шид биелнэ. Хариултгүй асуулт гэв гэнэт өөрөө арилна. Асуулт арилсан цагт чи түүнийг ойлгоно. Энэхүү ойлгохуй нь хийсвэр хариулт бус бодит туршлага байна. Тэр тухай юу ч ярих боломжгүй, ярьсан бүхэн буруу болно. Энэ бол үгээр илэрхийлж, үзгээр зуршгүй нууц. Би хэн бэ? Асуулт доторх Би-д ямар ч утга байхгүй. Энэ бол чамайг зүгээр л үл мэдэхүйн зүг, оюун ухааны чинад руу хөтлөх арга зэмсэг. Оюун бодлын үндэс бүрийг энэ илдээр цавчихад оюуны бус амгалан хоосон л үлдэнэ. Тэрхүү аниргүмийн дотор асуулт ч үгүй, хариулт ч үгүй. Зэнгийнхэн үүнийг коан гэдэг. Үгээр илэрхийлэх аргагүй учир олон арш дуугүй байсан. Миний жинхэнэ дүр хэн бэ? Хүүхэд, залуу, хөгшин хөвөө, эрүүл, өвчтэй, жаргасан, зовсон олон дүр хөвөрнө. Тэр бүгдийг няцааж чадвал эцэст нь гагц хоосон чанар үлдэнэ *Хоосон чанар бол жинхэнэ дүр. Тэг бол үнэмлэхүй туршлага* /АГ 14, Ай даа, Энэ л шүү дээ, х 20/. “Нэг гараар алга таших” чимээг анирд гэж Багш хэлнэ. Шавь түмэн хариулт олно. Багш хэлүүлэлгүй гөвшиж орхино. Тэгээд хэлнэ: “Хариулттай л ирсэн бол буруу гэсэн үг. Үнэхээр олсон бол чи энд ирэхгүй. Би өөрөө чам дээр очих байсан” гэж зандарна /тэнд, х 21/. Бүх хариулт замхарсны баттай тэмдэг нь асуулт өөрөө замхрах. Тэр үед Багш: “Ээ дээ, энэ л шүү дээ. Асуулт ч үгүй, хариулт ч үгүй” гэнэ /Тэнд, х 21-22/.

### **БОДИДАРМА**

Бодидарма бол билиг танхайн оргил билээ. Тэрээр хятадын хаантай уулзахдаа нэг гутлаа хөлдөө углаад нөгөөг нь толгой дээрээ тавьсан байж. Тэрээр хаантай хоёулхнаа үлдсэн хойноо: “Энэ бол зөвхөн эхлэл. Би шавь нараа бэлдэх хэрэгтэй. Хэрэв та энэ эрс тэсийг хүлээн зөвшөөрч чадахгүй бол намайг ойлгох чадваргүй юм байна. Гутал бол зүгээр л бэлгэ тэмдэг. Чухамдаа би толгойгоороо хөл хийх гэсэн юм” гэж хэлсэн гэдэг. Гайхамшигт үзэгдэл ийнхүү эхэлжээ. Бодидармаа хятадад Зэнгийн үрийг суулгасан эцэг нь болохоор Зэн үеийн үед түүний өвөрмөц чанарыг тээж ирсэн. Зэн бол хамгийн этгээд эрс тэс шашин. Логикоос хэтийдсэн болохоор тэр /АГ 15, Эртний сайхан аялгуу, П.Бадралын орчуулга, 2016, х 264/. Бодидарма хүн мөртөө арслан байв. Барагтай дуугарахгүй. Түүний дуугүй байдал нь аюун сүрдмээр. Хэрэвзээ ярих юм бол аянга буух шиг болно. Зургаас нь асар догшин төрхийн цаана аялаг зөөлөн тэмтрэгдэнэ. Арслан, тоть хоёрын эрлийз мэт. Зэн ёс ийм эрс тэс чанарыг өвөрлөжээ. Зэн мастерууд гаднаа хахир хатуу мөртлөө дотроо элгэмсүү зөөлөн. Тэрээр хятадаас буцахын өмнө шадар шавь нараа шалгаж “Үнэн” гэж юу вэ асуултыг тэдэнд тавьжээ. Дофуку: “Миний бодлоор Үнэн бол үгүйсгэх, батлах хоёроос хэтийдсэн утга. Түүнд л хүрэхийн төлөө замнах ёстой”. Хариулт буруу биш ч гүн ухаанлаг байна. Энэ нь түүний бодит туршлагаас ургаагүй аж. “Миний бодлоор...” гэжээ. Үнэн бол үзэл бодол бүхнээс ангид. Үнэний тухай юу гэж бодох чинь огт хамаагүй. Чухамдаа бодож байгаа учраас л

үнэнийг таних завдалгүй. Бүх бодол зогсож үзэл арилсан цагт үнэн тодорно. Бодидарма: “Чамд миний арьс байна” гэжээ. Хариулт зүгээр нэг цэцэрхэл байсан бол ийм өндрөөр үнэлэхгүй. Хариултын цаана зэрвэс гялбаа байж. Тэр л дотоод хараа нь хариултын гоо сайхныг тодруулжээ. “Үнэн бол үгүйсгэх, батлах хоёроос хэтийдсэн утга”. Бурхан байдаг гэвэл эд юмстай адил болно. Гэтэл Бурханд байхгүй болох тохиол бий гэж үү? Баталж чадахгүй болохоороо үгүйсгэдэг. Байхгүй бол байхгүй л биз. Эсэргүүцэхийн цаана сэтгэл л бий. Бурхан батлах, үгүйсгэх оюунд баригдашгүй уудам / АГ 15, х 166/. Түүнийг Бодидармагийн хэлдгээр Үнэн гэж дуудъя. **Үнэн бол Оршихуй хийгээд Эс оршихуйг хамтад нь агуулдаг. Оршихуй дангаараа байх боломжгүй.** Өдөрт шөнө, амьдралд үхэл хэрэгтэй шиг. Дофуку энэ санааг илэрхийлжээ. Зөв замдаа байгаа ч гүн ухаанч хэвээр. Тиймээс “Чамд миний арьс байна” гэжээ. Арьс хамгийн гадна бүрхүүл. Агшин хормоор гуужин өөрчлөгдөх тул чиний мөн чанар биш. Сожи гэлэнмээ: “Миний үзэхэд энэ нь Анандын дотоод мэлмийд тодорсон Буддагийн дагшин орон мэт. Нэгэнтээ харсан цагт үүрд хоногшино” / АГ 15, х 168/. Бодидарма: “Чамд миний цус байна” гэжээ. Гэлэнмаа арьснаас цааш гүн явжээ. Учир нь энэ бол гүн ухаанч байр суурь биш. Туршлагад илүү дөхүү хариулт. Гэхдээ уг туршлага нь хуулмал юмсанж. Анандын туршлага. Үнэн бол Анандын үзсэн Буддагийн гэгээн орон мэт. Нэг л удаа нэвтрэх юм бол хэзээ ч түүнээс алдуурахгүй. Нэг л удаа харах юм бол хэзээ ч түүнийг мартажгүй. Эхний хариултанд эргэцүүлэл, энд бодрол давамгайлжээ. Дойку: “Шороо, ус, гал, хий 4 махбод хоосон. 5 цогцос ч бодгүй. **Бодгүй хоосон чанарыг л би үнэмлэхүй гэж үзнэм**” / АГ 15, х 169/. Бодидарма: “Чамд миний яс байна” гэжээ. Дойку лавширсаар, гэхдээ хараахан хүрээгүй байна. **Илэрхийлэл үнэн боловч илэрхийлэл учраас мөчид юм.** Хатуу, шингэн, хий, гэрлийн төлөв цөм хоосон чанартай. Тэдэн дотор ямарваа тусгай бод /субстанц/ үгүй. Ертөнц бүхэлдээ зүүд мэт илбийн үзэгдэл. Бодгүй хоосон чанар л үнэмлэхүй. **Түүний зөв. Гэвч тэр үгээр илэрхийлшгүйг илэрхийлэх гэж оролджээ.** Витгенштейн: “Өгүүлшгүй зүйл дээр дуугүй байсан нь дээр”. Үнэхээр өгүүлэх аргагүй бол юу ч гэж хэлсэн ч үнэнээс урвах болно. Эка Багшийнхаа хөлд мөргөөд чимээгүй суужээ. Бодидарма: “Чамд миний чөмөг байна” гэжээ / АГ 15, х 169/. Эка Багшийн өмнө мөргөл үйлджээ. Энэ нь түүний илэрхийлэл байв. Гүн баяр талархлын дохио. Тэгээд тэр чимээгүй суужээ. Хариулт биш хариулт л жинхэнэ хариулт. **Үнэнийг чимээгүйгээр л илэрхийлж чадна. Учир нь үнэнийг чимээгүйгээр л хүртдэг юм.** Эка 2 зүйл хийсэн: өвдөг сөгдөн мөргөсөн нь гүн хайр, хүндлэл, талархлын дохио. Тэр агшинд Бодидарма өлмийд нь арилсан хоосон чанар мөргөж буйг харсан нь лавтай. Экагийн дотор хэн нэгэн байгаагүй. Зүгээр л тунгалаг хоосон байжээ. Тэрээр 3 дахь шавийн хэлсэн хоосон чанарын амьд биелэл байжээ. Түүнчлэн хоёр дахь шавийн хэлсэн Анандын дотоод арилсан үзэгдлийн амсуур түүнд байв. Бас эхний шавийн гүн ухаанчаар илэрхийлсэн тийм, үгүй хоёроос хэтийдсэн нэгэн байлаа. **Зөвхөн чимээгүй нь үгүйсгэл, баталгаанаас ангид. Чимээгүй нь жинхэнэ ариун ном ёс билээ** / АГ 15, х 169/. Тэр чимээгүйн ариуныг харуулж мөргөл үйлдээд нам жим суужээ. **Өөрөөр илэрхийлэх аргагүй. Тийм учир Бодидарма: “Чамд миний чөмөг байна” гэжээ. Оршихуйн төвд хүрчээ.** Эка шиг гүн талархал, нам гүмд орш. Дотоод чанад руугаа эргэх хэрэгтэй. Хамгийн агуу гайхамшиг юу юэ гэсэн асуултанд Будда: “Параврути – Дотогшоогоо эргэх” гэжээ / АГ 15, х 170/.

## **БОДИТ АХУЙ**

Үзэх: Би

## **БОДОЛ**

Үзэх: Бясалгал, Оюун санаа, Сэтгэл

Бодол замхарвал бүх юм тодорхой болно. Бодлоос тусдаа бодогч гэж байхгүй. Алхаж байхад алхаа л байна, алхагч байхгүй. Унтах үед нойр л байна, нойрсогч байхгүй. Амьдрахуйд амьдрал л байна,

амьдрагч байхгүй. Үхэхүйд үхэл л байна, үхэгч байхгүй. Чи өөрөө бол цэвэр хоосон орон зай юм. Буддаг Түүнчилэн ирсэн, одсон гэдэг. Энэ бол ирэх, одохын үйл явц бий, ирэгч, одогч хэн нэгэн үгүй гэсэн үг. Гэтэлсэн нэгэн угтаа байхгүй, гэтлэхүй л байна /АГ 13, Нирваан, х 137/. Бодол арилахад гадна тал ч арилж чи цэвэр дотоод ахуй болдог. Үнэн бол субъектив чанар гэсний учир энэ /Нирваан, х 49/.

Бодол-үгүйд орох олон арга бий: дөлөнд төвлөрөх, хар цэг дээр, тарнид төвлөрөх гм. Гэхдээ бодлоос ангижирч нойрмог будангүйд автах эрсдэлтэй. Бодлоос ангид өөр 2 төлөв бий: нойр ба самади – сатори. Бодол замхарсан хойно нойронд автаж болох, эсвэл сэрүүн тунгалаг саторид орших. Инээдний сайхан нь нойронд үл автахад оршино /Эртний сайхан аялгуу, АГ 15, х 108/.

Зэн хүмүүс өдрийг инээдээр эхэлнэ. Өдрийг инээдээр угтаж, инээдээр үд /х 110/.

Бодолд автах нь үнэнээс алдуурч одох зам. Олон жил бодлоо гээд чи худал хуурмагийг үнэнд хувиргаж чадахгүй. Бас үнэнийг худал хуурмагт хувиргаж чадахгүй. Чимээгүй байх гэдэг нь ямарваа идэвхийлэ үгүй, зүгээр л нээлтэй энд-одоо-д байхын нэр. Үнэнийг анирдах үед дотроос чинь хариу зохирол үүснэ. Чиний бүхэл чанараас үүсэх зохирол. Үгээр илэрхийлшгүй аниргүйн аяз. Аялдах, сөргөхөөс ангид чимээгүй байхуйн урлагийг Дорно дахинд зуун зуунаар мэддэг. Барууны ертөнц ийм харьцаанд боловсорч амжаагүй /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 71/.

### ***БОДЬ МӨРӨӨР ЗАМНАГЧ***

Бурхан Багш: “Эцэг эхээ огоорч, орон гэрээ орхиж, өрийн сэтгэлийг таньж, хуран эс үүдсэнд нэвтрэгч хүнийг бодь мөрөөр замнагч /шрамана/ хэмээнэ” /Зам мөр, жам ёс, х 2/.

Бурхан Багш бээр айлдсан нь: “Би хэмээгч байгаа нь бидний бодлын үр дүн юм. Бодол бол бүх юмс мөн”. Тэрээр сэтгэлийг задлан шинжилснээр бодол арилсан төвшинд хүрч хоосон чанарыг нээжээ. Тэрээр хоосон чанарыг хуран эс үүдсэн гэжээ. Сүнслиг гэхийн оронд зүгээр л хуран эс үүдсэн хэмээжээ /Зам мөр..., х 14/. Бодол бол дотоод матери буюу хуран үүссэн зүйл. Бодлын манан замхрахад үлдэх хоосон орон бол хуран эс үүдсэн зүйл.

Бурхан Багш бээр сэтгэлээ танигчийн 4 төвшинг тодорхойлжээ.

Архад бол арилсан сэтгэлийн дээд төвшин. Өөрийн дотор үүрлэсэн дайсан болох харам шунал, үзэн ядалт, үймрэл бухимдлаа дарсан хэрэг. Сэтгэлээс тусдаа дайсан гэж үгүй, сэтгэлээ ялсан хүнийг архад гэж Бурхан Багш нэрлэжээ.

Хоёрдогч төвшинг эргэлт буцалтгүй одогч хэмээжээ. Тэрхүү нэгэн энэ төрлийн эцэст чөлөөлөгдөж архадын төвшинд хүрэх юм. Түүнд ялимгүй жаахан уяас буюу биетэйгээ барьцалдах сэжим үлдсэн. Гэвч нөхцөх үед энэ сэжим тасарч нирваанд уусна.

Гурав дахь нь эргэн ирэгч. Энэ ертөнцөд дахин нэг удаа төрөл авна. Түүний шуналын бүдүүн хэлбэрүүд /эд мөнгө, эрх мэдэл, нэр төрийн шунал/ арилсан ч нарийн хүсэл /гэтлэх, гэгээрэх хүсэл, амар амгаланг эгээрэх нарийн хүсэл/ оршоор байх юм.

Дөрөв дэх нь урсгалд орогч. Тэрээр 7 төрлийн эцэст архадын хутгийг олно. Гараа тайруулсан хүн дахин түүнийг хэрэглэхгүй, нүдээ ухуулсан хүн ахин түүгээр харахгүй мэт хүсэл шуналаас бүрмөсөн гэтэл гэж Бурхан Багш айлджээ /Зам мөр, х 16/.

Бурхан Багш: Сэтгэлийн ариуслыг дагалдаж Бурханы орон ариусмүй /Д.Болдбаатар, Дияан, х 78/.

Бурхан Багш айлдсан нь: Бодь хутаг /гэгээрэл/ ямар бол сэтгэл тийм. Сэтгэл ямар бол сэтгэгдэхүүн тэр мэт. Сэтгэгдэхүүн ямар мэт өнгөрсөн, одоо, ирээдүйн хамаг ном /юмс/ тийм.

Хамаг номыг таньсан сэтгэлийг бодь сэтгэл гэнэ. Бодисадва гэх алдар тэндээс төрнө. Үнэмлэхүй агаарт бодисадва ч, бодь сэтгэл ч эс оршино /АГ 1, х 159/.

Эндээс үзвэл үймрэл үгүй, бодол үгүй, хүсэл үгүй арилсан сэтгэл бол бодь мөр юм. Сэтгэлийн давалгаа арилсан ухамсарт л нэгдмэл үнэн оршино. Сэтгэлийн давалгаа үгүй бол хүн бээр цэвэр тунгалаг ухамсар л байна. Ирээдүй рүү үсчихгүй энэ агшиндаа орших үед сэтгэл арилдаг гэж гэгээрэгсэд номложээ. **Иймээс Бурхан Баги бээр: “Энд, одоо цагтаа ори. Агшин хоромтой хамт үрс”** хэмээжээ. Яг одоох агшнаас урагшаа ч хоосон, хойшоо ч хоосон. Өнгөрсөн ч үгүй, ирээдүй ч үгүй. Эхлэл нь хоосон бол төгсгөл нь хоосон, хоёр хоосны дунд аливаа юмс оршиж чадах билүү, тийм боломж үгүй.

Будда: “Гэргүй бядагч шрамана бүхий л холбоосоос өөрийгээ чөлөөлж / Зам мөр, жам ёс, х 28/ ...

*Холбоо барилдлага угтаа байхгүйг ухаарна гэсэн үг / Зам мөр, жам ёс, х 24/. Чиний ганцаар байхуй бол өнө мөнхийн. Ганцаар байхуйдаа орших нь уяа холбоосоос ангижрахын утга. Хорвоогоос зугтах хэрэггүй. Зүгээр л уягдах сэтгэлээс ангижир / Зам мөр, жам ёс, х 24/.*

- ✓ сэтгэлийн үндсийг ухаарч, Буддагийн гүн сургаалд нэвтэрч, ...

Буддагийн хамгийн гүн сургаал нь би-үгүй анатта. Эхлээд энэ илбийн хорвоод төвхнөх хэрэггүй, удаа нь уяа холбоос бүрээс өөрийгээ чөлөөл, эцэст нь зүрхэн сургаал: дотогшоогоо өнгийж би-үгүйг ухаар гэжээ / Зам мөр, жам ёс, х 25/.

- ✓ хуран эс үүдсэн номыг таньдаг /тэнд, х 28/.

*Үнэмлэхүй ном ёс буюу дарма оршин буй гэж Будда хэлдэг /х 27/. Үнэмлэхүйг эзэн бие биш, хууль жам гэж Будда үздэг / Зам мөр, жам ёс, х 28/.*

- ✓ Түүний зүрхэнд мухар сүжиг, сохор таамаг үгүй. Тэрээр юуны ч хойноос үл хөөцөлдөнө. Тэр үзэл бодолд автахгүй / Зам мөр, жам ёс, х 28/.

*Хаа нэгтээх бурхан тэнгэр, бумбын орныг хүсч, шашин ном, үзэл сурталд автахгүй. Үнэхээр ухаарсан хүн зам мөрийн тухай бодолд ч автахгүй гэж Будда хэлжээ /х 30/. Зорилго байж л зам байна. Зорилго бол ирээдүй. Энэ л агшиндаа бай. Энэ агшиндаа энгүүн тайван байвал бүх оршихуй чам руу юүлэгдэнэ / Зам мөр, жам ёс, х 30/.*

- ✓ Үйлийн үрд орооцолдохгүй /х 28/.

*Жам ёсыг ухаарсан хүний дотор ахуй, гадаад үйл хоёр нэгддэг. Ажил үйл нь хүчлэл бус зохирол байна. Үймрэл бус таашаал байна. Үр дүн горилохгүй, хийж байгаадаа л ханаж баясана /х 30/.*

- ✓ Ёс дүрэм, сахил санваарт баригдахгүй / Зам мөр, жам ёс, х 28/.

*Ухаарсан хүмүүнд ёс дүрэм шаардлагагүй. Ухаарал нь өөрөө сахил юм. Ухаарсан хүн буруу юм хийхгүй. Хаалгыг мэдсэн л бол хаалгаар гарна. Хаалгыг мэдсээр байж хана мөргөөд байхгүй. Үйлдэл л мэдлэгийг чинь харуулдаг. Ухаарч ойлгосон бол сахил дүрэм хэрэггүй гэж Будда хэлжээ.*

- ✓ Зэрэг дэс хийгээд гэгээрэлд уягдахгүй. Гагцхүү зам мөр, жам ёсыг итгэл төгс даган одох.

*Үнэн хэрэгтээ үе шат үгүй гэж Будда хэлдэг. Үе шат, эрэмбэ зэрэг бүхэн нь эгогийн заль. Өөрийгээ хөгжиж, бусдаас дээд дэсэд хүрч байгаа мэтээр сэтгэж, илүү өндөрт гарахын шуналасах нь эгөд л шим тэжээл болно. Зэрэг дэсэд уягдсан дэмийрлээс сал. Хүн гэгээрсэн, гэгээрээгүйн аль нэг л байна. Амьд үхсэн хоёр шиг. Дунд нь байх боломжгүй. Унтах сэрэхтэй л адил. Чамайг унтаж байхад дэргэдэх хүн чинь сэрүүн байж. Хүн гэдэг талаасаа бол ялгаагүй, харин унтаа, сэрүүн хоёр эрс ялгаатай. Нэг нь түнэр харанхуйд, нөгөө нь ухамсрын гэгээнд байна. Сэрүүн хүн юу хийж буйгаа бүрэн ухамсарлаж зохиролт үйл үйлдэнэ. Унтаж буй нь хариу*

үзүүлэвч юу хийж буйгаа мэдэхгүй механик үйлдэл хийнэ. Унтах, сэрэхийн хооронд зэрэг дэс үгүй Сэрсэн бол сэрсэн, сэрээгүй бол сэрээгүй / Зам мөр, жам ёс, х 32/.

Гагцхүү зам мөр, жам ёсыг итгэл төгс даган одох.

Оршихуйд бүрэн төгс бууж өгвөөс бүх зүйл зөнгөөрөө учирч эхэлнэ. Голд итгэвэл хөвнө, эргэлзвэл живнэ. Амьгүй цогц усны мандалд хөвдөг. Эргэлзэхгүй болсонд учир бий. Амьдрал ч үүнтэй адил. Буддист бус хуучин шашны хэлээр үүнийг “Бурханд бууж өгөх” гэдэг.

**Будда: “Шунал даслын эрхээр ухаан будангуйрдаг учир юуг ч битгий давт”** / Зам мөр, жам ёс, х 33/.

Амьдрал угаасаа баталгаагүй. Бүх баталгааг чинь үхэл ирээд товроглох болно. Тийм учир баталгаа хайж чөлөө учралыг үрэх хэрэггүй. Юу ч үгүй хоосон гуйранч болсон амар амгалан, аз жаргалтай гуйранч бай. Амьдрал баталгаагүйг ойлгож, хүлээн зөвшөөрч чадах юм бол энэ ухаарал хүлцэл чинь жинхэнэ сахиус баталгаа болно /х 33/. **Сэхээ сэрэмжээ алдахаасаа өмнө орчин нөхцлөө сольж сэлгээж бай. Энэнгишхээсээ өмнө шинэ байрнаасаа яв гэж Будда хэлдэг /х 34/. Дасал дадлын хүлээсэнд өөрийгээ бүү оруул.**

## **БОДЬСАДВА**

Үзэх: Арга билиг

## **БОДЬ ХУТАГ**

Бүхэлд уусан алдрах нь бодь хутаг. Тэр цагт чи өөрөө амьдрал болно. Мэдлэг үгүй билиг, мэдэгч үгүй сэрэхүй л байна /АГ 14, Ай даа, энэ л шүү дээ, х 51/.

## **БУДДА**

Үзэх: Очир огтлогч

Шагжамуни Буддагийн дэлхий дээр хэлсэн сүүлчийн үг: “Өөрөө өөртөө гэрэл бол” /Гайхамшигт хүмүүстэй хийсэн ярилцлагууд, х 70/.

Гэтэлсэн нэгэн үгүй, гэтлэхүй л бий. Буддагийн энэ билиг маш оршихуйч бөгөөд түүн шиг чөлөөлөгч ертөнцөд үгүй /АГ 13, Нирваан, х 138/.

Буддагийн сургаал бол энэ ертөнцийнх ч биш, нөгөө ертөнцийн ч биш. Эгээрэл, огоорлын 2 туйлаас ангид.

Будда: “Зугаа цэнгэл, зүдгүүр бэрхийн алийг нь ч сонгох хэрэггүй. Аль нэгийг нь сонговол нөгөөтэй нь барьцалдана. Миний сургаал бол сонголтгүй ухамсар” /Нирваан, х 54/. Зугаа, зүдгүүрийн алийг нь ч сонгохгүй бол 2 талт зоос гараас чинь алдуурна. Хоёрдмол үзэгдэл замхрахад ард нь аниргүм, амар амгалан үлдэнэ. Жаргал таашаалыг эрж зовлонд ойчих нь жир хүний зам. Хорвоогийн амьдралаас зугтаж өөрийгээ чандалсны эцэст таашал эдлэх – огоорогчийн зам. Зовлон, таашаал нэг зоосны 2 тал. Нэгийг нь үзээд авсаны хойно нөгөө талыг нь үзэж таараа /Нирваан, х 53/. Хорвоогийн амьдралыг амсаж ханасан бол, зүүд зэрэглээ гэдгийг нь ойлгосон бол, энэ эргийн юунд ч сэтгэл үл хоргодон, эргэж харахгүйгээр чинадын зүг одохдоо бэлэн бол зүрх сэтгэл чинь зөв зам мөрд зохилджээ гэсэн үг. Тэр цагт гадна талын сахил дэглэм ч шаардлагагүй гэж Будда хэлжээ /Нирваан, х 54/. Нэгэнт эрийн цээнд хүрсэн бол чинадын зүг ганцаар явахад бэрхшээх зүйлгүй болно. Дуулж бүжиж, инээж баясаж явахаас биш дурамжхан царайлж, өөртэйгээ зөрчилдөж явахгүй.

Будда: “Бодь мөрөөр замнагч хүнд ачаатай гүн шаврыг түүчигч одос мэт байвал зохино. Тэрээр зөвхөн урагш тэмүүлж шавраас гартал үл амсхийнэ. Шавь нар минь, хилэнц шунал бол бохир балчгаас ч илүү. Гагцхүү зам мөрийг санах нэгэн үзүүрт сэтгэлээр уг балчгаас гэтэлж чадна” /Нирваан, х 55/.

Будда: “Эхлээд асар их хичээл /зүтгэл/, дараа нь агуу их буулт хэрэгтэй” /Нирваан, х 55/. Энэ бол Зэн багш нарын “чармайлтгүй чармайлт” гэсэн үгийн утга. Чармайлт, чармайлтгүй хоёрын гайхамшигт зохицол хэрэгтэй.

Будда: “Хийх ёстойгоо хийсний дараа л бууж өгөх хэрэгтэй”. Дайчин зүтгэл, бууж өгөхүйн шүтэн барилдлагаар чи гэртээ хүрнэ /Нирваан, х 55/.

Будда биднийг гадаад юмсаас чөлөөлж, дотоод сахилыг хүртээнэ /Нирваан, х 59/.

Дотоод дүрэм журмыг ч нарийн уяа хүлээс, далд боолчлол гэдгийг анзаарснаараа Будда цор ганц юм /Нирваан, х 59/. Сахил дэглэм бүгдээс хэтийдсэн үедээ л хүн цог жавхлан төгөлдөр болдог. Бусдаар цагдуулахгүй, өөрийгээ ч цагдахгүй. Тэрээр хоосон чанарын агаарт үйлдэнэ. Тийм үйлдэл хүчирхийлэл үгүй, зохирол төгс /Нирваан, х 59/. Хоосон чанарын үйлд сүр жавхлан, адис ивээл оршдог. Учир нь үйлдэгч бүрэн замхарсан байна.

Будда: “Ухамсар сэргэг байх юм бол өмнө чинь бүх ертөнц жижгэрнэ. Ухамсрын чинь эн уудам орчлонгоос халина. Сүнслиг ухамсраа харах юм бол хүн эгнэшгүй агуу. Бие цогцос чамайг агуулдаггүй, бие цогцсыг чи агуулдаг” /Нирваан, х 70/. Бясалгалын үед хил хязгаар ууршин сарнидгийн учир энэ. Эгнэшгүй агуу, цаглашгүй гэдэг нь Бурхан гэсэн үг.

Буддагийн сургаал үнэхээр эсрэг тэсрэг. Эхлээд үүнийг хий, түүнийг биелүүл гэдэг. Дараа нь гэнэт “Одоо юу ч битгий хий. Бүгдийг орхи. Оюуны хязгаарт чи хүрлээ. Энэ сүүлчийн зүүдийг ч орхи” гэнэ /Нирваан, х 74/.

Буддагийн хэлдгээр бие цогц бол бохироор дүүрсэн тулам. Тиймээс биетэйгээ ижилсвэл чи үнэ хүрэхгүй. Оюун ухаантайгаа ижилсвэл арай томорно. Гэхдээ л оюун ухаан мулгуу, явцуу. Сүнслиг ухамсартаа оршвоос хүн цаглашгүй /Нирваан, х 73/. Өөрийгээ тань гэж Буддагийн хэлдэг ийм учиртай. Ринзай: “Будда ном заасан мөртлөө нэг ч ном заагаагүй гэдэг. Төрсөн мөртлөө “энэ төрөлт бол үхэл, төрлөөс хэтийдсэн гэсэн. Газар дэлхий дээр алхаж байгаа мөртлөө дотоод гүндээ нэг ч үйл хийгээгүй, хүрд тойрог эргэвч гол бул шиг үл хөдлөгч учраас би түүнд тахил өргөлөө” /Нирваан, х 74/. Буддатай хамт байснаараа чи долгион барих боломжтой. Сатсанга-ийн үнэ цэн үүнд бий. Багштай хамт, гэгээрсэн нэгэнтэй хамт байхуй. Будда = цэвэр ухамсар; Хорвоогийн хүн = түүн дээр + зүүд /Нирваан, х 75/.

Буддагийн оргил илэрхийлэл: “Тэгш чанарын номыг би үнэмлэхүй үнэний суурь хэмээн санадаг” /Нирваан, х 76/. Аливаа юмс уг чанартаа ив ижил. Өнгөн талдаа л ялгаатай. Мод, чулуу, од, гараг, чи, бид... Адилгүй мөртөө нэгэн адил чанартай. Анги ялгаа бүхэн зүүд зэрэглээ. Тэр адил чанарыг физикчид эрчим буюу энерги гэнэ. Материалистууд матери, идеалистууд оюун санаа, егүзэрүүд сүнс /ухамсар/, харин уг түгээмэл ахуйг Будда хоосон чанар гэжээ /Нирваан, х 76/.

Аливаа юмс уг чанартаа ив ижил. Өнгөн талдаа л ялгаатай. Мод, чулуу, од, гараг, чи, бид... Адилгүй мөртөө нэгэн адил чанартай. Анги ялгаа бүхэн зүүд зэрэглээ. Тэр адил чанарыг физикчид эрчим буюу энерги гэнэ. Материалистууд матери, идеалистууд оюун санаа, егүзэрүүд сүнс /ухамсар/, харин уг түгээмэл ахуйг Будда хоосон чанар гэжээ /Нирваан, х 76/. Ямар нэг юм болох л юм бол хэлбэрт орж таарна. Алтаар хийсэн түмэн юмны цаана адилхан алт, адилхан оршихуй байна. Иймд Будда тэгш чанарыг үнэмлэхүй үнэний суурь гэжээ. Тэгш чанарт уусахад хэлбэрээс

ангигирна. Эхлээд чи махбодын хэлбэрийг орхино. Дүр төрхөө ч мартахвий. Гүн бясалгалын үед биеэ огоорно. Нүдээ аних үед хэлбэргүй болно. Сэтгэхүй бол бас нэгэн хэлбэр. Гүн рүү ороход сэтгэхүйн хэлбэр ч замхарна. Дотоод гүндээ чи бие ч биш, сэтгэхүй ч биш. Тэгээд юу юм бэ? Хоосон чанар. Чи ямар нэг юм биш, хэн нэгэн бодгаль биш, гагцхүү хотол оршихуй юм. Төрөл, үхлээс ангид өнө мөнхийн оршихуй. Бүх хэлбэр арилахад дотоод, гадаад гэсэн зааг ч арилна. Дотоод, гадаад нь бас л хэлбэр, энэ үгүй болоход хоёргүй ахуй – тэгш оршихуй л үлдэнэ. Бурхан гэдэг үгийн жинхэнэ утга энэ – хотол түгээмэл тэгш чанар /Нирваан, х 76/.

Хэлбэр нь адилгүй ч чинадын агаарт адил. Түүнийг танин мэдэхийг Нирваан гэдэг /Нирваан, х 76/.

Бясалгалаас хэтийдэхийн тулд бясалгалаар замнах ёстой. Тэгэхдээ юунд ч автаж болохгүй, юунд ч уягдаж болохгүй. Арга хэрэгсэл бүхэн шат, гол гатлах завь. Гаталсан бол орхи. Арга хэрэгсэлд бүү авт. Өвчин арилсан бол эмийг орхи. Бясалгал бол эм. Бүх аргыг, бүх судрыг хэзээ нэгэн цагт орхих огоорох ёстой. Энэ бол Буддагийн агуу чанар. Өөрийнх нь сургаалыг хүртэл огоорох ёстой. Үнэмлэхүй зорилго бол эрх чөлөө. Энэ бол сүм хийд, сургаал номлол, сахил дэг, үзэл онол, арга хэрэгслээс чөлөөлөгдөхийн нэр. Хэлбэр нь адилгүй ч чинадын агаарт адил. Түүнийг танин мэдэхийг Нирваан гэдэг /Нирваан, х 77/.

Буддагийн нэг нэр нь Татхагата – Түүнчилэн ирсэн, нөгөө нь Сугата –Амгалан морилсон. Усанд мөргүй, огторгуйд оромгүй одсон гэсэн үг /АГ 13, Нирваан, х 113/. Ор мөргүй арилсан цагт гэртээ хүрнэ. Оршихуйгаас өөр зам мөр байхгүй. Бүх зүйл нэгэнт заяамал. Чи гэрээсээ нэг ч алхам холдоогүй. Үргэлж эндээ байсаар ирсэн. Өөрийн мөн чанар Дао, Дарма – Бурхан чанарыг гэсэн нэг ч хүн байхгүй. Тиймээс хаа нэгтээ явах, замнах мөр байхгүй. Зөвхөн сэрэх хэрэгтэй. “Замгүй зам”, “орцгүй хаалга” гэж Зэнд оновчтой нэрлэсэн /АГ 13, Нирваан, х 113/.

Чи язгуур үндсээсээ өөрчлөгдөх ёстой. Хуучин үнэлэмж, ёс суртахуун, үзэл бодол бүхнээ таягдан хаях хэрэгтэй.

Орчин үеийн физикчид угтаа матери байхгүй гэж байна. Харваас биетэй, барьцтай ханыг нэвтэлж гарч чадахгүй. Тэгээд яагаад хоосон чанартай гэнэ вэ? Энэ бол асар хурдтай энергийн хуйлралаас үүдсэн илбийн үзэгдэл аж. Түүн дотор эгэл бөөмс маш хурдтай хөдөлж, уг хөдөлгөөн бодит эдийн илбийг бүтээх аж. Биет юмс үгүй, биегүй энерги л оршдог гэж шинжлэх ухаан нотолж байна. Тиймээс Буддаг би шинжлэх ухаанч гэдэг. Тэр бээр Бурхан, тэнгэрийн тухай ярьдаггүй, зүгээр л би-үгүй хоосон чанарыг ярьдаг. Дотоодод тань эзэн бие үгүй. Алхаж байхад чинь алхагч байхгүй, алхаа л тэнд бий гэж Будда хэлдэг /АГ 3, Нирваан, х 132/. Амьдрал юмсаас бус үйл явцаас бүтдэг гэж Будда хэлдэг. Үүл хуралдаж аянга цахихыг хэн хийгээд байна гэж асуухгүй. Энэ бол хэн нэгэн үйлдэгч үгүй зүгээр л үйл явц. 2 талт ойлголтыг бид үгээр бүтээдэг. Би алхаж байна, би бодож байна гм. Гэтэл алхагч үгүй алхаа, бодогч үгүй бодол л хөвөрнөм. Ойлгоё гэвэл бодол замхрах цэг хүртэл гүн бясалгах хэрэгтэй. Бодол замхрахад бодогч талийх болно. Бодлын хөврөлөөр л биежиж байсан хэрэг. Гол үнэхээр байна уу? Эсвэл урсах хөдөлгөөн үү? Хөдөлгөөнийг авчихвал гол тэнд үлдэх билүү? Тэгэхээр гол урсаж байгаа юм биш. Урсгалаас тусдаа гол гэж байхгүй. Урсахуй л өөрөө гол юм /АГ 13, Нирваан, х 133/. Бүх зүйл нэр үг биш үйл үг гэж Будда хэлдэг. Би өлслөө,идлээ, цадлаа нь зохиомол илэрхийлэл. Хэл хоёрдмолд суурилдаг. Бүх юмсыг үйлдэгч, үйлдэхүүн хоёрт хувааж орхидог. Хэл яриа бол бидний сэтгэхүйн тусгал гэдгийг сануулсан анхны шашин бол буддизм юм /АГ 13, Нирваан, х 133/. Бодогч сарнисан цагт би-гийн мэдрэмж байхгүй. Тэр ердөө л сүүдэр байсан хэрэг. Цэвэр хоосон орон зайд би үлдэх газаргүй. Будда тэр хоосныг “анатта” –би-үгүй гэж нэрийдсэн /АГ 13, Нирваан, х 134/. Будда: “Эсрэг тэсрэг байж магадгүй. Гэхдээ л ийм байна” гэдэг /АГ 13, Нирваан, х 134/. Будда бодит баримтаас бүлтдаггүй шинжлэх ухаанч юм. Хэрэв тэр шинжлэх ухаанч биш метафизикч байсан бол би-г бодит хэмээн



үзэж, дахин төрөлтийн онолоос татгалзахын аль нэгийг сонгох байсан. Орчин үеийн шинжлэх ухаанд яг ийм зүйл болжээ. 50 жилийн өмнө эрдэмтэд материйн гүн рүү нэвтрээд балмагджээ. Учир нь электрон бөөмс туйлын логикгүй авирлах ажээ. Тэдгээр бөөмсийг ямар захирч зандралтай биш. Тэд нэг болохоор бөөмс шиг, нөгөөтэйгүүр долгион шиг орчих ажээ. Бөөм, долгион хоёулаа байх нь цэг, шулуун нэг зэрэг болохтой адил. Энэ бол Эвклидийн теоремтэй харш явдал. Цэг шулуун биш, шулуун нь цэг биш, гэтэл ганц цэг атлаа шулуун шиг загнах аваас бүх геометр будлих болно. Гэтэл материйн гүнд яг ийм зүйл болдог аж. Ажиглах үед цэг байсан зүйл эгшин зуур шулуун болж хувирна. Хэрэв энэ явц алгуур байсан бол ойлгож болохсон. Үр нь мод болж ургах шиг учир шалтгаанлиг үзэгдэл гэж тооцно. Гэтэл ямар ч завсаргүй агшин дотор ийм зүйл болох нь учир шалтгаангүй явдал. Бүр нарийндаа агшны ч хувирал биш байх. Цаг хугацааны нэг агшинд 2 ажиглагч байхуйд нэг нь түүнийг цэг мэтээр харах, нөгөө нь шулуун мэтээр үзэх. Нэгнийх нь нүдэнд үл харагдах, нөгөөд нь мод харагдах. Байдал ийм байхад яах билээ. Эрдэмтэд олон янзаар оролдож үзжээ. Учир нь оюун ухаан өөрийн тогтсон таалал, хэв загварыг эвдэж, тэдгээр тэнэг бөөмст бууж өгнө гэдэг амар хэрэг биш. Бараг 20-30 жил үзэж таржээ. Эцэст нь тэд фактыг байгаагаар нь хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй болов. Квант физикийн онол ингэж үүсэн. Квант бол нэг талаасаа бөөм, нөгөөтэйгүүр долгион юм. Цэг, шулуун 2 зэрэг болохын нэр. Үүнийг юу гэж тайлбарлах вэ, дэндүү логикгүй юм биш үү гэхэд эрдэмтэд : “тийм ээ, логикгүй байж магад. Гэхдээ бид бодит ахуйг сонсох ёстой. Хэрвээ ахуй логикгүй байгаа бол бидний логикт л гажиг байна гэсэн үг. Бид логикоо өөрчилж болно, харин ахуйг өөрчилж чадахгүй шүү дээ” гэж хариулж байна /АГ 13, Нирваан, х 135/.

Буддаг энэ дэлхийд морилох үед ийм явдал болжээ. Тэрээр хүмүүсийн би буюу сүнс, бодгаль гэж боддог тэр ахуйн гүн цөмд нэвтэрсэн юм. Тэгээд мөн л гайхаж алмайрсан. Тэнд хэн нэгэн байсангүй. Тийм атал дахин төрөлт, хорвоогийн орчил байдаг. Хэрэв тэр шинжлэх ухаанч биш жирийн сэтгэгч байсан бол энэ фактыг огт ярихгүй байх байсан. Сонголт маш энгийн: Би үгүй учраас дахин төрөлт ч байхгүй гэж хэлнэ /АГ 13, Нирваан, х 135/. Сүнсэнд үл итгэгч аттейст, чарвака – тасархай үзэлтнүүд, үргэлж тэгэж хэлдэг байсан. Сүнс байхгүй юм чинь үхэхэд бүх юм дуусна. Хойд нас гэж байхгүй гэнэ. Энэ бол энгийн бөгөөд логиктой хандлага. Мөнхийг баримтлагч, сүнсэнд итгэгч тейст үзэлтнүүд: бие үхэвч сүнс үлдэнэ гэнэ. Сүнс – атма бол үхэшгүй мөнх. Энэ ч бас логиктой. Будда л логикгүй загнадаг. Яагаад гэвэл тэр бодит ахуйн эсрэг мугуйдалдаг нэгэн биш. Түүний хандлага нь: Ахуй бидэнд юу илэрхийлж байна, түүнийг сонсох ёстой. Би үзэл бодлоо түүнд хүчээр тулгаж болохгүй. Ахуйг захирах бид хэн билээ? Хэрэв факттай харшиж байгаа бол бидний хэл, сэтгэргүүд л буруу байна. Ахуйгаас нүүр буруулахын оронд түүнийгээ л өөрчилсөн нь дээр” гэнэ /АГ 13, Нирваан, х 135-136/. Тиймээс Будда энэ дэлхийн хамгийн абсурд сэтгэгч. Чамайг байхгүй гэх мөртөө дахин төрдөг гэх. Зүй утга энд байна уу? Гэвч Тэр: “Би өөрийн харснаа л хэлж байна. Хэрэв чи хармаар байвал бясалга. Дотоод гүндээ нэвтрэх аваас чи ч бас гайхах болно. Бодит үнэнийг танихын хирээр үг хэл чинь өөрчлөгдөнө” гэдэг. Будда хэл, сэтгэхүйн бүх хэв маягийг өөрчилжээ. Буддаг ойлгох боломж барагтаа байхгүй. Учир нь тэр та нарын ярьдаг хэлээр ярьдаггүй. Тэрээр цоо шинэ харааг дэлхий ертөнцөд авчирчээ/АГ 13, Нирваан, х 136/. Сүнсэнд үл итгэгч атейстууд, урд хойд насыг үгүйсгэгчид үеийн үед байсан. Маркс шинэ юм яриагүй. Махавир, Патанжали ч шинэ юм яриагүй. Учир нь сүнс хийгээд төрөл орчилд итгэгсэд хэзээнээс байсан. Будда л цоо шинэ, цэвэр тунгалаг зөн билгийг тунхагладаг. Төрөл орчил бий, гэхдээ сүнс үгүй гэж Тэр хэлдэг. Энэ бол квант үерэлт. Хэрэв чи орчин үеийн физикийн хэлийг ойлгодог бол Буддаг ойлгох боломжтой. Гейзенберг, Планк, Эйнштейн тэргүүтэн эрдэмтэд Буддатай зэрэгцээ шугамаар ярьдаг. Матери замхарч гагцхүү энерги л орших ажээ. Түүн дотор ямар ч бодот чанар – субстанц алга. Энэ бол Буддагийн өгүүлдэг би-үгүй хоосон чанартай агаар нэг юм /АГ 13, Нирваан, х 136/.

## **Эрх чөлөө, хоосон чанар**

**Буддагийн бүхий л номлолыг нэг үгээр илэрхийлж болдог. Тэр нь эрх чөлөө / АГ 13, Нирваан, х 61/. Энэ бол сургаалынх нь охь юм. Түүний сургаалд бурхан, диваажин, хайр огт ач холбогдолгүй. Зөвхөн эрх чөлөө л хамгийн гол байр эзэлдэг. Учир нь үнэ цэн бүхий зүйлс нь зөвхөн эрх чөлөөтэй орон зайд хүртээмжтэй болдог. Эрх чөлөөгүйгээр хайр, диваажин, бурхан байхгүй. Диваажин нь өөрөө эрх чөлөө юм. Эрх чөлөө гэж Будда аливаа хүсэл үгүй, дур хүсэлд автаагүй, шуналд баригдаагүй, хэрэгцээ шаардлага огт үгүй ухамсрыг оюун ухаан үгүй ухамсар, сэтгэхүй байхгүй төлвийг хэлдэг / АГ 13, Нирваан, х 62/. Энэ нь тэр чигээрээ хоосон төлөв бөгөөд хэрэвзээ ямар нэг юм байваас тэр нь эрх чөлөөнд саад болно. Иймд бүхэлдээ хоосон. Яагаад гэвэл бүх зүйл зайлуулагдсан тул хоосон нь асар их орон зай гэсэн үг /тэнд, х 63/. Хоосонд хил хязгаар гэж үгүй, агуу том, юунд ч баригдахгүй. Зөвхөн ийм газар л эрх чөлөө боломжтой. Буддагийн хоосон гэсэн үгэнд ямар ч сөрөг чанар байхгүй, харин бүр туйлын эерэг буюу дүүрэн гэснээс илүү эерэг. Тэр хоосон энгийн нэг хоосон зай биш, үл харагдагч ямар нэг юм тэнд бий. Гэрээсээ эд зүйлсийг зайлуулвал зай нь томорно. Энэ бол бясалгалын үйл явц. Бүхнийг зайлуулах, бүхнээс ангижирч ардаа орхих, юу ч үлдэхгүй, бүр та өөрөө ч байхгүй болох явдал юм / АГ 13, Нирваан, х 63/.**

## **Энэрэл нигүүсэл**

**Шагжамуни Будда бясалгахаасаа өмнө энэрэх нигүүсэх сэтгэлийг төлөвшүүлэх хэрэгтэйг зааснаар гэгээрэхэд бясалгахаас өөр юу ч хэрэггүй гэж үздэг өмнөх үзлийг өөрчилсөн. Энэ нь Түүний хамгийн агуу үйл мөн / АГ 13, Нирваан, х 64/. Эхлээд хайр, энэрэл нигүүсэл, нинжин сэтгэлээ хөгжүүлэх ёстой. Үүний цаана нэгэн далд ухаан оршдог. Зүрх сэтгэл нь энэрэл нигүүслээр дүүрсэн хүн гэгээрсэн тохиолд бясалгалаараа бусдад өөрийн хүрсэн оргилдоо хүрэхэд тусална. Ингэснээр Шагжамуни Будда гэгээрлийг бусдад үлгэр жишээч “халдвартай” үйл болгох боломжийг нээсэн юм /тэнд, х 64/. Гэвч нэгэнт зорьсон газраа хүрч хүслээ биелүүлж чадсан бол бусдын төлөө санаа тавин буцаж ирэх хэрэг юу вэ? Тэрээр түүхэнд анхалж гэгээрлийг хувиа хичээсэн үйл бус харин нийгэм, хүмүүсийн өмнө хүлээсэн хариуцлага болгосон юм / АГ 13, Нирваан, х 64/. Үүний тулд гэгээрэхээсээ өмнө энэрэл нигүүслийг төлөвшүүлэх ёстой. Гэгээрсний дараа сурах юм байдаггүй. Хэрэв хүн баяр хөөртөө нэгэнт ханасан бол энэрэх нигүүсэх ч тээр мэт санагддаг /тэнд, х 64/. Чухам үүний учир гэгээрсэн хэдэн зуун хүн байдаг ч тэдний хэдхэн нь Бурханы хүтгийг олдог / АГ 13, Нирваан, х 65/.**

**Будда зөвхөн өөрөө гэгээрээд зогсоогүй гэгээрсэн хувьсгалч юм / АГ 13, Нирваан, х 65/. Тэрээр шавь нартаа бясалгалаар мэдрэх баяр баясгалан, амар амгалан, буцлан хөөрөх баяр цэнгэлийг дотроо хадгалалгүйгээр бүх дэлхийд хайрла, санаа бүү зов, өгснийхээ хирээр авах болно гэж сургадаг. Бусдад өгөх, бусадтай хуваалцах үйл нь асар ач холбогдолтой. Өгөх нь танаас юу ч хорохгүй, харин ч эсрэгээр баяр цэнгэлийг тань улам ихэсгэдэг болохыг ойлгоорой. Харин энэрэл нигүүслийг мэдэрч байгаагүй хүн өгөх, хуваалцах агуу нууцыг мэддэггүй /тэнд, х 65/. Энэрэл нигүүсэл нь хүмүүсийн алдаа дутагдал, сул талуудыг хүлээн зөвшөөрч, тэдний бурхад шиг байж чадахгүйг ойлгох явдал юм / АГ 13, Нирваан, х 66/. Энэрэл нигүүсэл бол таны мөн чанар /тэнд, х 67/. Хариу нэхэлгүй, аливаа болзолгүй, мод, шувуу, ан амьтан, хүмүүс, бүхий л юмсыг энэрэн нигүүлсэж, өөрөө баясан цэнгэх болно / АГ 13, Нирваан, х 67/.**

**Будда бол төвлөрлийн хүн биш, сэрэхүйн хүн. Тэрээр ухамсраа уйтан болгох гэж хичээхгүй. Эсрэгээр оршихуйд бүрэн нээлттэй байхыг эрхэмлэдэг байсан. Нүдээ аниад орчин тойрноо анирд. Юуг ч бүү тээршаа. Тээршаах агшиндаа чи Бурханыг эсэргүүцэж буй /Эртний сайхан аялгуу, АГ 15, П.Бадралын орчуулга, УБ, 2016, Уялга үг/.**

Будда нууцлаг хүн байгаагүй, түүнээс өөр нууцлаг биш их багшийг хаанаас ч олохгүй. Есүс маш нууцлаг байсан. Лууз бүр ч нууцлаг байсан. Будда бол энгийн, ойлгомжтой, түүний эргэн тойронд ямар ч учир битүүлэг зүйл байхгүй. Буддагийн логик сэтгэлгээ маш төгс тул түүний логигоос цоорхой ч олж чадахгүй /Ошо Зэн буюу гэгээрлийн бясалгал, УБ, 2012, х 13/.

***Шагжамуни Будда шашны хамгийн чухал мөн чанарыг төлөөлдөг. Тэр бол бурханы шашны үндэслэгч бус, харин дэлхий дээрх тэс өөр маягийн шашныг эхлүүлсэн. Тэрээр шашингүй шүтлэгийг үндэслэгч бөгөөд шашныг бус шүтлэгийг дээдэлж, хүн төрөлхтний ухамсрын түүхэнд асар том өөрчлөлт оруулсан.*** Буддагаас өмнө шашин байсан боловч цэвэр ариун шүтлэг үгүй байлаа. ***Хараахан боловсорч гүйцээгүй байсан хүн өөрөө Бурхан Буддагийн ачаар нас бие гүйцсэн билээ.*** Бүхий л хүн төрөлхтний нас бие гүйцээгүй нь үнэн боловч ***Будда бидэнд зам зааж, хаалгагүйн хаалгыг нээж өглөө. Энэхүү гүн агуулгатай санааг ойлгоход хүн төрөлхтөнд цаг хугацаа хэрэгтэй. Хэн ч Буддагийн бүтээсэн буянт үйлийг түүн шиг хийж чадаагүй юм. Хэн ч түүний адил цэвэр ариун итгэлийг төлөөлж чадаагүй.*** Бусад шашин шүтлэгийг үндэслэгч, гэгээрсэн хувилгаад нар өөрсдийн дагалдагч нарынхаа итгэлийг олж, эвлэрэхийн тулд буулт хийж байсан бол ***Будда ямар ч буулт хийлгүй цэвэр байдлаа хадгалж чадсан. Түүнд хэн нэгний ухамсрын хэмжээ, ойлгох чадвар огт хамаагүй, зөвхөн бодит үнэн л чухал.*** Тэрээр сургаалаа айлдахдаа хэн нэгэн ойлгох болов уу, үгүй юу гэдэгт санаа зовдоггүй. Энэ нь нэг талаар хэцүү мэт боловч нөгөө талаасаа асар их нигүүсэх сэтгэлийг агуулдаг. Хүн бодит үнэнийг байгаагаар нь илэрхийлэх ёстой. Эвлэрэлдэн зөвшилцөж хүний ухамсрын төвшинд хүртэл буулт хийхэд бодит үнэний мөн чанар, сүнс сүлд гээгдэж, итгэл бишрэл нь мухар сүсэг, үхмэл бишрэл болон хувирдаг. ***Хэн нэгэн бодит үнэнийг хүмүүний ухамсрын төвшинд хүртэл бууруулж чадахгүй, харин ухамсрыг бодит үнэний төвшинд хүргэн өсгөж болно. Энэ бол Буддагийн агуу гавъяа билээ.***

***Шагжамуни Буддагийн сургаалд аливаа шахалт дарангуйлал, хий хоосон үзэл суртал байхгүй. Энэ бол шашин шүтлэгийн хувьд ер бусын, нэн ховор үзэгдэл.*** Бүхий л төрлийн ердийн сүсэг бишрэл нь гоёмсог үзэл суртал номлож, ихээр залхаан цээрлүүлдэг. Дарангуйлах, айлган сүрдүүлэх нь тэдгээр шашин шүтлэгийн гол зэмсэг, хэрэгсэл учир хүмүүсийг хувьсгахын оронд эрэмдэг зэрэмдэг болгодог. Хүнийг эрх чөлөөтэй болгохын оронд боолчилдог. Харин Бурханы шашинд шахалт дарангуйлал огт байхгүй. Хэрэвзээ дарангуйлагч лам таарвал тэр бээр Буддагийн сургаалыг огт ойлгоогүй хэрэг.

***Буддад үзэл суртал гэж байдаггүй.*** Бүх үзэл суртал бол сэтгэхүй, оюун ухаанаас үүсдэг тул Будда түүнийг номлодоггүй. Бүх үзэл суртал сэтгэхүйд бүтдэг учир хүнийг оюун ухааны чинадад хүргэж чадахгүй. Зөвхөн оюун ухаан, сэтгэхүйгээ нрмхотгож байж хийрхсэн үзэл суртлаас ангижирч болно. Туйлын төгс төгөлдөр байдлын тухай санаа нь хэзээ ямагт хурцадмал, түгшүүртэй байдал, зөрчил, мөргөлдөөнийг үүсгэдэг. Ийм учраас Буддагийн хувьд туйлын төгс төгөлдөр зүйл гэж үгүй. Эдгээр нь хүмүүсийг хооронд нь салгаж түгшүүр, айдас үүсгэдэг. Зөвхөн аливаа үзэл суртлаас ангид ухамсар л энэхүү хагарлаас сэргийлж, түүнийг зайлуулж чадна. Үзэл сурталд автсан хүн өөртэйгээ зөрчилдөн тэмцэлддэг. Ийм хүн өөртөө итгэлгүйгээр барахгүй өөрөөсөө айдаг. Ямар ч урхи занга руу ороход бэлэн болдог. Тийм хүн өөрсдийн мөн чанараа мэддэггүй, ухаардаггүй учир хаашаа алхахаа мэддэггүй. Бүх үзэл суртал, үзэл баримтлал аюултай. Будда хүмүүнд аливаа шахалт дарамтгүй, үзэл суртлаас ангид байж аврагдах тэрхүү замыг зааж өгсөн. Чухам үүний учир тэр бээр бурхан, тэнгэр, диваажин эс бөгөөс ирээдүйн тухай огт ярьдаггүй билээ. Будда хүмүүнд шинээр барих, зуурах тулгуур өгөлгүй өмнөх суурь ойлголтуудыг нь няцааж үгүй хийгээд эцэст нь хамгийн дотноссон “би” хэмээх аминч үзлийг нь хүртэл устгана. Ийнхүү дан ганц цэвэр ариун ухамсар үлдэнэ. Энэ нь хүмүүнийг хүндхэн байдалд оруулдаг. Учир нь хүмүүн бээр өгөхүйн, түгээхүйн хэлийг огт мартсан, энэрэл таашаалыг умартсан бөгөөд дандаа бусдаас

авч амьдарч хэвшсэн. Бидний яриа хэлц хүртэл цөм авах, тухайлбал авгай авах, шалгалт авах, чимх нойр авах, юм хум цуглуулахаа хүртэл “ийм тийм юм авах” гэнэ. Хүмүүн бээр бусдад өгөх, буулт хийх, уучлан хэлтрүүлэх, орших, бүтээх, амьдрах боломж өгөхөө мартсан байна. Будда хийсвэр сэтгэлийн зорилт тэмүүлэл, бүхий л ирээдүйг тань авч хаяад, эцэст нь “би” хүртэхгүйг үгүй хийхэд юу ч таныг тодорхойлохоо болино. Ингээд хүмүүн бээр цэвэр ариун, гэм буруугүй, цагаан цайлган, онгон дагшин, юунд хоргодохгүй хоосон чанар болох ба Будда үүнийг нирваан гэж нэрлэсэн. Нирваан нь аливаа зорилго, зорилт бус хүмүүний хоосон чанар юм. Хэрэв хүмүүн бээр амьдралынхаа турш хуримтлуулсан зүйлээ хөсөр хаяж, ахин хуримтлуулахаа зогсоож, аливаа үзэгдэл юмтай зууралдахгүй, харамч шунахай сэдэл, үйлдлүүдээ зогсоовоос дотоодоос нь хоосон чанар оргилон гарч ирнэ. Энэ хоосон чанар хүмүүний дотоодод байсаар байсан, байсаар байх болно. Будда танд нирвааныг төгс төгөлдөрт тэмүүл гэж өгөөгүй. Бурхан Будда таныг албадан шахахын оронд чөлөөтэй болгодог. Будда бидэнд тэчъяадан тэмүүлэх зорилго, зорилтгүйгээр яг одоо амар амгалан, аз жаргалын дээдийг эдлэн амьдрахыг зааж өгч байна. Ухамсар бидэнд аливаа эд зүйл өгөхгүй, бас аливаа зорилго биелүүлэх арга хэрэгсэл ч болохгүй, зөвхөн тэдгээрийн хэрэгцээ, хүсэл шаардлагыг л үгүй болгодог. Энэ бол ухамсрын бодит үнэ цэн юм. Нирваан гэдэг үг лааг үлээж унтраах гэсэн сөрөг утгатай үг юмсанж. Шагжамуни Будда энэ үгийг зориудаар хэрэглэжээ. Учир нь эерэг үг бүр эгог хүчирхэгжүүлдэг бол сөрөг утгатай үг дарангуйлдаг. Хүмүүс Буддад : “Наад нирваан гэдэг үг тань сэтгэлийн хөөрөл, хүсэл тэмүүлэл үүсгэхгүй байна. Туйлын үнэн, өөрийгээ ухаарах, Бурханыг ухамсарлах зэрэг хэллэг нь асар их хүсэл тэмүүлэл бий болгодог байхад наад үг тань унтрааж байна” гэдэг. Будда хариуд нь: “Чухамдаа миний үгийн гоо сайхан энэ л чанарт нь бий. Хүсэл тэмүүлэл үүсгэж байгаа үг хүнийг эцсийн зовлонд хөтлөх тул ач тусгүй. Нирваан ямар ч хүсэл тэмүүлэл үүсгэхгүй учир хүмүүнийг эрх чөлөөтэй болгож, аливаа үймээн түгшүүр үүсгэхгүй. Харин ч эсрэгээрээ, та өөрийгээ уусган алга болгоход бэлтгэх учиртай. Ингэж эго уусан алга болж, хүн цэвэр ариун үлдэнэ” гэнэ. ***Аугаа Будда энэхүү сөрөг үгийг хэрэглэснээр хүн төрөлхтөнд гайхамшигт бэлэг барьсан бөгөөд 2500 гаруй жилд энэ үг хүчтэй хэвээр байна. Нирваан таныг уусган алга болгоно, харин та нирвааныг яаж ч чадахгүй.*** Нирваанаас өөр ямар ч үгэнд хүнийг тайтгаруулан нам гүм болгох увдис байхгүй. Нирваан гэдэг үгийг сонсоход таны хувьд цаг хугацаа зогсож, явах газар үлдээгүй мэт санагдана. Яг тэр мөчид та уусан алга болж, танаас ямар ч ул мөр үлдэхгүй.

***Будда дэлхий дээр бясалгах цоо шинэ хэв маягийг бий болгосон.*** Буддагаас өмнө бясалгал нь өдөрт нэг, хоёр удаа нэг цаг үргэлжилдэг дасгал байсан. Будда бясалгах үйлд тэс өөр утга чанар өгсөн. Будда: “Та нарын өглөө орой нэн нэг цаг хийдэг бясалгалыг өдөрт 5 удаа давтаж хийсэн олигтой үр дүн гарахгүй. Бясалгалыг амьдралаас салангид 1 цаг, эс бөгөөс 15 минут хийх дасгал сургуулилт төдий ойлгож болохгүй. Бясалгал таны амьсгалтай адил амьдралын тань салшгүй хэсэг болох учиртай. Та зөвхөн өглөө, оройд нэг нэг цаг амьсгалаад бусад цагт нь амьсгалахгүй байж чадахгүйн адилаар бясалгалыг хүлээн авах хэрэгтэй. Та унтаж байхдаа үргэлжлүүлэн амьсгалдаг шиг бясалгалаа хийх ёстой. Ухаан алдаж унасан хүн ч амьсгалсаар байдаг”. Бясалгал нь амьдралын салшгүй хэсэг болсон цагт л таныг хувьсгаж чадна гэж Будда айлдсан бөгөөд бясалгалын шинэ арга барилыг боловруулсан.

Ажиглалт ямар ч бясалгалд зайлшгүй. Харин Будда бясалгалаас бусад бүх зүйлийг нь авч хаяад зөвхөн үндсэн хэсэг болох ажиглалтыг үлдээсэн. Буддагийн сэтгэн бодох хэв маяг маш нарийн шинжлэх ухааны үндэслэлтэй учир тэр ажиглалтыг 3 төрөлд хуваадаг.

1. Бие махбодын ажиглалт хялбар тул хамгийн эхэнд ордог. Хүн өөрийн бие, гарын хөдөлгөөн гэх мэтийг харан мэдэрч ажиглах боломжтой. Алхахдаа алхам бүрдээ анхаарлаа хандуулан ухамсартайгаар биеэ ажиглаж чадна. Зооглож буй хоолныхоо амт мэтийг

амталж мэдэрч чадна. Будда удаан алхаж явдаг байж. Тэрээр: “Энэ бол миний бясалгалын дасгалын нэг хэсэг. Өвөл гол гаталж буй мэт удаан, сонор сэргэг, анхааралтай бай. Алхам бүрээ анхааралтай ажиглаж нэн сэрэмжтэй явахгүй бол мөс цөмөрч усанд унаж мэднэ” гэжээ. Алхам бүрд зам өөрчлөгдөх боловч алхах хэв маяг, аргачлал хэвээр байна. Хоёрдугаар алхам нь оюун санаа, ажиглах.

2. Оюун ухаан, сэтгэхүйгээ ажиглах. Одоо илүү нарийн баригдашгүй хэмжээс рүү орж, өөрийн бодол санааг ажиглах ёстой. Бодол бол бодит зүйл. Агаар харагдахгүй ч чулуутай адил бодитой оршдог. Бодлыг ажиглахдаа хэрхэвч шүүн тунгааж, эргэцүүлэн бодож болохгүй. Шүүн тунгааж эхлэнгүүт ажиглах чадвараа алддаг. Өөрөө бодол санааныхаа нэг хэсэг нь болчихвол гэрчлэх, хөндлөнгөөс түүнийг ажиг боломжгүй. Та замын хажуугаас машин ажигладаг гэрч бус харин замын хөдөлгөөнд оролцогч болж орхино. Нягтлан дүгнэхгүйгээр ажиглаж гайхамшигт зүйлүүдтэй учирна. Ажиглахын хирээр бодол санаа аажмаар багасдаг. Анхаарлын 50% нь санамсаргүй ажиглалтад чиглэсэн бол бодол санааны 50% нь алга болно. 60 % бо лоход 40% үлдэх гм. Хэрэв юмс үзэгдлийг нягтлан дүгнэхгүй, ялгамжтай хандахгүйгээр 100% гэрч нь байж чадвал толь мэт болно /тэнд, х 54/. Ажиглалт хийх нь ийм толь мэт болох явдал юм. Та замынхаа хагасыг тууллаа. Та нууцыг мэддэг болсон болохоор төрөл бүрийн юмс дээр турших хэрэгтэй.
3. Одоо бодол санаанаас илүү нууцлаг, баригдашгүй үзэгдлүүд болох сэтгэл хөдлөл, мэдрэмж, зан араншинтай учрах болно. Одоо сэтгэхүйгээр бус зүрхээрээ ажиглаж мэдрэх ёстой. Мөн л нягтлан дүгнэхгүй, ялгамж хандагаагүйгээр ажиглана. Сэтгэл хөдлөл, мэдрэмж, зан араншин өөрийг тань бүрэн эзэмдэгийг ухаарахдаа балмагдахвий. Уур, гуниг бүгдийг зүрхээрээ ажигласнаар эд таныг эзэгнэж чадахгүй. /тэнд, х 55/. Жаргалтай байсан ч баясан цэнгэхгүй, зовлонд унасан ч уйтгарлаж гунихгүй. Таныг ямар ч зүйл зүрхний долгисолд хүргэж чадахгүй. Амьдралдаа анх удаа хувь тавилангийнхаа эзэн нь болж байх шиг санагдана. Сэтгэл хөдлөлд тэнцвэрээ алддаг боол байхаа болино. Энэ төвшний ажиглалтын гэрч болж чадвал амьдралынхаа эзэн нь болно. Танд юу ч садаа болж чадахгүй, юу ч таныг дийлэхгүй, бүх юм танаас ангид оршиж, та өөрөө уулын оргил дээр суугч ажиглагч мэт болно /тэнд, х 55/.
4. Хэрэв бие, сэтгэхүй, зүрхийг бүрэн эзэмдэж, тэдэнд захирагдахгүй болсон бол танд хүлээхээс өөр сонголт байхгүй болдог. Эхний 3 алхмыг сайн хийсэн бол 4 дэх нь аяндаа бий болж таныг урамшуулна. Энэ бол зүрхний хүртэхүйгээс оршихуйн мөн чанар луу шилжих квант үсрэлт юм. Та үүнийг өөрөө хийж чадахгүй, бүү оролдоорой. Оролдлого тань бүтэлгүйтэх нь гарцаагүй. Энэ бол тохироо нь бүрдэхээр өөрөө аяндаа явагддаг үйл явц. 4 дэх алхам оршихуйгаас хийгдэнэ. Ингээд та гэртээ ирлээ. Эрэл тань дуусаж оршихуйн бодит үнэнийг оллоо. Сэхээрэхүй, гэгээрэл, туйлын эрх чөлөө ер юу гэнэв дураараа бол. Ингээд туйлын баяр хөөр таныг мөнхөд хамгаалан хучих болно /АГ 15, х 56/.

***Шагжамуни Буддагийн дэлхий дээр хэлсэн сүүлчийн үг нь: “Өөрөө өөртөө гэрэл бол” /АГ 15, х 69/. Бусдыг бүү дага, бүү дуурай. Дагаж дуурайх нь тэнэг үйлдэл. Та оюун ухааны агуу боломжтой төрсөн. Та дотроо гэрэл гэгээтэйгээр энэ хорвоод мэндэлсэн. Дотоод дахь нам гүм дуу хоолойгоо чагна, тэр л таныг зөв замд хөтөлнө. Та нэн өвөрмөц, онцгой учир өөр хэн ч таныг хөтөлж чадахгүй, өөр хэн ч танд загвар жишээ болж чадахгүй. Тантай яг адилхан хэн ч байхгүй, байгаагүй, дахин хэзээ ч төрөхгүй. Энэ бол таны сүр жавхлан, яруу алдар. Таныг хэн ч орлож чадахгүй. Та бол зөвхөн та өөрөө, өөр хэн ч биш. Будда багш мэргэн ухааныг хүний ухамсрын гэгээ гэж тодорхойлдог. Та зуун зууны турш хэн нэгнийг дагаж төөрөлдөж байсан учир Бурхан багшийн бүхий л чармайлт нь таныг эрх чөлөөтэй болгоход чиглэгдсэн байдаг.***

Будда: “Би юмсыг ямар байдлаар оршдог, түүнийг л хэлдэг. Түүнээс өөр юу ч ярьдаггүй. Миний үгс зөрчилтэй, логик бус байдгийн учир энэ. Үнэн бол логик бус. Үнэнийг ойлгохын тулд логикоос хэтийдэх ёстой” /Ошо Очир огтлогч, х 81/.

Будда болсон нэгний хувьд агуу хийгээд өчүүхэн, чухал хийгээд чухал бус гэсэн ялгаа арилж, гагц мөн чанарт оршдог /Ошо Очир огтлогч, х 10/. Тэрээр аягаа авахдаа ч Бурханд хандаж байгаа шиг хандана. Хувцсаа өмсөхдөө ч Оршихуйн утгыг сэрж мэдэрнэ. Хүн ухамсаргүй зуршлаар үйлддэг бол Будда бүхий л үйлдлээ ухамсраар үйлддэг. Будда ч, та нар ч хоол идэж, усанд ордог. Харин хүн бээр усанд орохдоо ч талархал үгүй хайш яайш, хоол зооглохдоо ч хүндэтгэл үгүй хам хум. Тэгвэл Будда юу ч хийж байсан түүндээ уусан нэгдэж, энд-одоо цагтаа бүрэн оршдог /тэнд, х 11/. Будда хувцаслаж байхдаа түүндээ л анхаарна. Алхаж байхдаа алхаандаа л оршино. Юу ч хийхгүй үедээ амьсгалаа мэдэрнэ. Түүний мэдрэг, сэргэг чанар нойрсож байхад нь ч алдрахгүй /тэнд, х 11/.

Буддад ямар ч эго байхгүй. Тэр бээр эзгүй хоосон. Энэ нь Түүний байхуй. Амьдрах атал, алхах атал, ярих атал түүн дотор хэн ч амьдардаггүй, хэн ч ярьдаггүй, хэн ч алхдаггүй. Аниргүй нам гүм нь хэзээд хэвээрээ. Үйлдэгч үгүй нь Түүний үйлдэхүй. Ертөнц үгүй нь Түүний ертөнц. Би үгүй нь Түүний биет чанар /тэнд, х 52/.

Будда бол урдаа зам үгүй, ардаа мөр үгүй нэгэн /тэнд, х 52/.

## **БУРХАН**

*Үзэх: Багш, Эрэл/Эрэлчин*

Кабир: “Намайг байхад Бурхан байгаагүй. Бурхан байхад би байгаагүй. Энэ хоёр уулзаагүй”.

“Би” гэсэн үзэл бодол угаасаа ташаа. Бүхэл буюу Бурханд би үгүй. Би, Бурхан хоёр хамт орших боломжгүй. Учир нь би байгаа л бол тусгаар нэгэн байна гэсэн үг. Гэтэл Бурхан бол бүхэл чанар /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 82/. Бурханы үйлс бол ажил алба биш тоглоом наадам юм. Тийм болохоор агшин хором бүр нь бүтээл мөртлөө амралт зугаа. Бурхан зүгээр л наадаж баясдаг. Хорвоо ертөнцөд байх атлаа түүний гадна үлдэнэ. Зах хүрээндээ байлаа ч дотоод төвөө мартаггүй. Мянга түмэн зүйл хий мөртлөө эс үйлдэгч хэвээр үлддэг. Олон замаар аялах боловч хэзээ ч гэрээсээ төөрөхгүй, дотоод гэрэл нь асаастай /тэнд, х 125/. Бурхан тийм хямд биш. Чи түүний төлөө бүхнийг төлөх ёстой. Өөрийгээ өчүүхэн ч харамгүй өргөл болгох учиртай. Тэрээр буланд чимээгүйхэн хүлээж, чиний хоосрохыг, өөрийгээ бүрмөсөн өргөхийг хүлээж байдаг. Мэдлэг, загварт автахгүй байвал зүй ёсны эмх цэгц дотоод цөмөөс тодорно. Тэр бол хүчлэн бүтээх хэв биш амьд ургалт. Хүчлэлгүй зөнгөөрөө бай. Бурхан бол чиний ая зөнгийн цэцэглэл /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х129-130/.

## **БУРХАНЫ ХУТАГ**

*Үзэх: Амьдрал, Будда, Оршихуй*

Гэгээрэхээсээ өмнө энэрэл нигүүслийг төлөвшүүлэх ёстой. Гэгээрсний дараа сурах юм байдаггүй. Хэрэв хүн баяр хөөртөө нэгэнт ханасан бол энэрэх нигүүсэх ч тээр мэт санагддаг. Чухам үүний учир гэгээрсэн хэдэн зуун хүн байдаг ч тэдний хэдхэн нь Бурханы хутгийг олдог /Ошо Гайхамшигт хүмүүстэй хийсэн ярилцлагууд, х 64-65/.

Ошо: Нүд нээгдэхэд эргэн тойронд амьдрал буцалж, аварга том хэлбэлзлүүд оволзож байв. Би яг л тайфунд орчихсон юм шиг. Гэрэл гэгээ, баяр баясгалан, аз жаргалын нүсэр их шуурганд живж байгаа юм шиг. Энэ үнэхээр бодитой байсан болохоор өрөөний хана, байшин, бие гээд юмс бодит бус болсон. Бүх юм бодит бус болж, би анх удаа бодит байдлыг жинхэнээр мэдэрч байв. Будда өөр бодит байдал бий, ертөнц бол хуурмаг гэсэн нь энэ байж. Тэрхүү бодит байдалд хүрэх л юм бол одоогийн энэ бодит байдал замхарна. Шинэ бодит байдал, шинэ хэмжээсүүд нээгдсэн. Тэнд ер бусын, өөр, үнэн гэж нэрлэж болохуйц өөр бодит байдал байлаа. Түүнийг Бурхан, Үнэн, Дао, Дхарма яаж ч нэрлэж болно /Ошо Эр хүний тухай х 103/.

***Бурханыг хоёргүй чанар гэдэг. Үүнийг хуваагдашгүй утгаар ойлгоно. Ямар зүйл хуваагдашгүй байх вэ? Гагцхүү цэвэр хоосон чанар хуваагдашгүй. Будда угтаа хэн ч биш. Хил хязгаар бүхнээс хэтийдсэн оршихуй. Оршихуй байвч би гэх мэдрэмж байхгүй /АГ 13, х 100, 103/.***

## **БУЯН**

Үзэх: Нүгэл / Буян

Японы Зэнгийн Багш Негэн Сэнзаки хэлжээ: “Тарьсан буяны үр тань хаана ургах тухай санаа зовох хэрэггүй. Буяны үрийг тариад л мартаж орхи” /Д. Т. Сузуки Зэн Буддизм, УБ, 2012 он, х 9/. Ноён Мин-ван Ло-Шаньд зориулж сүм барьжээ. Тэгээд их танхимд нээлтийн үг хэлээч гэж Ло-Шанийг урьжээ. Сүмийн тэргүүн тэр бээр сандалд суусан боловч юу ч хэлсэнгүй. Тэгээд өрөө рүүгээ явахдаа “баяртай” гэжээ. Мин-ван өрөөнд нь очоод: “Градхаркут ууланд Буддагийн айлдсан сургаал өнөөдрийн таны айлдсан шиг ийм байсан байх ёстой” гэхэд сүмийн тэргүүн: “Би таныг ном мэддэггүй хүн гэж бодсийм. Харин одоо зэнгийн талаар бага сага төсөөлөлтэйг тань ойлголоо” гэжээ /Д. Т. Сузуки Зэн Буддизм, УБ, 2012 он, х 15/.

Буянаа зориулах тухайтад Бурхан Багш бээр ийн айлджээ /Алтан Гэрэлт судар/:

- ✓ Үзүүр хязгааргүй орчлонд төрөн төрөхдөө би ямар буян хураасан, тухайлвал гурван эрдэнийг тахисан, бусдыг асарсан, адаглаад өмхийн төдий идээг адгуус амьтанд өгснөөс эхлээд итгэлийн суртлыг сахисан, хилэнц нүглээ наманчилсан, буянд даган баяссан, айлтгал өргөл үйлдсэн буяны үндэс бүхнээ хурааж хамаг амьтанд бэлэглэе.
- ✓ Харамлах өмчлөх сэтгэлгүйгээр хайр ивээлээ ертөнцөд түгээгч Бурхадын суу билгийг өглөг болгон түгээе.

Хамаг амьтны гарт хүслийг хангагч чандмань болтугай.

Эдийн болоод эрдмийн буян бүхэн ундрах барагдашгүй огторгуйн сан хөмрөг болтугай.

Хамаг амьтанд сайн сайхнаа бэлэглэсэн буяны үрээр би төгс гэгээрлийн суу билгийг олох болтугай. Шагжамуни Бурхан лугаа би болон хамаг амьтан үлэмжийн гэгээрэлд хүрэх болтугай.

## **БҮТЭЭЛ**

Бүтээлч чанар бол дуулах, бүжиглэх, шүлэг бичих, зураг зурах гэхчилэн тусгай ажил үйлтэй холбоогүй. Ямар ч үйлэнд бүтээлч чанарыг шингээж болно. Үйл өөрөө тодорхойгүй зүйл. Зурлаа ч бүтээлч биш зурах, дууллаа ч бүтээлч бишээр дуулж болно. Шал угааж, хоол хийхдээ ч бүтээлчээр хийж болно. Хийж буй үйлэндээ шингээж буй агуулга нь уран бүтээл юм. Аливаад хандаж буй дотоод хандлагаас чинь хамаарна. Санах зүйл: 1) Бүтээлч чанарыг ямар нэг тусгай үйлэнд бүү хаш. Зүгээр алхаж, нам жим сууж байгаа нь хүртэл уран бүтээл. Бодь модны дор зүгээр л сууж буй Будда энэ ертөнцөд хэнтэй ч зүйрлэшгүй бүтээлч юм. Юу хийхээс бус өөрөө хэн байхаас бүх зүйл хамаардгийг ойлговол ээдрээ тайлагдана. Юу ч хийсэн түүнийгээ хайр, баяслаар, бясалгагч ухамсраар үйлдэх юм бол тэр чинь уран бүтээл. Дотоод чинадаас төрж, эргээд дотоод хөгжлийг чинь тэтгэж байгаа бүхэн сүнслэг, тэнгэрлэг бүтээл юм. Бүтээгч чанар оргилдоо хүрч бүх амьдрал

чинь уран бүтээл болох цагт чи Бурхан дотор л амьдарна. Хүн бүхэн энэ ертөнцөд бүтээлч байхаар төрдөг. Хүүхэд бүхэн бүтээлч. Амбиц орж ирүүт бүтээлч чанар бөхдөг. Учир нь тийм хүн хайрлаж чадахгүй. Бүтээлч хүн үргэлж одоо цагтаа оршдог. Оршихуй, бүтээлч байх хоёр нэг утгатай. Орших мөртөө бүтээлч биш байх боломжгүй. Бүтээлч хүн өөрийгөө л эрхшээдэг. Өөрийгөө эрхшээж чадалгүй ертөнцийг эзлэхийн гавъяа юусанж. Мөн чанараа золиослон байж түмэн олныг хөлдөө сөгтгөлөө гээд чи яах юм бэ? Үнэн зүрхнээсээ инээх ч агуу бүтээл юм шүү. Өглөгч байгтун. Өгч чадах бүхнээ түгээ. Бүтээгч нар олон сувгаар цацрах учиртай /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 150-153/. Бүтээлч байа гэвэл ашиг, алдрыг март. Хийж буй зүйлдээ л баясан цэнгэ. Бүжигтээ хайл. Бусад хүн таалж буй эсэх нь хамаагүй. Бусдаас бурам шан бүү горил. Чи өөрөө л бүжиж баяссан болохоор хэдийн ханамж шангаа хүртсэн шүү дээ /тэнд, х 155/. Аварга чулууг өргөдөг Зэн мастер: “ Ямар ч арга заль хэрэглэдэггүй. Би зүгээр л чулууг хайрладаг болохоор чулуу надад тусалдгийм. Би түүнээс тусыг нь гуйж, хамт хөдлөхийг хүсээд хайрлан тэвэрч хариу дохио хүлээдэг. Чулуу дохио өгөх үед нуруугаар минь долгион гүйж мэдрэгдэнэ. Тэр үед би өргөдөг. Та нар чулууг сөрж хөдөлдөг болохоор асар их хүч гаргадаг. Харин би чулууны аяыг дагаж хөдөлдөг. Үнэндээ би чулууг хөдөлгөдөггүй, чулуу өөрөө хөдөлдөг. Би зүгээр л хамт байдаг юм”. Өөр нэг Зэн мастер мужаан: “Энэ сайхан сандал, ширээ мэтийг би хийдэггүй, өөрсдийнх нь тааллар бүтдэг юмаа. Ой руу явж, ямар мод сандал болмоор байгааг нь асууж тодруулах л миний үндсэн ажил. Ойд очоод би модны хүслийг асууж, надтай хамт явж, найрсан зохилдох эсэхийг нь асуудаг. Зөвшөөрвөл нь би залж ирдэг. Зарим мод сандал болохдоо бэлэн биш байдаг. Тэр үед би гар хоосон буцаж ирдэг. Модыг хүсэл тааллаар нь авчрахад хамаг ур ухаан оршдог. Тэгсэн хойно мод өөрөө мужааны туслалцааг гуйдаг” /тэнд, х 155, 156/. Хайрлангуй байх юм бол бүх ертөнц амьдлаг болохыг харна. Чамаар дамжуулж нэгийг хийж, хоёрыг бүтээх төлөвлөгөө Бүхэлд бий юм шүү /тэнд, х 156/.

## **БҮХЭЛ**

*Үзэх: Мөн чанар, Махамутар, Очир огтлогч*

Ухамсар бол эрүүл төлөв. Харин “би” бол өвчин юм. Ухамсрын тухайд бол хувь чанар, Бүхэл хоёрын дунд ямар ч зөрчил үгүй. Хувь нь Бүхэл рүү урсаж, Бүхэл нь хувь руу урсана. Амьсгал лугаа адил. Амьсгал авах үед Бүхэл чам руу орж, амьсгал гарах үед Бүхэл рүү чи урсана. Энэ тэнцвэр үргэлж хадгалагддаг. Гэтэл би-г баримтлагч нь авахаас биш өгөхийг мэдэхгүй. Өөртөө л хурааж, өөр хэнийг ч оруулахгүй хана хэрэм босгож, үйл бүрээрээ түүнийг зузаална. Амьдрал бол хуваалцахын нэр. Ухамсар бол хил хязгааргүй амьдрал. Тэгэхээр би үгүйн ухамсар нь жинхэнэ ухамсар. Би-үгүй гэдэг нь “би” хэмээх явцуу төв арилж, үнэмлэхүй “Би” буюу хотлын төвд хүрэхийн нэр. Хоосон хонгил мэт болоход миний гэх юу ч үгүй болно. “Бууж өгөх” гэж би үүнийг хэлдэг. Би үзэр бол тэмцэх, дайтах хандлага. Оршихуйтай тэмцэлдэх юм бол чи би-г баримтлагч болно. Мэдээж ахин дахин ялагдсаар. Чи Оршихуйтай, Бурхантай цуг байж л амжилтанд хүрнэ. Бүхлийн эсрэг тэмцсэнээр зовлонг бүтээдэг /Ай даа, энэ шүү дээ, х 167/. Хэрвээ чи зовлонтой байгаа бол өөрөөс чинь өөр хэн ч үүнд буруугүй /тэнд, х 168/. Хэрэв чи өөрийгөө таньсан бол бусад хүн намайг юу гэх бол гэж санаа зовож явахгүй. Чиний тухай ярьж байхдаа тэд өөрсдийгөө л ярьж байдаг. Өөрсдийгөө ч таниагүй байж тэд чамайг яаж мэдэх билээ /тэнд, х 174/.

Хүн бүхэн үлэмж хүчтэй байж таараа. Учир нь хүн бүхэнд Бурханд үндэслээтэй, Оршихуйд шүтээстэй. Хэдий алд биехэн харагдавч орчлон ертөнцийн мөн чанараас гадуур байх боломжгүй. Үүнийгээ мартсан хүн сул дорой болно. Сая сая хүн ийм л юм хийдэг. Тэд хүч чадлыг нар буруу зүгээс хайдаг. Хүч чадлын эх булаг дэргэд чинь, дэндүү ойрхон, үргэлж нээлттэй байвч төөрөн бэдэрсээр. Бид О-Нами бөх шиг үлэмж хүчтэй, бүгд далайн давалгаан. Үүнийгээ мартсан байж магадгүй, харин далай биднийг мартаагүй. Хүн бол Бурханы хувилгаан /тэнд, х 176/. Энэ судрыг



тогтоож ав: Би-г санаж байхдаа чи Бурханыг мартана. Би-г огоорсон үедээ Бурханыг санана. Би, Бурхан хоёрыг зэрэг санах боломжгүй /тэнд, х 177/.

Зааглалтаас бүү эхэл. “Би нэгдмэл”-ээс ч бүү эхэл. Зүгээр л мэдэхгүйгээс, хүлцэнгүй үл мэдэхгүйгээс, “би юу ч мэдэхгүй”-гээс эхэл /Ошо Эзотерикийн сэтгэлзүй, х 76/. Тийм, үгүй хоёроос зай барь. Дундын байр суурийг ямагт барь. Зүгээр л “По” гэж хэл. “Таныг сонслоо, тийм ч гэхгүй, үгүй ч гэхгүй ээ” гэсэн санаа /тэнд, х 76/. Бүхэлийг Бүхэл юмаа гэж ухаарсан үед л хувирч өөрчлөгддөг. Мэдэрч байхдаа нэгдлийг мэдэрдэг, бодож байхдаа хувааж эхэлдэг. Одоо цагт зааглалт гэж үгүй. Оршихуй хуваагдашгүй, бүх хуваалт оюуных /тэнд, х 76/. Оршин буйг л мэдэр. “Нэг”, “хоёр” гэж бүү хэл /тэнд, х 76/. Гагцхүү оюун ухаан үгүй үед л, ойлголт, философ, онол, бүр хэл ч үгүй үед л байгааг мэдэрч болно. Хэл үгүй үед та Оршихуйд, хэл байгаа үед оюун ухаандаа байдаг /тэнд, х 76/. Хэл үгүй бол та бүхэн нэг л хэлэнд - Оршихуйд харъяалагдана /тэнд, х 77/. Үг үгүй ухамсрын төвшин рүү буцаж ирж бай. Мод, шувуу, тэнгэр, нар, үүл, бороотой цуг амьдарч бай. Ингэвэл гүн руугаа шумбаж, төдийчинээ нэгдлийг мэдэрнэ. Гагцхүү анир чимээгүй нь л нэгдэл юм /тэнд, х 83/. Бүхлийг оноё гэвэл оюун ухаанаас хагацах хэрэгтэй. Тогтолцоо үсгэх юм бол оюун ухаанаа гэж чадахгүй. Яагаад гэвэл тэр завсруудыг дүүргэх болно /х 88/.

## **БЭЛЭН БОЛОХ**

*Үзэх: Эрэл/Эрэлчин*

## **БЯСАЛГАЧ**

### **БҮХЭЛ**

*Үзэх: Очир огтлогч*

### **БҮХЭЛ**

*Үзэх: Очир огтлогч*

## **БЯСАЛГАЛ**

*Үзэх: Гэгээрэл, Оршихуй, Очир огтлогч, Төв/Хүрээ, Төвлөрөл, Эрх чөлөө*

Ошо: “Бясалгал бол үнэмлэхүй амралтаас өөр юу ч биш. Энэ үнэмлэхүй амралтыг бүтээх 1001 арга бий. Манай арга бол амралтгүйгээс амралт руу. Бие, хэл, сэтгэлийн бүх идэвхийлэл зогссон үед жинхэнэ бясалгал эхэлдэг. Зүгээр байх юм бол энерги босоо тэнхлэгээр өгсөнө. Үйлэнд идэвхийлэх үед хэвтээ шугамаар хөдөлнө. Өнгө мөнгө, нэр төр, эрх мэдэл, ашиг хонжоо бүгд хэвтээ чигийн хөдөлгөөн. Хайр, бясалгал, Бурхан, нирваан – босоо тэнхлэгт л оршдог. Шунал, хүсэл, бодол, төсөөлөл, ой санамж нь сэтгэлийн толийг хучдаг тоос юм. Түүнийг бясалгалаар цэвэрлэ /АГ 11, х 48-49/.

Хувь хүний ертөнц, хүслийн хорвоогоо орших хэрэгтэй. Бясалгалын утга санаа ердөө л энэ /АГ 11, х 64/.

Юу ч хийхгүй, юунаас ч зуурахгүй, ганцаараа байхыг бясалгал гэдгийм /АГ 13, х 81/. Ертөнц дээрх агуу гайхамшиг юу вэ гэхэд Зэн багш: “Би энд ганцаараа суудаг” гэжээ /АГ 13, х 80/. Энэ хамгийн агуу гайхамшиг мөн. Ганцаардал бол бусдын эзгүйрэл. Ганцаараа байхуй нь өөрийн дүүрэлт. Өөрөөрөө чи бүх ертөнцийг дүүргэж чадахуйц тийм бялхам хангалуун байна. Орчлон хөрвөж галав юүлсэн ч Зэн багшид алдах юмгүй. Учир нь тэр төрөлх гэртээ тухалсан учраас юугаар ч

дутахгүй. Энэ нь гэгээрсэн буюу гэртээ харьсан хүн бусадтай амьдардаггүй гэсэн үг биш. Чухамхүү тийм л хүн бусадтай амьдарч чадна. Өөртэйгээ ч байж чаддаггүй хүн яаж бусадтай амьдрах билээ. Чи өөртөө хамгийн ойр орчин. Өөртэйгээ байхдаа жаргалтай хүн бусдаас хайр халамж горьдохгүй. Харин халгиа цалгиагаа л хуваалцана. Өөрөө гачигдаж явдаг хүн бусдыг юугаар гялайлгах вэ. **Иймд хайрын анхны хичээл бол ганцаар байхуйд суралцах** /АГ 13, х 81/.

Улам гүн рүү уусах аваас ганцаардал чинь ганцаар ахуйд хувирна. Гэнэт гэртээ ороход, ёроолгүйд ороход эхэндээ хоосон чанар шиг санагдана. Нэгэнт орсон хойно дүүрэн оршихуй, төгс цэцэглэхүй байх болно. Өөртэйгээ байхуйд суралцвал үхэл утгаа алдана. Үхэлд булаагдах юмсаас өөрөө гэтэлсэн болохоор тэр. Бясалгалын утга учир үүнд оршино. Ганцаараа байхын сүр жавхлан, цог залиг зүйрлэх аргагүй. Энэ бол үнэмлэхүй суу заль, тэнсэлгүй эрх хүч. Гэртээ харь. Харих зам нь ганцаардлыг туулах. Ганцаардлын шаналал бол түүний төлөөх төлөөс юм /АГ 13, х 84/.

Бясалгал нь хүний амьдралын салшгүй хэсэг болсон цагт л таныг хувьсгаж чадна гэж Будда айлджээ /Ошо Гайхамшигт хүмүүстэй хийсэн ярилцлагууд, 2014, х 50/. Буддагаас өмнө бясалгалыг тусгай цаг гаргаж хийдэг онцгой дасгал мэт ойлгогдож байсан бол **Будда бясалгал нь амьсгалах мэт энгийн бөгөөд тасралтгүй үйл явц байх ёстойг заажээ.**

Ерөнхийдөө ажиглалт бол ямар ч бясалгалд зайлшгүй. Харин Будда бясалгалаас бүх зүйлийг нь авч хаяад зөвхөн үндсэн хэсэг болох ажиглалтыг л үлдээсэн /тэнд, х 52/. Будда ажиглалтыг 3 төрөлд ангилдаг /үзэх: Будда/.

Сэтгэхүйнхээ мөрний эрэг дээр сууж оюун ухаан, бодол санааныхаа урсгалыг ажаарай. Юу ч битгий хий. Энэ бүхэн танд огт хамаагүй мэт хөндлөнгөөс ажаиглаарай. Оюун ухаан, сэтгэхүйдээ болж буй үйл явдлыг гэртээ хол болж байна гэж төсөөлөөрэй. Оюун ухаан, сэтгэхүй чинь та биш, харин хэн нэгэн. Иймд та түүнийг зөвхөн хөндлөнгөөс ажигла. Будда энэхүү гүн ухааны номлолыг *najjhim nika* гэж нэрлэсэн ба туйлууд ямар байхаас үл хамааран ямагт дундыг баримтал гэсэн утгатай. Ажиглагч ямагт дундыг баримтлагч байдаг. Харин үйл явцад автах, эсвэл түүнийг эсэргүүцэн зэвүүцэх тэр мөчид хүн ажиглагч байхаа больдог. Эсэргүүцэн зэвүүрхэж буй бол нөгөө туйл руу тэлүүлэх ба автсан үедээ энэ нөхцөл байдалдаа үлдэх гэж хичээнэ. Ингээд дундыг баримтлагч байж чадахгүй. Иймээс хөндлөнгийн ажиглагч бай, үйл явдалд бүү хутгалдан оролц. Үйл явц, юмс үзэгдэлд бүү авт, бүү ялгаварлан гадуурх, бүү жигшин зэвүүц. Толгой тань өвдөж байвал хүлээн зөвшөөр. Ой мод, байшин, толгойн өвчин бодитой байгаа. Тэднийг нүдээ аниад хүлээн зөвшөөр, зугтах гэж бүү оролд. Аз жаргалтайгаа хүлээн зөвшөөр, автаж болохгүй. Буцаад аз жаргалгүй болох гэж хичээх хэрэггүй. Юу ч хийх байсан бай, бүх оролдлогуудаа зогсоо. Зовлон гунигийг хүлээн зөвшөөр. Өглөө, орой, өдөр, шөнө, од, нар, сар мандаг жаргаг. Тэднийг уулын оройгоос л ажигласаар бай. Та гэртэй тэргүй юу ч хийж чадахгүй тул зөвхөн харна уу. Өвчнөө ажигла, тэр бүгд ирсэнтэйгээ адил буцаад алга болно. Савлуурт дүүжинг төвд нь тогтоож чадвал та амьдралдаа анх удаа ертөнцийг тэс өөр нүдээр харах болно. Та хөдөлгөөнд байгаа нөхцөлд хүрээлэн буй зүйл, хорвоо ертөнцийг танин мэдэж чадахгүй. Хөдлөл бүр чинь түүнийг самууруулдаг. Хөдөлгөөнгүй зогсож байхдаа л ертөнцийг ажиглаж чадна. Ингэж л бодит байдлыг таньж мэднэ. Хөдөлгөөнд байгаа оюун ухаан, сэтгэхүй бодит үнэнийг хэзээ ч хүртэн мэдэрч чадахгүй. 2 туйл руу савчихаа больж, туйлшрахаа зогсоож, төвийг баримталж чадвал савлуурт дүүжин шууд зогсоно /Ошо Гайхамшигт хүмүүстэй хийсэн уулзалтууд, х 59/.

Бясалгал бол хүчилж хийдэг дасгал, тэмцэж хүрдэг амжилт биш. Тийм зүйлс оюуны л үйлдэл. Оюун ухаан бясалгалд нэвтэрч чадахгүй. Бясалгалаас бусад бүх зүйлийг оюунаар бүтээж болно. Учир нь бясалгал бол бүтээгдхүүн биш займал оршихуй. Түүнийг гагцхүү санаж сэрэх учиртай. Чамайг хүлээж дотор чинь нээлттэй байсаар байдаг. Хаа ч, хэзээ ч чи түүнийгээ өвөрлөж явдаг.

Тэр бол алддаг, эсвэл олдог юм биш, язгуур мөн чанар чинь. Бясалгал бол сэтгэхүйн биш сэрүүн тунгалаг төлөв. Бодлын үүл сарнихад тэрхүү тунгалаг төлөв тодорно. Тийм төлөвт чиний мэлмий алсын алсыг тольдож, оршихуйн үндэст нэвтэрч чадна. Бясалгал бол үзэхүй болохоос бодохуй биш. Бясалгалд орохын тулд оюун бодлоос ангижрах учиртай. Харин бодлоос ангижрах гэж хүчлээд эхэлвэл энэ нь эргээд бодол, үйлдэл болно. Бодлоос ангижир гэдэг нь юу ч бүү хий гэсэн үг. Зүгээр л бай. Бодол өөрөө арилаг. Оюун ухаан ая зөнгөөрөө зогсог. Буйдхан буланд хана ширтээд зүгээр л суу. Хаашаа ч яарах, юу ч хийх шаардлагагүй. Гүн нойронд умбаж байгаа шигээр бүх бие чинь тавираг. Харин дотроо сэрүүн бай. Бодлын хөл үймээнд хөндлөнгөөс хутгалдах Японд ийнхүү зүгээр суухыг зазен гэдэг. Нэг л өдөр бясалгал тохионо /АГ 15, Эртний сайхан аялгуу, х 129/. Өөрийнхээ мөн чанараас бусад бүх юмыг чи сонирхож явсан. Энерги дотогшоо эргэхийг Будда Параврүтти буюу эх сурвалж руугаа эргэх гэдэг. Тэгсэн хойно гэв гэнэт тунгалаг оршихуй нээгдэнэ. Эрдэнэсийн сан чинь хамт байсаар байхад чи түмэн бодолдоо автаад түүнийг харахгүй байсан хэрэг. Оюунд автахгүй байх тусам зазэнд суух боломж, бясалгалтай учрах чөлөө учрал өснө. Оюун ухаан: - үргэлжийн үглээ чалчаа юм. Чи гаднаа ярихгүй ч дотроо чалчсаар л байдаг. Энэ дотоод яриа чинь хормын төдий зогсоход арилсан төлвийн гялбааг үзнэ. Бясалгал бол оюун бодлоос ангижирсан төлөв, жинхэнэ оршихуй чинь. 2 бодол, 2 үгний хооронд завсар чөлөө бий. Үгийг л ажихаас завсрыг нь анзаардаггүй. Одоо тэгвэл анхаарлаа шилжүүл. – оюун ухаан хязгаарлагдмал боломжтой. Тэрээр эсрэг тэсрэгийг танин барьж чаддаггүй. Тиймдээ ч Бурханыг таньж чаддаггүй, дотоод чинадыг сэрж мэддэггүй. Үгийг анхаарч буй оюун ухаан үгийн ард буй аниргүйн чөлөөг харж чадахгүй. Тиймээс тусгалаа өөрчил. Бясалгалд ноцтой хандлага хэрэггүй. Нам жим суугаад завсар чөлөөг харж эхэл. Хүчилж чангарах хэрэггүй. Уужуу тайвуу, энгүүн тааваараа, аясаараа, наадан зугаацаж байгаа юм шиг бай. Жинхэнэ бясалгагч хөгжүүн, амьдрал түүний хувьд наадам. Үг үнэ хүндгүй болж, завсар чөлөө л хүндтэй болдог. Хар самбар дахь цагаан цэгийг хараад байвал хар дэвсгэр арилна. Самбарыг хараад байвал цэгэн дүрс хоёрдогч болно. Үг бол дүрс, анир чимээгүй нь дэвсгэр /самбар/ юм / АГ 15, х 130-131/. Оюун ухаан бол чиний хурааж цуглуулсан үгс, бодь чанар бол чамтай хамт төрсөн аниргүй. Аниргүй нь өөрөө бясалгал юм. Энэ агшиндаа байхад оюуны хэрэгцээ үгүй болдог – ухамсар л хангалттай. Юу хийж байгаадаа л орш. Алхаж байхдаа алхандаа, идэж ууж байхдаа илтэс хэлтэс бүрийг мэдэр. Алдуурмагц сэхээрч хаа байгаа газраа эргэж ир. Энэ бүхэн бясалгалын нөхцөл / АГ 15, х 137/.

Шанкарагийн шавь байнга л юм шалгаадаг, багш дүлий дүмбэ оргин суух. Нэг өдөр: “Би чамд заагаад л байна. Чи даанч ухаарахгүй юм. Чимээгүй нь л жинхэнэ би шүү дээ / АГ 15, х 132/.

Шожу багш чоно үүрлэдэг оршуулгын газар 7 хоног зазэнд суужээ. “Би тухайлж юу ч хийгээгүй. Зүгээр Зазэнд сууж байхад минь бөөн чоно тойрон шаваад хамрыг минь долоож, хүзүү шанаагаар шиншилж байлаа. Гэвч зөв төлөвт байсан болохоор надад халдсангүй. Сэтгэлийн зохист төлөвт орших аваас амьдрал үхэлд ажрахгүй, гал усанд автахгүй” / АГ 15, х 140/. Бодол бүхэн эерэг сөрөг 2 туйлтай. Сөрөг соронзон туйл үүсгэвэл нөгөө талд нэмэх туйл аяндаа үүснэ. Чамайг айдаст автахад нөгөө талын дотор чамайг айлгах зовоох хүсэл даруй төрнө. Араатантай харьцахад ч адил. Хэрэв чи зөв төлөвт байх юм бол учрал тохиолыг зүгээр л гэрчилнэ. Дотроо атгаг сэжиг үүсгэхгүй учраас эргэн тойронд чинь атгаг үүсэхгүй /тэнд х 141/. Бодол бүхэн биеждэг жамтай. Хайрлавал эргэн тойрон хайр ургана. Бодолд автахгүй бол юу ч чамд халдахгүй / АГ 15, х 142/. Шожу багш тухайлж юу ч хийгээгүй, зүгээр л суухад бүх юм өөрчлөгдсөн аж. Хэрэв энэ хорвоод нам жимхэн, амьд хоосон чанар шигээр суух юм бол хорвоо ертөнц диваажин болж хувирна. Ухамсрын зөв төлөвт зүгээр л байхад бүх юм зөнгөөрөө бүтнэ. Оршихуйд 2 төрлийн хууль бий. Нэг нь, бодол сэтгэлийн хууль. Түүгээр чи эргэн тойрноо тамыг бүтээж явдаг. Андууд атаатан болж, амрагууд өстөн болж, цэцэг өргөст хувирдаг. Хэрэв оюун бодлын хүлээсээс гэтэлвэл нирваан буюу арилсан бурханы орон. Идэвхийлж үйлдэхгүйгээр энхжин өөрөө биелнэ. Эгогоос

салж, үйлдэгч сэтгэлээс ангижирвал, амьдралд уусан адарвал Бурханы оронд эргэж ирнэ. Эргэх замаа мэд: Үйлдлээс үчралд, би-гээс би-үгүйд, оюун бодлоос арилсан төлөвт шилжих нь зам мөр билээ / АГ 15, х 143/.

Мэдлэгийн тоос сэрэхүйн толийг бүрхдэг. Бясалгал бол сэтгэлийн толио арчихуй юм. Амьдралын хором бүрд арчсан толь шиг байх юм бол тусгайлан бясалгал хийх шаардлагагүй. Хүүхэд шиг цайлган, урьдчилсан төсөөлөл үгүй, гайхан бишрэх нүдээр харна гэсэн үг. Эрвээхэй хөөж гүйх хүүхэд ямар баясгалантай, ямар дэврүүн билээ дээ. Та нар Бурхан байсан ч тэгэж гүйхгүй, тэгэж баясахгүй. Хэв загвартаа баригдаж, хүүхэд биш том хүн гэдгээ л харуулахыг хичээнэ. Хүүхэд гэдэг нь гайхан бишрэх нүдээр орчлонг хардаг хүмүүс гэсэн үг. Юуг нь мэдэхгүй ч тэр нууцлаг руу үсрэхэд бэлэн цайлган зүрх, гайхан алмайрах харц юм /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 128/.

## **ГАНЦААР ОРШИХУЙ**

*Үзэх: Очир огтлогч*

Будда нөгөө ертөнцийн тухай ярьдаггүй. Тэр зүгээр л энэ ертөнцөд яаж амьдрахыг заадаг. Дотоод чанадын хоосон чанараа элдэв түйтгэрээр хааж халхлалгүй сэрүүн тунгалаг, сэрэмж төгөлдөр байхыг сургадаг. Энэ ертөнцөд сэрүүн тунгалаг оршиж чадах юм бол ертөнц чам руу халдаж чадахгүй.

Нөгөө ертөнцийн гэгдэх шашин суртахуун бүхэн хүчирхийлэгч, дарангуйлагч, садо-мазохист, товчдоо гаж шинжтэй. Буддагийн шашин суртахуунд тэс өөр эрүүл оюун санааны анхилга бий. Энэ бол ягшмал үзэлгүйн анхилга, хоосон мөрөөдөлгүйн анхилга, нөгөө ертөнцгүйн анхилга. Анхилам цэцгэнд одоо л буй. Хаа холоос хайж тэнүүчлэх хэрэггүй. Бүх зүйл хэдийнээ заяагдсан. Зүгээр л нүдээ нээж, сонороо тавь. Хараа чинь хурц болохын хэрээр гэрэл тодорно. Сонор чинь соргог болохын хэрээр аялгуу ундарна. Энэ бүхэн чиний хэр зэрэг сэхээлэг байхаас шууд хамааралтай. Ухамсар сэхээгээ алдах юм бол оршихуйг ч алдах болно. Нойронд автах юм бол, мансууралд живэх юм бол алдаж таараа. Сэхээлэг байх, эс байхын ялгааг сайтар анзаараад үз. Сэхээлэг үедээ чи өөртөө үндэслэж, төвлөрсөн байна. Оршихуй чиний орон гэр, буй чанар болсон байна. Сэхээгээ алдсан үед чи үндэсгүй хамхуул, орон гэргүй тэнүүлч болсон байна.

Тийм учир Буддагийн бүх захиас сэхээлэг байхыг онцолдог. Ухамсар сэхээ оршихуйг илчилдэг. Ухамсар сэхээ чамайг бүтээдэг. Чи өөрөөсөө хичнээн хол алдуурсан яваагаа мэдэхгүй байна. Чиний жинхэнэ мөн чанар төсөөлшгүй аугаа, тодорхойлшгүй түүнчилэн чанар. “Би” гэж төсөөлж, тодорхойлж байгаа бүхэн чинь сарниж замхрахад хил хязгааргүй тэр бээр тодорно. Цэвэр мөн чанартаа орь ганцаар үлдэх энэ бясалгалыг Будда “үнэн зөв бясалгал” буюу Саммасамадхи гэж нэрлэсэн юм. Ганцаар байх нь ганцаардах биш гэдгийг санаарай. “Ганцаараа” (alone) гэсэн үгийн гоо сайхныг анзаарч байсан уу? Энэ бол “бүгд” (all), “нэг” (one) гэсэн хоёр үгийн нийлбэр. Орь ганцаар үлдэхдээ чи бүх ертөнцтэй нэгддэг гэсэн үг.

Ганцаар байхад ганцаардал байх боломжгүй. Бүх ертөнцтэй нэгдсэн байхад яаж ганцаардах юм бэ? Тийм учир бусдаас салахвий, амьдралаас тасрахвий гэж санаа зовних хэрэггүй. Нэг ба бүхлийн ялгаа нэгэнт замхрах хойно юундаа бачуурах вэ. Нэг өөрөө бүхэл болж, бүхэл өөрөө нэг болно. Alone гэдэг энэ үгэнд цаглашгүй гоо сайхан бий. Энэ гоо сайхныг Будда Саммасамадхи гэдэг үгээр илэрхийлжээ. Үнэн зөв бясалгал бол үнэмлэхүй ганцаар оршихуй агаад бүхэлтэй нэгдэхийн нэр. Хоосон чанарт уусахад чиний хил хязгаар алга болно. Хоосон чанарт уягдах нэр томъёо, барьцалдах дүр хэлбэр үгүй. Тэрбээр өнгөгүй тунгалаг, жингүй хоосон. Хил хязгаар, зааг ялгаа бүхэн замхрахад чи оршихуйд уусч, оршихуй чамд уусна. Чи өнчин арал байхаа больж, элчилгүй уудам эх газар болно.

Бясалгал бол психоз, невроз, бүх өвчнөөс салахын нэр /Эртний сайхан аялгуу, АГ 15, х 164/.

### **ГЭГЭЭРЭЛ**

Үзэх: *Нирваан*

Ошо: Би олон жил бясалгасан. Зүгээр л дуугүй суугаад юу ч хийдэггүй байв. Тэгээд алхам алхмаар тэрхүү зүгээр л оршдог, юу ч хийдэггүй орон зайд очсон. Зүгээр л оршдог, цэвэр оршихуй, үйлдэлгүй ажиглагч болдог тэр орон зайд хүрсэн. Би юу ч хийдэггүй байсан. Хэвтээд л, суугаад л, яваад л байсан. Бүх хүсэл мөрөөдлөө алдсан. Ямар нэг юманд хүрэх, ямар нэг зүйл рүү тэмүүлэх хүсэл байхгүй болсон. Би зүгээр л өөр рүүгээ орчихсон. Гэтэл тэнд хоосон байсан. Хоосон үнэхээр галзууруулдаг юм билээ. Гэхдээ энэ бол Бурханд хүрэх цорын ганц зам. Галзуурахад бэлэн хүн Бурханд хүрдэг юм билээ. Гэгээрэх үедээ би инээж байсан. Бүр хөхөрч байсан. Гэгээрэх гэж үхэн хатан зүтгэхийн утгыг ойлгоод тэр. Энэ бол үнэхээр инээдэмтэй. Бид угаасаа гэгээрсэн төрдөг. Чамд угаасаа байгаа зүйлийг хүсэх хэрэггүй. Чамд байхгүй зүйлийг л авч болно. Харин гэгээрэл бол бидний мөн чанар /Ошо Эр хүний тухай, х 89/. Би гэгээрэх гэж олон төрөл дамжин зүтгэсэн. Хийж болох бүхнийг хийсэн ч бүтэлгүйтээд байсан. Бүтэлгүйтэхээс аргагүй байсан юм билээ. Яагаад гэвэл гэгээрэлд хүрэх боломжгүй. Мөн чанар чинь болсон юманд яаж хүрэх билээ. Чамд нэгэнт байгаа юмыг хичнээн шунаад ч олж авч чадахгүй шүү дээ. Оюун ухаан ямагт нэг юманд зорьж тэмүүлж байдаг. Мөнгө, эрх мэдэл, нэр төрд дурладаг. Гэтэл нэг сайхан өдөр гадаад юманд ханаж цалсан оюун өөр юм руу зүтгэнэ. Түүнийг гэгээрэл, нирваан, чөлөөлөгдөх, бурхан татаж эхэлдэг. Гэвч энэ чинь бас л хүсэл эрмэлзэл. Гадагш чиглэсэн зорилго дотогшилсон гэсэн үг. Үнэндээ хандлага, арга барил чинь өөрчлөгдөөгүй. Чи хуучин дадал зуршилтайгаа хэвээрээ байна гэсэн үг. Би гэгээрэлд хүрсэн өдөр гэж буруу нэрлэлээ. Гэтэл тэр өдөр би юунд ч хүрээгүй. Тэр өдөр бол хүрэх юм үгүй, очих газар үгүй, хийх юм үгүйг л ойлгосон өдөр. Тэр бол би биш байсан. Би гэгээрэлд хүрэх гэж инээдтэйгээр зүтгэж байсан өөрийгээ, бас хүн төрөлхтнийг дооглосон /Ошо Эр хүний тухай, х 90/. Тэр өдөр би хоосроод дүүрсэн. Би оршихоо болиод оршихуй болж хувирсан. Нас нөхцөөд дахин төрсөн. Гэгээрэл гэдэг нойрноос сэрэхүй юм. Гэгээрсэн хүний хувьд бүх амьдрал нь зүгээр л зүүд байдаг /Ошо Эр хүний тухай х108/.

### **ГЭРЧЛЭХ**

Үзэх: *Ажиглах*

### **ГЭТЛЭХ**

Гэтлэх гэдэг нь хүслээс гэтлэхийн утга. Хүслээс гэтэлсэн сэтгэл шинхэнэ оршихуйг үзнэ. Хүслээс ангижрах үед бутархай тусгалууд шүтэн барилдана. Тусгал бүтэн болоход чи чөлөөлөгдөнө. Хүслээс ангид сэтгэл тогтуун дөлгөөн мандал шиг бодит ахуйг буй байдлаар нь тусгана. Энэ бол Бурхан буюу Үнэнийг танихуй. Үнэн эргэн тойрон байвч чи түүнийг тусгах төлөвт оршоогүй байдаг. Зүгээр л энэ агшиндаа хүсэлгүй орш /АГ 11, х 56/.

### **ДАРАНГУЙЛАГЧ**

Үзэх: *Тархи*

### **ДИВААЖИН**

Үзэх: *Там*

*ДИЛОВА Богдын сургаал /Агнистын гэгээ цуврал, Чинадын чинадад номоос/*

- Хүчлэн чармайх хэрэггүй. Энгүүн тааваараа бай. Энэ нь өөртэйгөө битгий байлд, мөн чанараа бүү багла гэсэн үг. Эргэн тойрондоо зан суртал, ёс суртахууны хана бүү босго. Сахилга баттай байх гэж бүү хичээ. Сахилга чангарах тусам хүлээс болно. Сайн дурын шоронд өөрийгөө бүү хорь. Нөхцөл байдалд зохицож сур, түүнтэй урсаж сур. Мөс шиг битгий хөлд. Ус шиг урс. Энгүүн чанар чинь, мөн чанар чинь хаашаа хөтөлнө, тийшээ урс. Хуурамч баггүй энгүүн байж чадвал эрх чөлөө өөрийн чинь мөн чанар болж амтагдана.
- Ёс журмын дагуу явж байгаа хүн мөн чанарынхаа дагуу урсаж чадахгүй /*Ошо Богдын тайлбар, II.Бадралын орчуулга, Чинадын чинадад, х 36*/.
- Амьдралын түг түмэн зовлонг чи тоочиж чадна. Гэвч тэр бүхний үндэс нь мөнөөх зовлон тоочоод байгаа сэтгэл чинь өөрөө. Сэтгэл өөрөө жинхэнэ асуудал. Гамшигийг тус тусад нь арилгах гэж бүү чармай. Тусдаа гамшиг гэж хорвоод үгүй. Сэтгэл л өөрөө гамшиг. Ил байгаа зүйл хэзээ ч жинхэнэ асуудал биш. Жинхэнэ асуудал нь далд байдаг. Үзэгдэж байгаа зүйлтэй тэмцэх нь сүүдэртэй тэмцэхтэй адил. Сэтгэлийн асуудлаа л шийдэх хэрэгтэй. Гагцхүү сэтгэлээс ангижрах нь амар амгалан юм /тэнд, х 47-48/.  
Тийм болохоор сэтгэлээ тайван болгох гэж бүү чармай. Бодлууд чамд хамаарахгүй. Тэд бол зочид, чи харин гэрийн эзэн. Гүн гүнзгий ажиглах тусам гэрийн эзэн, зочин хоёрын ялгаа тодорно. Бодол бүхнийг зочин шиг хүлээж ав. Ирсэн гийчин буцдагийг бүү март. Энэ жамыг мартаж зуурдын юмстай зууралдах аваас чи биш тэд гэрийн эзэн болж хувирна. Угтаа бол чи бээр нэрлэшгүй, дүрслэшгүй ухамсар. Энэ бол жинхэнэ оршихуйн мөн чанар. Ээнэгшин дасаж уягдахаараа л чи сэтгэл болчихдог. Ингэснээрээ чи бие махбод болчихдог. Бодол бол эд юмс, хүч чадал. Гэхдээ чиний мөн чанарт хамаагүй. Бодлууд орж л байна, гарч л байна. Тэр бүхэнд хутгалдах хэрэггүй. Тусгаар хөндий байдлаа хадгал /тэнд, х 118/.
- Үзэн ядалт гэж үгүй, хайрын эзгүйрэл. Уур хорсол гэж үгүй, нигүүслийн эзгүйрэл. Мунхаглал гэж үгүй, Будда ухамсарын эзгүйрэл. Гэрлээ л асаачих. Ухамсраа өөд татвал уур, шунал цөм алга болно. Шунал, хорсол, тачаал, уур бухимдал бүхнийг марталт дагуулдаг. Марталт бол жинхэнэ харанхуй. Чи өөрийгөө мартчихсан явна. Марталт бол өвчин. Ерөндөг нь өөрийгөө санах.
- Юу ч хийлгүй биеэ сулла. Юу ч ярилгүй амаа хамхи. Юу ч бодолгүй сэтгэлээ хоосол /тэнд, х 116/. Нүдээ аньж зөвхөн өөрийгөө мэдэр. Одоо цагт төвлөр. Өнгөрснийг оршуул. Энэ л агшиндаа цэнгэн жарга. Зөвхөн ажигла. Хүсэл шуналыг огоор. Юу ч хийхгүй гэдэг нь идэвхийлэлд автахгүй гэсэн үг /тэнд, 112/.  
Тамхи татдаг бол алгуур аажим тат. Юу хийж буйгаа бүрэн дүүрэн мэдэр. Ингэвэл нэг л өдөр тамхи гараас чинь мултран унах болно. Зүгээр л ухамсарла. Ангижрах арга энэ. Зүгээр л тэнэглэл байсныг ойлгох агшинд чи тамхийг биш тамхи чамайг хаяна /тэнд, х 109/. Хүчээр салвал идэвхийлэл. Нэгээс салаад нөгөөтэй зууралдана. Өмнө нь тамхины донтон байсан бол одоо ойворгон сагсуугийн донтон болно. /тэнд, х 110/.
- Юу ч хийхгүй гэдэг нь идэвхийлэлд автахгүй гэсэн үг. Унтахын тулд хэвтээд л өгдөг биз дээ. Амьдралын турш ам чинь дэндүү идэвхийлжээ. Одоо хамхи.
- Бурханыг ч бүү хүс. Хүсэл бол, мөрөөдөл бол хүлээс. Хүлээс алдуурмагц Бурхан чам дээр өөрөө ирнэ /тэнд, х 121/.
- Чи өөрийн мөн чанараа өвлөж төрсөн. Түүнийг засаж сайжруулах хэрэг огт үгүй. Зүгээр л хэн гэдгээ ухамсарла, тэгээд л гүйцээ. Дотоодод чинь хэн нуугдаастайг ажигла. Хэдийнээ Бурхан байж Бурхан болох гэж гүйгээд л. Хэдийнээ хаан байж хаан болох гэж шаналаад л. Ямархан инээдтэй /тэнд, х 122/.
- Хэрэв чи юунаас ч зуурахгүй бол хоосон чанар алган дээр чинь бууна. Улам тайван налгар бол. Яг энд одоодоо орш. Ирээдүй чухал, зорилго чухал болж хувиралгүй идэвхийллээс

зохиролд ор. Тэр цагт хорвоо ертөнц диваажинд хувирч хоосон чанарын агаарт Будда тодорно /тэнд, х 123/.

- Амьдралаас бие чинь биш сэтгэл чинь ангижрах ёстой. Сэтгэл ангижирвал зах дээр явж байсан ч зах алга болно /тэнд, х 224/. Гадаад ангижрал бус дотоод ангижрал чухал /тэнд, х 222/. Дотоод уяа хүлээсээсээ л сал. “Миний, чиний” гэсэн ойлголт задран унасан цагт л чи садны холбоог тасалж чадна. Хүмүүстэй холбогдсон дотоод уяасаа тасал. Хэн нэгнийг “миний эхнэр, “миний хүүхэд” гэхчилэн бодох ёсгүй. Минийх гэдэг чинь жинхэнэ зүүд /тэнд, х 221-222/.
- Энергээ ертөнцтэй хуваалц. Гэхдээ энэ чинь наймаа байх ёсгүй. Чамд байвал бусдад өг. Харин хонжоо харж хариу горилж өгвөл чи алдана. Бүх наймаачид там руу явдаг /тэнд, х 116/.
- Алхам бүрээ бүрэн дүүрэн ухамсраар хий. Идэх уухдаа ч тэгэж ханд. Өөрийгөө санах ухамсраар ид. Зөвхөн ухамсарла, харин дадал зуршил болговол төөрөлдөнө.
- Сонголт бол хүлээс. Сонголт хийснээр хорвоогийн занганд ордог /тэнд, х 229/. Сонгох нь ижилсэхүйг дагуулдаг. Аливаа юмтай ижилсэхээрээ сүнслиг мөн чанараа алддаг. Уйлахдаа ч өөрийгөө авч үлд /тэнд, х 234/.
- Дотоод ахуй бол гэрч, үйлдэгч биш. Түүнийг үйлдэгч болоход ижилсэл бий болно /тэнд, х 234/. Төвөө бүү алд, бүү март. Тэгвэл үйлдэгч, ажиглагч 2 холилдохгүй. Уйлж дуулж, идэж ууж, нүүж сууж, дурлаж хайрлаж буйгаа хөндлөнгөөс хар, аж. Үзэж буй зүйл рүүгээ үсэрч орох хэрэггүй. Толинд тусавч юу ч үлдэж нялзахгүй. Энэ бол үл ижилсэхүй. Хүлээс уяанаас ангид оршихуй. Толь сонголт хийдэггүй /тэнд, х 238/.
- Омогтой бол түүгээрээ үлд, ичих хэрэггүй. Уур унтуу, шунал тачаал, атаа жөтөө цөмийг нь зүгээр аж. Тэдгээрт бүү ижилс, бүү ээнэгш. Үзэгч байраа хадгал. Чамайг үзэгч болмогц ижилсэл – ээнэгшил арилж үндэс тасарна /тэнд, х 243/. Сэтгэлийн үндэс тасрахад сансрын хүлээс алдарна. Бүх ертөнц хөзрөөр барьсан байшин шиг нуран унана /тэнд, х 244/. Агшин зуур бүх нүгэл хилэнц, мунхаглал, үйлийн үр устана. Энэ бол гэнэтийн гэгээрэл /тэнд, х 246/.
- Сэтгэл санаа, бодол, эмоцтой зууралдвал сэтгэлээс чинад аугаа их сэтгэлийг танихгүй. Бүх юм сэтгэл санааных. Гагцхүү гэрчлэхүй л сэтгэл санааных биш /тэнд, х 246/.
- Сэтгэлээс ангижирсан мөн чанар гэдэг нь чиний жинхэнэ мөн чанар, дотоод ухамсар буюу аугаа их амар амгалан /тэнд, х 248/.
- Үнэн бол чиний дотоод мөн чанар, түүнийг бүтээж болохгүй, нээж л болно /тэнд, х 249/.
- Сэтгэлийн чинадад хүрэхийн тулд сэргэг бай, ажигч бай. Жинхэнэ бясалгал бол гэрчлэхээс өөр юу ч биш. Ямар ч юм хийж байсан түүндээ дасаж уягдалгүй дотоод ухамсар чинь бүхнийг тольдож сууна. Жинхэнэ бясалгал гээч энэ /тэнд, х 249/.
- Үнэнийг нүцгэн дүрээр нь үзэх, энэ бол гэрчлэл /тэнд, х 252/. Энгүүн чөлөөтэй, нүцгэн – энэ бол төгс амирлал /тэнд, х 253/.
- Хүүхэд шиг цайлган бай. Чамд зориулсан Оршихуйн бэлгээс нүүр буруулах хэрэггүй. Авсан, өгсөн гэж бодолгүй зүгээр л өг, зүгээр л ав. Үйлдэл биш учрал гээд бодчих /тэнд, х 270/.
- Ямар ч дүрэмгүй байх нь цорын ганц дүрэм. Энгүүн чөлөөтэй бай. Бүү эсэргүүц. Тэмцэл эхэлмэгц энгүүн байдал алдарна /тэнд, х 272/. Ухамсар, сүнс, бодгаль ахуй бол биет бус хоосон чанартай. Юуг нь эсэргүүцэж, юуг нь хамгаалах юм бэ /тэнд, х 274/. Тэмцэх ч хэрэггүй, тэвчих ч хэрэггүй, зүгээр л байж бай /тэнд, х 276/. Юмсыг өөрчлөх сайжруулах гэж бүү оролд /тэнд, х 277/.
- Ялах, ялагдах хоёрын гадна цэцэглэх эрх чөлөөг мэдэрч, хуваагдмал бус бүхэл оршихуйг өөртөө нээ /тэнд, х 274/.

## **ДИЯАН**

Үзэх: *Барамид 5. Дияан*

## **ДУНДАЖ ЗАМ МӨР**

Хоёр туйлаас ангид амар амгалан, цэвэр тунгалаг орших нь Буддагийн сургасан дундаж зам мөр /Ошо Зам мөр, жам ёс х 127/.

## **ЕГҮЗЭР**

Үзэх: *Аз жаргал*

## **ЕРТӨНЦ**

Үзэх: *Мөн чанар*

## **ЗАЛБИРАЛ**

Үзэх: *Зам мөр: Зөв эрмэлзэл*

Та нарын залбирал бол төвөг ядаргаа. Бурханы эсрэг аминч хүслийн илэрхийллэс өөр юу ч биш. Бурханыг эсэргүүцээгүй юм бол залбирал нэрээр гомдол хүсэлт тавихын хэрэг юун /Зам мөр, жам ёс, х 98/. Бурханд үнэхээр итгэдэг бол өвчин, гай барцад тохиолоо ч түүнийг Бурханы таалал гэж хүлээж авна. Гүрэм засал гэж сүмд очихгүйсэн. Чин сүсэгтэн, номын ёстонд хувийн хүсэл байхгүй /х 99/. Залбирал чинь баяр баясгалангийн морийг хөлөглөж л Бурханд хүрдэг. Бурхан англи, араб, санскрит хэл ойлгохгүй. Бурхан зөвхөн баяр баясгалангийн хэлийг мэддэг /Ошо Зам мөр, жам ёс х 124/. Энэ бол цэцэг, үүл, шувууд, моддын хэл, гол мөрний хэл. Бурхан бүжгийг ойлгодог, хөгжмийг мэддэг. Үгийг тэр мэдэхгүй, аялгууг л мэднэ. Үг хэл хүний бүтээл, баяр баясгалан бол бурханы долгион /тэнд, х 124/. Уйтгар гуниг, дарамт ядаргаатай бурханы номын үйл үйлдэж явснаас шашин шүтлэггүй явсан нь дээр. Бурхан царайг чинь биш зүрхийг чинь харах болохоор хуурах аргагүй. Өр зүрхний ундаргаа юугаар өдөөж /дуу, бүжиг, хөгжим/ цацраана, түүнийгээ л хий.

## **ЗАМ МӨР**

*Оршихуйд 2 төрлийн хууль бий. Нэг нь, бодол сэтгэлийн хууль. Түүгээр чи эргэн тойрноо тамыг бүтээж явдаг.* Андууд атаатан болж, амрагууд өстөн болж, цэцэг өргөст хувирдаг. Хэрэв оюун бодлын хүлээсээс гэтэлвэл нирваан буюу арилсан бурханы орон. Идэвхийлж үйлдэхгүйгээр энхжин өөрөө биелнэ. Эгогоос салж, үйлдэгч сэтгэлээс ангижирвал, амьдралд уусан адарвал Бурханы оронд эргэж ирнэ. Эргэх замаа мэд: Үйлдлээс үчралд, би-гээс би-үгүйд, оюун бодлоос арилсан төлөвт шилжих нь зам мөр билээ / АГ 15, х 143/.

Миний зам бол дундаж зам гэж Будда хэлсэн. Энэ бол хүсэл, хясалын хорвоогоос гэтлэх зам мөр /Эртний сайхан аялгуу, АГ 15, х 86/.

*Бурхан Багш: 8 гишүүнт зам мөр /Ошо Богдын тайлбар, Зам мөр, жам ёс/*

Буддагийн үнэн зөв нь буруугийн эсрэг хандлага биш. “Буруу үй түм, зөв ганц тул бурууг зөв яаж сөрөх вэ” гэж Будда хэлдэг /х 93/. Эрүүл мэнд ганц, өвчин тоо томшгүй. Өвчний эсрэг эрүүл мэнд байдагсан бол тоо томшгүй эрүүл мэнд байхсанж. Зөв буруу ч үүнтэй адил. Буруу тоо томшгүй. Чи ч түүнийг зохион бүтээж болно. Үнэн зөвийг харин зохион бүтээж чадахгүй. Энэ бол бүхэлтэй нэгэн хэмнэлд орших төлөв / Зам мөр, жам ёс, х 94/. Бүхэлтэй зохилдох үедээ чи эрүүл



байна. Бүх ертөнцтэй найрсан зохицож, айзам хэмнэлд орших үед л эрүүл, зөв байна. Үнэн зөв угаасаа байдаг, Бурханаас заяамал. Буруу нь хүний бүтээл /тэнд, х 95/. Бурууг бүтээхээ болих хэрэгтэй. Зөвийг шинээр бүтээх гэж оролдох хэрэггүй. Энгүүн байгаль чанартаа орших юм бол чи аяндаа зөв болно. Өөрийгээ агуу гэгээнтэн, аврал буянтан ч гэж мэдэхгүй /тэнд, х 95/. Хэрвээ тийм мэдрэмж байгаа бол чи гажууд хэвээр байна. Садаа дотор чинь байсаар л байна. /жич: энд Зэнгийн санваартан Негэн Сэнзакийн үгийг ишилье: танд ямар нэгэн юманд хүрчихсэн мэт санагдаж эхэлмэгц та өөрийгээ эхлэлийн цэгээсхэдэн хувь доор байгааг ухаарч бүр ёроолоос нь эхлэх хэрэгтэй болдог. /Д.Т.Сузуки Зэн Буддизм, 2012 он, х 9-10/.

“Зөв” гэдэг бол ямар ч хаалтгүйгээр оршихуйд уусан нэгдсэн төлөв. Будда: “Чи байгаа л бол буруу байна” /Зам мөр, жам ёс, х 95/. “Би” үзэл хашилтыг бүтээдэг /жич: Их Багш Чин Хай: би үзэл бол урагшлах зам дээрх өргөс/. Бүрэн хайлсан үед чи байхгүй, оршихуй л байна. Чи байхгүй бол зөв байна.

Эдгээр 8 гишүүн бол хэрхэн арилж хязгааргүйд уусахыг заасан дохио / Зам мөр, жам ёс, х 95/.

### **1. Зөв үзэл**

**Будда: “Юмсыг яг байгаагаар нь, ямар нэг хэв загварт авталгүй хар” / Зам мөр, жам ёс, х 95/.** Үзэл бодол, итгэл үнэмшилдээ автвас ч бодит ахуйг биш зохиомол төсөөллөө харах болно. Зөв үзэл гэдэг ямар нэг урьдчилсан таамаг, итгэл үнэмшилд үл автахын нэр. Энэ бол үнэнд хүрэхийн цорын ганц зам /х 96/. Будда: “Үнэнийг танихын тулд зүгээр л нүдээ нээ” /х 97/. Нүдээ нээсний дараа юу харахыг тэр ярьдаггүй. Харалган байдлаас салсан хойно үнэнийг бусдын тайлбаргүй өөрөө ойлгоно. Зөв үзэл бол үзэлгүй үзэхүй юм / Зам мөр, жам ёс, х 97/.

### **2. Зөв эрмэлзэл**

**Будда: “Хүслийн эрхээр хяслыг эдэлнэ” / Зам мөр, жам ёс, х 98/.** Хүсэл эрмэлзэл чинь оршихуйтай сөргөлдвөл зовлонгийн шалтгаан болдог. /жич: Их Багш Чин Хай: бид бүхнийг Дээд оршихуйн эсрэг хийдэг/. Оршихуйн эсрэг яваад амжилтанд хэзээ ч хүрэхгүй. Бурханыг ялах хэн ч үгүй / Зам мөр, жам ёс, х 98/. Гагцхүү Түүнтэй хамт байж л ялалтыг үзнэ. Аз завшаан бүр чинь санамсаргүй ч бай Оршихуй лугаа зохилдсон тохиол. Бүтэлгүйтэл бүхэн чинь Оршихуй лугаа тэрсэлдсэний учир юм /х 98/. Учир утгыг таньсан хүмүүнд амин хувийн хүсэл эрмэлзэл үгүй болдог. Иймд хүсэл эрмэлзлээс ангижрах нь зөв эрмэлзэл / Зам мөр, жам ёс, х 98/.

Та нарын залбирал бол төвөг ядаргаа. Бурханы эсрэг аминч хүслийн илэрхийллэс өөр юу ч биш. Бурханыг эсэргүүцээгүй юм бол залбирал нэрээр гомдол хүсэлт тавихын хэрэг юун /Зам мөр, жам ёс, х 98/. Бурханд үнэхээр итгэдэг бол өвчин, гай барцад тохиолоо ч түүнийг Бурханы таалал гэж хүлээж авна. Гүрэм засал гэж сүмд очихгүйсэн. Чин сүсэгтэн, номын ёстонд хувийн хүсэл байхгүй. Учир нь түүнд аминч сэтгэл, тусгаар амьдрал үгүй. Тэрээр ертөнцтэй нэгдэж, хамт урсдаг. Даяар ертөнцийн хувь зохиол түүний хувь зохиол болно. Үүнийг зөв эрмэлзэл гэж Будда хэлжээ / Зам мөр, жам ёс, х 99/.

Зөв эрмэлзэлт хүн гэгээн хутагт болно. Ирээдүйг загварчлах хүсэлгүй тэрээр агшнаас агшинд ая зөнгөөрөө амьдарна. Эрмэлзэлгүй эрмэлзлээр амьдардаг хүн / Зам мөр, жам ёс, х 100/. /жич: Их Багш: Хоосон чанар бол Нирваан. Бүх хүсэл, эрэл, идэвхийллээс хоосорч чөлөөлөгдсөн гэсэн үг. Нирвааны эрэл хүсэл ч замхран арилсан төлөв/.

### **3. Зөв үг яриа**

**Будда:** “Зохиомол биш бодит үнэнийг л ярь. Бусдын бус өөрийн туршлагыг л өгүүл” /Зам мөр, жам ёс, х 100/. Бурханыг өөрөө таниагүй бол түүний тухай бүү ярь. Хуулмал мэдлэгт үнэн байхгүй. Будда олонх асуултанд дуугаа хураадаг. **Будда:** “Зөвхөн өөрийн амссан мэдсэн зүйлийг ярьж бай. Бодит ашиг тустай зүйлийг өгүүлж бай. Утгагүй хийрхэл, шимгүй үгэн дунд төөрөх хэрэггүй. Хэлж ярьж буй бүхэндээ хянамгай ханд” / Зам мөр, жам ёс, х 101/. **Будда:** “Үгэнд алдуурахаас болгоомжил. Чин зүрхнээс хэль гэсэн тэр л зүйлээ хэлж бай” / Зам мөр, жам ёс, х 102/. Өөртөө юу хурааж, өрөөлд юу илгээж буйдаа хянуур ханд. Тийм байж л дотоод төвдөө оршиж амьдарна. Хүмүүс биедээ ч, сэтгэлдээ ч юу таарснаа хүүдийлж явдаг. Чимээгүйд суралц, аниргүйд уус. /жич: Их Багш: наад яриулаад байгаа юм чинь чөтгөр/.

#### **4. Зөв ёс суртахуун**

**Гаднаас үүдсэн ёс суртахуун зөв ёс суртахуун биш, дотроос ургасан нь зөв гэж Будда хэлдэг** /х 103/. Хүмүүний ёс суртахуун гэж боддог зүйл нь нийгмийн болзол нөхцлөөр бий болсон зүйл. **Ухамсар сэхээ бол зөв ёс суртахуун** / Зам мөр, жам ёс, х 104/. Худал хэлдэггүй, хулгай хийдэггүй, сүүлэрдэггүй байж болно. Тэглээ гээд нийгмийн сайн гишүүн болохоос ёс суртахуунтай болохгүй. Ёс суртахуун түүнээс хэтийдсэн агуу чанар. Ёс суртахуунлиг байх нь сайн иргэн байх биш, эрхэм хүн байхын нэр / Зам мөр, жам ёс, х 104/. Сүүлийнх нь нийгэмд огт хамаагүй, гагцхүү дотоод зарчимд хамаатай. Ухамсраар амьдрах нь дадал зуршлаар амьдрахаас хавьгүй чухал. Ухамсар дадал чинь болох учиртай / Зам мөр, жам ёс, х 104/.

**Ёс суртахуун чинь ухаарлаас үүдэх ёстой гэж Будда хэлдэг** /х 105/. **Будда:** “Айдас ч үгүй, шунал ч үгүй бай” / Зам мөр, жам ёс, х 105/. Юмсыг бодитой харах ухамсраас зан чанар аяндаа ургана. /жич: Их Багш: Агуу юмсыг өндөр ёс суртахууны суурин дээр сүндэрлүүлдэг юм/.

#### **5. Зөв аж төрөл**

**Будда:** “Амьдрал маш энгийн байх учиртай” / Зам мөр, жам ёс, х 106/. Шуналд бус бодит хэрэгцээнд суурилсан амьдрал. Хоол унд, орон байр, өмөг түшиг хэрэгтэй. Үүнд буруу юм байхгүй. Аж төрөл чинь хүчирхийлэл байх учиргүй. Амиа тэжээхийн тулд бусдыг хөнөөх, ашиг хонжооны төлөө гараа цусанд дүрэх учиргүй. Мөнгөний төлөө амьдралаа сүйтгэх хэрэггүй. Энгийн амьдрал дахь үлэмжийн сайхныг таашааж сур. Нэхэх тусам тэнгэрийн хаяа холддог. /жич: Их Багш: байгаа бүхэндээ сэтгэл хангалуун бай. Энгийн амьдар/.

#### **6. Зөв чармайлт**

**Будда:** “Бүү хүчил. Гэхдээ бүү залхуур” / Зам мөр, жам ёс, х 107/. **Зөв чармайлт гэдэг нь угтаа чармайлтгүй чармайлт.** Зурж буй зураач, бичиж буй найрагч, тоглож буй хөгжимчин, бүжиж буй бүжигчин, тоглож буй хүүхэд ... ямар ч хүчлэл үгүй. Зөв чармайлт гэдэг нь хийж буй бүхэн чинь зөнгөөрөө бөгөөд зүрхээрээ амтлах таашаал болох учиртай.

#### **7. Зөв анхаарал**

**Энэ бол бясалгалыг тодорхойлсон Буддагийн үг** / Зам мөр, жам ёс, х 107/. Үргэлж одоо цагтаа оршиж, үйлдэл бүрээ ухамсартай хийхийн нэр. Сэрэмж сэхээтэй байхын утга. **Будда:** “Амьсгал бүрээ ухамсарлаж бай”. Юу л хийнэ, түүнээ ухамсарлана, ажна гэсэн үг. Өдөр шөнийн бүхий л үйлээ сэрүүн тунгалаг ухамсрын агаарт үйлдэх нь өөрөө бясалгал юм /х 108/. Бясалгалын тусгай цаг гаргах шаардлагагүй.

**Будда:** “Амьдралаас тусдаа бясалгал байх ёсгүй. Амьдрал, бясалгал 2 нэгдэх учиртай” / Зам мөр, жам ёс, х 108/.

## 8. Зөв самади

Буруу самади байх боломжтой учраас “зөв” гэж тодотгожээ. Ухамсраа алдаж тасрах юм бол буруу самади. Дотоод руугаа гүн орох үед гадна талыг умартаж ухамсраа алдах нь бий. Ердийн үед гадна талаа ухамсарлаж дотоодоо умартаж явдаг. Дотоодоо ухамсарлаад гадна талыг мартвал хөл толгой л солигдсон болохоос нөгөө л хүн хэвээрээ. Энэ бол буруу самади / *Зам мөр, жам ёс*, 108/.

Будда: “Аль нэг туйлд автахгүйгээр гаднаа ч, дотроо ч бүрэн ухамсарлиг байх нь зөв самади” /х 108/. Дотоод ухамсрын чинь гэрэл туяарч, тэрхүү гэрлээр гадна тал чинь дүүрэх учиртай. Чухамдаа зөв самадид гадаад, дотоод гэсэн зааг арилдаг. Хуваагдал буюу хоёрдмол байдлаас даван гарах нь зөв самади” гэжээ / *Зам мөр, жам ёс*, х 108/.

### **ЗҮГЭЭР БАЙХУЙ**

*Үзэх: Барамид 4. Эрч хүч, зориг самбаа, Цэвэр сэтгэл, Эго, Эрх чөлөө, Одоо цаг*

Хамгийн агуу сорилт бол юунаас ч зуурахгүй зүгээр л байх. Өнгөрснийг давтах, ирээдүйг харуулдах шуналгүй энэ агшиндаа орших /АГ 11, х 15/. Ирээд хоосон буцахын хооронд юу хурааж хумих гэв. Зүгээр л бай... Зүгээр байх нь хамгийн агуу гайхамшиг... Буддагийн хэлдгээр Параврүти: Дотогшоогоо эргэ. Дотоод чинад рууаа орох юм бол гаднаас юу ч хүсэн хүлээлтгүй жаргалтайн дэлгэр болохоо мэднэ. Бусдаас гуйланчлах биш харин бусдад түгээх баялагийн эзэн шүү дээ, чи. Даанч хоёр туйлын хооронд савласаар энд-одоог анзаарахгүй явдаг. Цагийн дүүжин шиг горьдлогоос горьдлогүйд, хүслээс хясалд савлана. Хэт их хүсч горилсноос л эсрэг тал нь эсрэг тал нь нөхцөлддөг. Чи горьдлого дунд амьдарч ирсэн. Одоо харин горьдлого чинь дампуураад горьдло үгүйд автжээ. Тэгвэл горьдлогүйгээс ч гэтэлж энд-одоод амьдар. Туйлшрал бүхнээс салж төв дунд зогсох аваас чамтай хамт цаг хугацаа зогсоно. Цаг хугацаа зогсоход бүхий л шунал хүсэл зогсож, жинхэнэ амьдрал эхэлнэ. Жинхэнэ амьдралын хувьд энд гэгч ганц орон зай, одоо гэх цорын ганц хугацаа бий /Эртний сайхан аялгуу, АГ 15, х 85/.

### **ЗҮҮ ТӨӨНҮҮР**

Нэг хүн өстнөө алах гэж сум харваад хөлийг нь оножээ. Хохирогч харин насан туршийн шаналгаа болсон толгойн өвчнөөсөө салжээ. Тодорхой оньс цэгийг хөндөж хатгахад биеийн цахилгаан гүйдэлд өөрчлөлт ордог. 5000 жилийн тэртээх дайсны сум хүн төрөлхтөнд үлэмж гавъяа бүтээжээ /АГ 14, Ай даа, Энэ шүү дээ, х 61/.

### **ЗЭН**

*Үзэх: Барамид 4. Эрч хүч, зориг самбаа, Үнэмлэхүй, Оюун санаа / Оюун ухаан*

Зэн буюу Дияан нь залбирах юмгүй ганцаараа байх утгатай. Дияан гэдэг нь оюун ухаан үгүй байдлыг илэрхийлнэ. Төвлөрөл, бясалгал бүгд байхгүй. Үнэндээ бол ердөө анир чимээгүй, гүн гүнзгий амар амгалан, бүх бодол алга болсон тийм анир чимээгүйг хэлнэ /Ошо Зэн буюу гэгээрэхүйн бясалгал, х 105/. Оюун ухаан бол шорон. Эндээс гарахгүйгээр эрх чөлөөг олохгүй /тэнд, х 106/. Оюун ухааны чинад гарахад би гэх үзэл санаа алга болдог. Яг энэ үед оршихуйтай хил хязгааргүйгээр холбогдсоноо мэдэрч, яг энэ үед дотоодод чинь Зэн цэцэглэдэг. Будда: “зүгээр л мэд, тэгээд өөрийгөө хайхаа болино” /тэнд, х 110/. Сократ: “ өөрийгөө тань” гэжээ. Тэнд таниад байх “өөрөө” байхгүй. Энэ л Зэнгийн хэлээд байгаа юм. Тэнд мэдчихмээр юм байхгүй. Таны алга болох нь өөрөөсөө чөлөөлөгдөх юм. Энэ нь оюун ухаанаар болдог зүйл биш бясалгалаар болдог. Зэн бол бясалгалын бас нэг нэр нь юм /тэнд, х 111/. Таныг шоронд хорьсон бүх хязгаараас гарч хоосон руу үсрэх үед: 1. Та алга болж эхэлнэ. 2. Хамгийн сүүлд тохиолдох зүйл бол та бүхэл болно /тэнд, х 113/. Хоосон бол амьдрал, бас оршихуй /тэнд, х 112/. Зүрх рүү уусч алга болох үед бүхий л оршихуй таны гэр болно. Энэ бол Зэн тохиолдож байгаа хэрэг. Энэ бол дээд эрх чөлөө буюу

өөрөөсөө чөлөөлөлт. Энэ бол гэрлийн чимээгүй шилжилт. Үг хэл үгүй шилжилт. Энэ бол таны билгийн мэлмий нээгдэх үед, та дотоод сэрэл рүүгээ харж эхлэх үед боломжтой. Дотоод сэтгэл рүүгээ харж чадаж эхлэхэд чинь мастерийн ажил дуусна. Алга болж буй зүйлийг бус тохиолдож буй зүйлийг л анхаар. Амар амгалан, хоосноос үүдэн гарч буй зүйлийг л анхаар. Эцэстээ бүх л хорвоо таны дотор багтдаг. Ийм хоосон байдал нь цэвэр бөгөөд хязгааргүй юм. Оршихуйн бүхий л нууц өмнө тань хаалгаа нээнэ. Үүнд эцэс төгсгөл үгүй. Зэн нь танаас тусдаа ямар нэг зүйл биш, та өөрөө юм. Тийм болохоор барьж авахгүй, тохиолдоно. Зэн бол таны мөн чанар. Объект ч биш, субъект ч биш /тэнд, х 114-116/.

Ошо: Зэнгийн мэлмийд юм бүхэн бурханлиг. Цай уух, хувцас угаах, гэр цэвэрлэх гээд үйл бүхнээ дияан болгох боломжтой. Тэгэж гэмээнэ бясалгал амьдралд чинь түгнэ. Өдрийн сэрүүнд төдийгүй шөнийн нойронд нэвтэрч, зүрх лугших, амьсгал хөврөх мэт амьдралын чинь хэмнэл болно. Үүнийг л Зэн зарчим гэдэг /АГ 15, Ай даа, энэ шүү дээ, П.Бадралын орчуулга, эхний нүүр/.

Ошо: Зөвхөн Зэнд нэгэн нандин зүйл биелсэн юм. Тэд эгэл амьдрал, шашинлиг амьдрал хоёрыг зааглаж хуваалгүй харин шүтэн барилдуулсан юм. Зэн маш энгийн аргуудыг бясалгалын увдис болгожээ. Эгэл амьдралыг увдис болгохгүй бол бясалгал чинь амьдралаас зугтах арга саам болно.

Өнгөрснөөс ангижир. Энэ бол хором дутам нөхчих зам. Ирээдүйг бүү таамагла. Энэ бол амьдралд өөрийгээ нээх зам. Өнгөрсөн, ирээдүйгээс ангид энэ агшиндаа, үзүүр ёзоор хоёроосоо зэрэг дүрэлзсэн бамбар шиг бай /Эртний сайхан аялгуу, Агнистын гэгээ 15, П.Бадралын орчуулга, УБ, 2016 он, Уялга үг/. Элдэв хачир чимэггүй, маяг будаггүй энгүүн аясаараа зүрхийг хайлуулах шидтэй гоо үзэсгэлэн мэт амьдрал өөрөө Зэн юмсанж /тэнд, П.Бадрал/. Зэн чамайг хутагт хувилгаан болгох гээгүй, зүгээр л хүн болгоно. Эх сурвалж, байгаллиг унаган төрхөнд чинь буцааж оруулна. Жинхэнэ хүн л жинхэнэ хайртай учирдаг. Үнэнийг хайх хэрэггүй. Өөрөө л чи үнэн болчих /мөн тэнд/.

Зэн бол ая зөн, совин билгийн зам. Чармайлтгүй чармайлтын зам мөр. Оршихуйг ойр холын ялгаагүй тусгагч тунгалаг толь. Тэгэхийн тулд зүүн тархинаас баруундаа шилжих хэрэгтэй. Тэгвэл Очирт суудалдаа Будда номоо айлдахыг сонсоно. Нарс модны дотроос дуурьсах эртний аялгууг анирдана. Тэр бол хэзээ ч үл арилах мөнхийн эгшиглэн. Аль болох эмэгтэйлиг тал руугаа, баруун бөмбөрцөг рүүгээ дөтлөөд бай. Итгэл, хүлцэл, хайрын зүг, Бүхэл оршихуйн зүг нүүгээд бай. Өнчин арал болох гэж тэмцэлгүй, энгүй уудам эх газрын хэсэг бологтун / мөн тэнд, х 17-18/.

Эртний сайхан аялгууг анирдахын тулд өөрөө алга болсийм шиг нам гүм болох ёстой. Орших, эс оршихын зааг арилахад чамайг аялгуу хүрээлнэ. Тэр бол Оршихуйн зүрхэн лугшилт, Бурханы сүмд орох үүд юм /АГ 15, Эртний сайхан аялгуу, эхний хуудас /.

Зэнгийн мэлмийд юм бүхэн бурханлиг. Цай уух, хувцас угаах, хоол хийх, гэр цэвэрлэх гээд үйл бүхнээ дияан болгох боломжтой. Тэгэж гэмээнэ бясалгал амьдралд чинь түгнэ. Өдрийн сэлүүнд төдийгүй шөнийн нойронд нэвтэрч, зүрх лугших, амьдрал хөврэх мэт амьдралын чинь хэмнэл болно. Үүнийг л Зэн зарчим гэдэг /АГ 15, Ай даа, энэ шүү дээ, эхний хуудас/.

ОШО Богд ЗАЗЭН Бясалгалыг үе шаттайгаар тайлбарлажээ:

"Зазэн бол гүн гүнзгий сүлрэл, хоосрол юм; энэ нь угтаа бясалгал ч биш юм, учир нь чи бясалгах үедээ ямар нэгэн зүйл хийх гэж хичээж байдаг: бурханыг санан дурсах, эсвэл өөрийгөө санах гэх мэт. Эдгээр хичээл зүтгэлүүд нь дам уришгийг бий болгодог.

*Чи хаана ч сууж болно, харин харж байгаа зүйл чинь хэтэрхий сэтгэл догдлуулам байж болохгүй. Тухайлбал юмс үзэгдэл нь хэт их хөдөлгөөнтэй байх ёсгүй. Тэдгээр нь сатааруулагч болдог. Чи моддыг харж болно - тэд хөдөлгөөнгүй бөгөөд үзэгдэх байдал нь нэгэн хэвээр байдаг учраас асуудалгүй. Мөн тэнгэрийг харж болно, эсвэл зүгээр л буланд суугаад хана руу хар.*

Хоёр дахь зүйл бол, ямар нэгэн зүйл рүү тухайлан бүү хар - зөвхөн хоосныг л хар, учир нь нүд байна, тэгээд хүн ямар нэгэн зүйлийг харах хэрэгтэй болдог, харин чи юуг ч тухайлан харахгүй. Анхаарлаа юунд ч бүү чиглүүл, бүү төвлөрүүл - ердөө л нэг сарнисан дүр зураг байна.

Энэ нь маш ихээр амраадаг.

Гурав дахь зүйл бол амьсгалаа сулруул. Үүнийг хийх хэрэггүй, тохиолдохыг нь зөвшөөр. Ая зөнгөөр нь байлга, тэгвэл илүү ихээр амрах болно.

Дөрөв дэх зүйл бол биеэ аль болох хөдөлгөөнгүй байлга. Эхлээд биедээ эвтэйхэн байрлалыг ол - дэр, гудас эсвэл юун дээр суумаар байна түүн дээрээ суу, харин нэгэнт байрлалаа олсон бол хөдөлгөөнгүй бай, учир нь бие махбод хөдлөхгүй болоход сэтгэл өөрөө намждаг. Хөдөлж буй биед оюун ухаан мөн хөдөлсөөр байдаг, учир нь бие-сэтгэл бол хоёр зүйл биш юм. Тэд бол нэг ...  
нэг эрчим юм.

Эхэн үедээ энэ нь бага зэрэг хэцүү санагдах болно, гэвч хэдхэн өдрийн дараа л чи ер бусын ихээр баясан таашаах болно. Аажим аажмаар, давхарга давхаргаар сэтгэл багасч эхэлж байгааг чи харна.

Нэгэн агшинд сэтгэл үгүйд чи зүгээр л тэнд байх мөч тохионо.

Бодидарма есөн жил зүгээр л хана руу харж суусан, юу ч хийгээгүй - есөн жилийн турш зүгээр л суусан. Түүхэнд түүний хөлнүүд нь алга болсон гэсэн байдаг. Миний бодлоор энэ нь бэлгэдлийн утгатай. Энэ нь ердөө л бүхий л хөдөлгөөн нь алга болсон гэсэн утгатай, учир нь түүний бүх хүсэл сонирхол алдарсан. Тэр хаашаа ч яваагүй байлаа. Тэнд хөдлөх хүсэл, хүрэх зорилго үгүй байв - харин тэрээр тохиож болох хамгийн агуу зүйлд хүрсэн. Тэр бол энэ дэлхийд хөл тавьсан хамгийн ховор сүнснүүдийн нэг мөн.

Ердөө л нэг хананы өмнө суугаад тэрээр бүхнийг олсон; юу ч хийгээгүй, ямар ч ур чадвар үгүй, ямар ч арга барил үгүй, юу ч үгүй. Энэ нь л цорын ганц арга барил байсан. Хараад байх зүйл үгүй үед аажим аажмаар харах сонирхол чинь замхардаг.

Зүгээр л нэг цулгүй хана руу харснаар, чиний дотор зэрэгцээ нэгэн хоосон чанар, энгийн байдал үүдэн гарна. Ханатай зэрэгцсэн өөр нэгэн хана гарч ирнэ - бодол үгүйн хана."

Зэн бол зүгээр л Зэн. Өөр юутай ч зүйрлэх аргагүй. Хүний ухамсрын ертөнцөд тохиосон хамгийн энгүүн атлаа эгэлгүй гайхамшиг. Энгүүн гэдгийн учир нь Зэн бол мэдлэг буюу оюун ухаанд дулдуйддаггүй. Энэ бол гүн ухаан ч биш, шашин суртахуун ч биш. Эгэл оршихуйг бүхий л зүрх сэтгэлээрээ хүлээн авахуй юм. Өөр ертөнц, чинагуух оршихуйг хүсч мөрөөддөггүй. Түүнд ямар ч хийрхэл, метафизик сонирхол байхгүй. Буй орчлонгоо л бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрдөг. Энэхүү хүчлийн шидээр хорвоогийн эрэг чинадын эрэг болж хувирдаг нь гайхалтай. Тийм болохоор Зэн маш энгийн. Ямарваа хойдын диваажин, бумбын орон, бурханы хутаг бүтээх гэж тэмцэхгүй. Зүгээр л энгүүн, зөнгөөрөө амьдрахыг чамаас хүснэ. Тэр цагт эгэл амьдрал хутагтын амьдрал болдог. Эглийг эгэлгүйд хувиргах нь Зэнгийн ид шид. Амьдралын энгүүн зам мөр урьд өмнө хэзээ ч ийм их өргөл хүндлэл хүлээж байсангүй. Зэнгийн хосгүй чанар үүнд л бий /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 3/. Зэн Буддагаас ч, Лаоаас ч хэтийддэг. Энэтхэгийн билиг ухааны оргил нь Будда бол Хятадын суу залийн оргил нь Лаоз юм. Буддагийн зүрхэн сургаал Лаозын зүрхэн сургаалтай шүтэн барилдсанаар Зэн төржээ /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 3/. Энэ нь зүгээр нэг барилдлага биш төгс уусал нэгдэл учраас Зэн бол Буддын болоод Бумбын ёсны аль ч биш, гэхдээ хоёулаа мөн. Тиймээс Зэнг Зэн Буддизм гэж хэлэх нь учир дутагдалтай. Будда Зэн шиг газар дэлхийлэг биш. Лаоз бол маш дэлхийлэг. Харин Зэн дэлхийлэг төдийгүй дэлхийг тэнгэрт хувиргагч юм /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 3/.

Хүн төрөлхтний ирээдүй Зэнд улам бүр ойртоно. Учир нь Өрнө, дорнын учрал гагцхүү Зэн билгээр хэрэгжих боломжтой. Өрнө бол маш дэлхийлэг, Дорно бол дэлхийгээс тасрамхай. Хэн энд гүүр болж чадах вэ? Будда гүүр болж чадахгүй. Тэр бол цэвэр Дорнын анхилга. Лаоз ч бас чадахгүй. Тэр хэт дэлхийлэг. Хятад бол үеийн үед дорнын гэхээс илүүтэй өрнийн буюу дэлхийлэг хандлага давамгайлж ирсэн орон. Дорно дахинд Хятад анхны коммунист, материалист, бурхангүйн орон болсон нь тохиодлын хэрэг биш. 5000 жил тэд тэнгэрээс дэлхийг, сүнснээс

материйг онцолж ирсэн. Тийм болохоор Лаоз гүүр болж чадахгүй. Лаоз бол Грек Зорбатай илүү төстэй. Будда газар дэлхийгээс тасарсан нэгэн. Түүнээс барих сэжүүр олдхоггүй учраас яаж гүүр болох вэ. Будда, Лаоз хоёрыг нэгтгэдэг учраас Зэн л боломж гэдгийг би хардаг /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 3/. Өрнө, Дорныг шүтэн барилдуулах үр хөврөл хэдийн тэнд байгаа. Аугаа их өнгөрсөн төдийгүй аугаа их ирээдүй Зэнд л байгаа /тэнд/. Зэн өнгөрсөн, ирээдүйн алийг нь ч сонирхохгүй, зөвхөн одоог л эрхэмлэдэг. Чухам тиймээс өнгөрсөн, ирээдүйн хооронд гүүр болж чадна /тэнд/. Одоо бол угтаа цаг хугацаа биш, цаг хугацаанд нэвтэрсэн өнө мөнхийн түрлэг. Зэн одоо-д л амьдардаг. Бүхий л сургаал нь: Хэрхэн одоо-д орших вэ? Нэгэнт улирсан хийгээд хараахан ирээгүйн аль алинд сатааралгүй гагцхүү бодит ахуйд төвлөрөх. Зэнгийн энэ хандлага эрс шулуун боловч олон зүйлд гүүр болж чадна: Өнгөрсөн, ирээдүйн дунд. Бие, сүнсний дунд. Энэ хийгээд чинагуух ертөнцийн хооронд. Эгэл хийгээд бурханлиг оршихуйн хооронд гүүр болж чадна /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 4/.

Зэн үл мэдэхүйг онцолдог. Энэ нь мэдлэгээс ангид байхыг хэлж байгаа юм. Энэ нь цэцэн, тэнгэрийн аль нь ч биш гэсэн үг. Үл мэдэхүйд өөрийн гоо сайхан бий. Энэ бол цэвэр тунгалаг толь, намгүм нуурын мандал мэт эргийн модод, од эрхисийг буй дүрээр нь тусгагч. Ойлгохуй юм. Ойлгохуй нь үргэлж одоо цагт хамаардаг. Ойлгохуйн зүрх нь одоо юм. Ойлгохуй нь цэвэр одоо. Now /одоо/ нь маш гоё үг. Түүний голд ‘О’ үсэг. Одоогийн голт зүрх бол ‘О’ юм. Тэг буюу хоосон чанар. Оюун бодол арилсан үед бүх юм чамайг хүрээлдэг. Гадна, дотногүй хамаг оршихуй нэвт тунгалаг болдог. Энэ нь зөн билгээр сэрэхүй юм. Чиний дотоод гүнд угаас байгаагүй бол яахин сэхээрэх билээ. Энэ бол Зэнгийн үндсэн хандлага. Санаж ав: Үзэл, мэдлэгээс ангижрах нь мунхаг байхын нэр биш. Мэдлэг, мунхаг хоёулангаас нь гэтлэх учиртай /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 11, 12/. Санаж ав: Зэн чамайг хутагт хувилгаан болгох гээгүй. Зүгээр л хүн болгоно. Эх сурвалж, байгаллиг төрхөд чинь буцааж оруулна /тэнд, х 13/.

Өндөр сэнтийд залран суугаад Догэн Зэнжид шавилж байжээ. Нэг удаа Кэйшин түүнээс:

“Зэн багш Хогэн бээр Кэйшин Зэнжид шавилж байжээ. Нэг удаа Кэйшин түүнээс:

- Чи хаашаа явж байгаа юм бэ гэж асуув.
- Хогэн: Би зорьсон газаргүй эргэл мөргөл хийж явна гэв.
- Эргэл мөргөлийн чинь утга учир юу юм бэ нэж Кэйшин Зэнжид асуухад “Мэдэхгүй ээ гэж Хогэн хэлэв.
- Мэдэхгүй нь хамгийн ойрхон гэхэд Хогэн гэнэт гэгээрчээ /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 14/.

Зэнгийн хүн бол зорилгогүй бядагч. Агшнаас агшинд амьдрахдаа тэрээр аясын салхинд хийсэх навч мэт арилсан сэтгэлээр одно. Салхин аясаар тэнгэрт хөөрлөө гэхэд газарт хэвтэх бусдаас илүү гэсэн омгорхол төрөхгүй. Газарт уналаа гэхэд тэнгэрт хөөрөгч бусдаас дутуу гэсэн гоморхол төрөхгүй. Ямар ч учрал түүнд зовлон гутрал болохгүй. Зэнгийн хүн бүх тохиолд ялдаг. Ялагдал дундаа ч ялдаг /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 16/.

Мэдлэг багасахын хирээр алслал ч багасдаг. Юу ч мэдэхгүй болох юм бол ямар ч алслалгүй болж ахуйтай нүүр тулна. Чухамдаа нүүр тулах ч юмгүй, тэр бол чи өөрөө. Тийм учраас Багш хэлжээ: “Мэдэхгүй нь хамгийн ойрхон” /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 18/.

Энэ содон судрыг үргэлж санаж яв. Үл мэдэх болсон агшинд оршихуй, та хоёрын хооронд ан гав үгүй болно. Чи оршихуйг тэвэрч, оршихуй чам руу нэвтэрч, амраг хос шиг, нарны илчинд цас хайлах шиг уусан алдарна. “Мэдэхгүй ээ” гэж хэлэх үедээ Хогэн хэдийн хилийн зурваст ирсэн байж. “Би зорьсон газаргүй эргэл мөргөл хийж явна” гэхдээ тэр нэг алхмын цаана байв. Удаах агшинд алхмын зай ч арилжээ. Багшийг гэрэл тусгаж, гэрчлэх агшинд тэр гэгээрчээ. Эцсийн барьц эгшин зуур алдрахад “Би мэдэхгүй” гэж хэлэх нэгэн ч үгүй болжээ. Зөвхөн аниргүм. Хэлэх ярих юм юу ч үгүй. Гэгээрэл ямагт гэнэтийн байдаг. Учир нь энэ бол идэвхийлж бүтээдэг зүйл биш, эрт угаас байсныг л санаж сэрэхүй юм /тэнд, х 18/.

Зэнгийн Их Багш Догэн сэнтийдээ залрангаа айлдсан эцсийн айлдвар: “In the time of life, there is none other than life. In the time of death, there is none other than death. Амьдрахын цагт амьдралаас өөр юу ч үгүй. Үхэхийн цагт үхлээс өөр юу ч үгүй”. Тайлбар: “Амьдрахын цагт амьдралаас өөр юу ч үгүй”. Түүний хувьд амьдрал л байсан, харин амьдрагч байгаагүй, амьдрагч үгүй амьдарчээ.

Шавь ч ингэж амьдрах учиртай аж. “Үхэхийн цагт үхлээс өөр юу ч үгүй”. Үхэл байвч үхэгч үгүйг айлджээ. Шавь ийм л төвшинд хүрэх ёстой гэсэн санаа аж.

Зэнгийн Их Багш Доген:

- To study the Buddha Way is to study self.

Буддагийн Замналыг судлах гэдэг нь өөрийгээ судлахын нэр.

- To study the self is to forget the self.

Өөрийгээ судлах гэдэг нь өөрийгээ мартахын нэр.

- To forget the self is to be enlightened by everything.

Өөрийгээ мартах гэдэг нь бүх талаар гэгээрэхийн нэр.

- To be enlightened by everything is to free your own.

Бүх талаар гэгээрэх гэдэг нь өөрөөсөө чөлөөлөгдөхийн нэр.

Зэнгийн Их Багш Доген:

Хятадад Буддагийн жинхэнэ, үнэн сургаалыг үе үеийн хуврагууд тасралтгүй уламжилж иржээ.

Хичнээн судар судаллаа ч, чангаар уншлаа ч, Буддагийн нэрийг хашгирч дуудлаа ч Буддагийн жинхэнэ сургаалыг олж чадахгүй юм. Бид бясалгаж суудаг. Сууна, суугаад л байна. Энэ нь нэг ёсондоо далайд орж суугаад усгүй болохыг нь мэдрэхтэй л ижил юм.

Зэнг дадуулах гэдэг нь сүнс үлдэж, бие алга болохыг хэлнэ. Одоо Зэнгээс өөр хоёр дахь, гурав дахь зам гэж үгүй. Зэнг бясалга, ингээд гүйцээ.

Зазен гэхдээ би бээр бясалгадаггүй /хүчлэлгүй/ бясалгалыг хэлж байна. Энэ бол зүгээр Дарма буюу амар амгалан хийгээд аз жаргалангийн үүд юм. Төгс гэгээрэлд хүргэгч бясалгал юм.

Хаврын цэцэг, зун хөхөө, намрын сар, өвлийн хүйтэн цас.. Энэ бүхэн мэдээж байдаг л зүйл. Бүх юм ийм л юм даа. Юмыг яг байгаагаар нь харах, хүртэж мэдрэх нь гэгээрэл. Зазен бол зах хязгааргүй далайн усыг харахтай ижил. Төрөлхийн Будда чанараа олж хүртэтлээ ийм л юм.

Будда дотоодод чинь бий. Буддатай учрах амар биш ээ. Хүн бүр л энийг ч, тэрийг ч хүсч ангаж цангаж явдагтаа л хүрэх юмнаасаа хоцордгийм. Тэгээд замаа олохгүйгээс болж бухимдаж мунхагладаг. Ингэж сохорцгоосон учир хүмүүн бид Буддаг олж үзэж чаддаггүй юм. Ийм л учраас бид энд сууж байна. Бид сууна, дотооддоо Буддатай нүүр тулах хүртлээ суух болно.

Хоол хүнс үгүй байсан ч бид буцалсан ус уугаад Зазенд суух /бясалгах/ болно. Энгийн амьдралыг орхиж, уягдсан бүхнээсээ салах хэрэгтэй. Зөв ба буруу гэх бодлыг орхиж, өөрийгээ ч бодолгүй, бүр гэгээрлийн тухай бодлоо ч орхивол зохино. Бүх төлөвлөгөө /зорилго/ хийгээд бодлоос салцгаа. Үүнийг 'Бодол үгүй байх' гэдэг юм. Бид гэгээрэх гэж зазенд сууж байгаа юм биш. Зүгээр л бясалгацгаа. Энэ л өөрөө гэгээрэл юм.

Үхэл рүү ганцаараа л явна. Харин амьдралдаа хийсэн бүхэн тань дагаж хамт явах болно.

Урвуулах гэдэг нь хүлээж авна, хүлээн зөвшөөрнө гэсэн үг. Өвдөлт, зовлон, үзэн ядалт цөм хүч агуулдаг, яг л тань шиг. Та энэ бүх түгшүүр шаналлыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Би үзлээсээ татгалзах хүртэл тань байсаар л байна. Айдас түгшүүрийг хүлээн зөвшөөрч чадахгүй бол алга болгож чадахгүй. Тухайн нөхцөлд баруун гар тань эрх мэдэл, хүч эзэмшиж байх аваас зүүн гар тань зовлон амсана.

Ошо Богд: Зэнг залбирлаар бус инээдээр ойлгохыг хичээ. Бодлоготой, ноцтой хандлага огт хэрэггүй. Зэн бол ягшмал үзэл, хэвшмэл суртал биш. **Хөнгөн шингэн, цагаан цайлган байх нь Зэн юм. Зүрх хөнгөн, алхаа хөнгөн бай. Шашныг ачаа үүрэх мэт авч явахаа боль** /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 56/.

Зэн асуултыг ч, хариултыг ч сонирхдоггүй. Аливаа үзэл суртал, онол номд автдаггүй. Энэ бол өөрийгээ болоод ертөнцийг огт өөрөөр харах зам мөр – зарчим юм. Энэ бол эсрэг үйлдэл, хариу урвал бус зохирол юм. Зохирол бол үргэлж одоо-д байхуй. Тухайн тохиолыг яг буй байдлаар нь,

оюун сэтгэхүйн гуйвуулгагүйгээр толь мэт тусгах зарчим юм. Үүнд гагцхүү бодлоос ангид ухамсар хэрэгтэй. Зэн хариулт өгөхгүй, харин харах нүдийг л соёрхоно. Харалган хүмүүнд гэрлийн тухай яриа, онол сургаал ямар хэрэгтэй юм бэ. Хариулт эрсэн сониучирхал чинь харалган сохрын тэнэглэл. Түүний оронд *хараа оруулах эм тан, эмчилгээ л хэрэгтэй. Тэр бол Зарчим юм. Будда: “Би гүн ухаантан биш, эмч” гэж хэлдэг. Зэн бол төгс эмчилгээ* /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 58-59/.

Зэнг хичээл шиг заах боломжгүй. Зэн бол мэдлэг биш, номлол биш. Чамайг зүгээр л сэгсэрч сэрээх арга /тэнд, х 62/.

## ***ИДЭВХИЙЛЭЛ***

*Үзэх: Үйлийн үр /Карма*

## ***ИЖИЛСЭЛ***

Энэ үеийн агуу их тантарч Георгий Гуржиев: “Ижилсэл бол цорын ганц нүгэл” гэжээ. Чи өнгөрсөнд ижилсэн уягддаг. Өнгөрсөн бүхэн зүүд. Тэдгээрт уягдалгүй гэрчилж ажиглавал маш нарийн дотоод хараа үүснэ. Өнгөрсөнд хугалдалгүй өөрөөсөө тусгаар байдлаар гэрчил. Хэн нэгний амьдралыг хөндлөнгөөс харж буй мэт ажигла. Хайрттайгаа байгаа дүрийг өөр хэн нэгэн мэт хар. Үзэгдэл өөрт хамаагүй юм шиг өрнөж чи зөвхөн гэрч ажиглагч бологтун. Уурлах нь ижилссэний шинж. Кино үзэж байгаа мэт хар. Чиний мөн чанар бол нэр ч биш, дүр ч биш. Дүр гэсний учир нь тэнд чи биш чини йдүр л байна. Иймээс нэр, дүрээс ангид мөн чанартаа төвлөр. Чи бол нэр, дүрийг тольдогч чинадын ухамсар /АГ цуврал, Нууцын ном, х 78/.

## ***ИНЭЭД***

Инээд бол шашны амин сүнс. Ноцтой зан чанар бол эгогийн араншин, эмгэг төлөв /Эртний сайхан дуунууд, АГ 14, х 103/. Буддагийн инээд алдсан нэг ч дүр хөрөг байдаггүй. Будда инээж хөхөрдөггүйдээ биш. Энэтхэгчүүд шашинд хэт буурьтай ягшмал ханддагийнх. Энэтхэг оюун ухаанд хүлэгдсэн, онол суртлаар дүүрсэн газар. Будда маш энгийн байсан. Түүний хандлага оюун сэтгэхүйн биш оршихуйн байсан. Эрдэмтэн бандит, судлаач цэцлэгчдийн орноос Будда дайжих нь аргагүй. Тэрээр тэс өөр хэмжээсийг авчирсан нь хүмүүсийн мартсан эх сурвалж, энгүүн байхуй байв. Тэрээр хүн төрөлхтөнд асар их тус хүргэсэн. Тэр зүгээр л энгүүн оршихуй – нам гүм, хангалуун жаргалтай, сэрүүн тунгалаг, агшнаас агшинд амьдрагч байсан /тэнд, х 104/. Үнэн мэндлэх үед үгээр илэрхийлшгүй дэлгэр аниргүм байдаг. Эрт орой түүнийг үг болгож, үзэл болгон загварчлах хүмүүс ирдэг. Тэдний загварчлал үнэнийг хөнөөдөг /тэнд, х 105/.

Хүмүүс амьдралыг эмгэнэлт туульс, эмгэнэл болгодог. Инээд чинь зүрх, хэвэл буюу дотоод төвөөс оргилохгүй, зүгээр л гадна хүрээнд зурсан зураг төдий /тэнд, х 106/. Цайлган цагаахнаар хүүхэд шиг инээхгүй бол чи амьдралын сайн сайхныг алдаж байна /х 106/. Инээж чадахгүй бол уйлж ч чадахгүй. Инээд нулимс хоёр нэг үзэгдлийн 2 тал /х 106/. Нүд нь чийгээр дутаж хатаж гандсан хүмүүс энэ дэлхийд зөндөө. Инээд бөхөх юм бол нулимс ч бөхнө. Үнэхээр сайхан инээж чаддаг хүн л бас уяхнаар уйлж чаддаг. Тэрхүү дотоод үелзэл хүнийг тэтгэн баяжуулж, ургуулж байдаг юм /х 107/. Онигоо логик биш, түүнд тааварлах аргагүй гэнэтийн эргэлт байдаг нь гэнэ сэнэгүй инээлгэдэг. Энэ бол өдөөж гижигдэх сэтгэлзүйн нарийн арга. Үнэнхүү инээхэд бодол сэтгэл замхарна. Арилсан сэтгэлд орох нь бүх Зэн аргын зорилго. Инээд бол түүнд орох нандин аргын нэг. Үнэхээр бүжиглэх үед бодол зогсдог. Эргэлдэн найгасаар ээрүүл шиг болох үед бүх хил хязгаар зааг ялгаа замхарна. Инээдэнд бүрэн эзэмдүүлэх юм бол бодлын үймээн зогсоно.



Бодол-үгүйд орох олон арга бий: дөлөнд төвлөрөх, хар цэг дээр, тарнид төвлөрөх гм. Гэхдээ бодлоос ангижирч нойрмог будангуйд автах эрсдэлтэй. Бодлоос ангид өөр 2 төлөв бий: нойр ба самади – сатори. Бодол замхарсан хойно нойронд автаж болох, эсвэл сэрүүн тунгалаг саторид орших /х 108/. Инээдний сайхан нь нойронд үл автахад оршино.

Инээхийг хүсч байвал уйлахад ч суралцах ёстой. Уйлж чадахгүй бол инээж ч чадахгүй. Жинхэнэ хүн – тэнцвэртэй хүн бол инээдэг ч, бас уйлдаг ч хүн. Баяр жаргалаар халгиж цалгих мөртлөө бас нам гүмд уусдаг хүн. Хоёр туйлын шүтэн барилдлагаас тэнцвэрт төлөв ургадаг. Энэ бол зорилго юм шүү /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 124/.

### **КУНДАЛИН**

Хүний тухайд эрчим хүч кундалин хэлбэртэй /Ошо Эзотерикийн сэтгэлзүй, х 46/. Кундалин гэдэг нь махбод ба сүнсний хуримтлагдсан энерги. Кундалин нь дотогш чиглэсэн эрчим хүчний урсгалыг тэмдэглэсэн үг. Дотогш чиглэсэн эрчим хүчний энэхүү урсгал нь цорын ганц хувьсгал, цор ганц эрх чөлөө мөн /тэнд, х 60/. Кундалин нь хүний эрчим хүч, харамсалтай нь түүний маш бага хэсэг л үйл ажиллагаа явуулдаг /тэнд, х 47/. Энэ жаахан хэсэг нь ч тэнцвэртэй бус, байнга зөрчилд байдаг. Кундалин нь таны эрчим хүчийг тэмдэглэх нэр томъёо:

- Нэгдэлд байх үеийг тэмдэглэнэ.
- Хөдөлгөөнд байх үеийг тэмдэглэнэ.
- Зөрчилгүй байх үеийг тэмдэглэнэ.
- Бие, оюун ухаан 2 хамтран ажиллаж органикаар нэг нэгнээ нөхөн сэлбэж байхыг тэмдэглэнэ.

Эрчим хүч доош урсах нь гадагшлах, дээш урсах нь дотогш урсах хөдөлгөөн. Хэдийчинээ эрчим хүч дээш өөдөө өгсөнө, төдийчинээ дотогшоогоо гүнзгийрч байдаг /тэнд, х 49/. Дотогш урсаххаас нана бид зүгээр л амиа хорлоцгоож байдаг /тэнд, х 50/.

Кундалин мушгираад унтаж байдаг. Түүнийг сэрээх арга нь:

- Пранаяна /амьсгалаа хянах/ /тэнд, х 54/.
- Залбирал
- Хайрлах
- Гүнзгий амьсгаа
- Бясалгал /тэнд, х 69/
- Падмасана буюу Бадамлянхуа суудал /эрчим хүч хамгийн бага шаарддаг, газрын татах хүч үйлчилдэггүй, хүн дэлхийтэй нэг болдог, тэнд, х 55/.

Эрчим хүч дотогшоо урсаж байхад /тэнд, х 55/:

- Амьсгал чөлөөтэй, хэмнэлтэй, тэнцвэртэй байдаг.
- Заримдаа амьсгаа тасарсан мэт.
- Эрчим хүч шаардлагагүй үед амьсгал зогсдог /самади/.

Оюун ухааныг ухамсарлах аргаар, махбодийг асана, пранаяна йогийн аргаар өөрчилнө /тэнд, х 60/. Ямар нэг тодорхой юмыг ухамсарлахгүйгээр орших цэвэр ухамсрын төлөв буюу нэгэн агшнаа оюун ухаан, махбод нэг болж хоорондоо ямар ч зөрчилгүйгээр синхрон төлөвт очиход та махбод ч биш, оюун ухаан ч биш болно /Ошо Эзотерикийн сэтгэлзүй, х 60/.

### **МАРТАХ / ОЙ САНАМЖ**

Санах ой чинь суларч байгаа нь хуримтлуулсан маш их хог новш чинь бясалгаад ирэхээр замхарч буй хэрэг /Эртний сайхан аялгуу, АГ 15, П.Бадралын орчуулга, УБ, 2016, х 152/. Дотоодод чинь шинэ орон зай үүснэ. Тийм орон зайд улам сэргэлэн, сэхээлиг байх боломжтой. Сэргэг сэхээлиг байхыг л билиг гэж ойлго. Өөрийгээ тэнэгхэн хүүхэд шиг мэдэрч байгаа нь Бурханы оронд хүрэх зам. “Энэ ертөнцийн хувьд мангуу юм шиг байж л учирзүйгээс хэтийдсэн Даогийн замыг ойлгоно” гэж Лууз хэлсэн /тэнд, х 153/.

## **МАТЕРИ**

Энергийн сүлжээ л материйг бүтээдэг гэж физик хэлж байна. Биет чанарт субстанц алга гэж тэд хэлж байна /*Ошо Богдын тайлбар, П.Бадралын орчуулга, Чинадын чинадад, х 27/*.

*/Жич: Биет чанарт субстанц = би/*

## **МАХАМУТАР**

Махамутар бол хоосныг мэдрэхүй. Чи байхгүй гэсэн үг. Чи байхгүй бол хэн өвдөж зовох вэ? Хэн өтөлж үхэх вэ? Хэн уурлаж тэчъяадаж гуних вэ? Хэн хөөрч баясах вэ? Будда: “Хэрэв өөрийгөө жаргалтай гэж мэдэрвэл эргээд зовлонг ч мэдрэх болно. Учир нь чи өөртэйгөө зууралдсаар байна”. Өөрийгөө хоосон гэж таньвал, би-үгүйд бүрэн дүүрэн уусвал жаргал ч үгүй, зовлон ч үгүй болно. Энэ бол жинхэнэ амар амгалан. Хүн яг сонгины хальс шиг. Сэрэл мэдрэмж, бодол төсөөллийнхөө багийг хуулаад үз. Цаана нь юу ч үгүй хоосон /*Ошо Богдын тайлбар, П.Бадралын орчуулга, Чинадын чинадад, х 28/*. Ухамсраас бодлыг чинь салгачихвал чи алга болно. Сэрэл мэдрэмжийг чинь салгачихвал чи алга болно. Зүгээр л вакуум үлдэнэ. Чи байгаа боловч үнэндээ бол байхгүй. Хил хязгааргүй эзгүй хоосон. Энэ үед л Бүхэлтэй нэгдэнэ. Чи үгүй болсон үедээ л Бүхэл болно. Чи байгаа л бол өрөвдөлтэй эго хэвээрээ үлдэнэ. Оршихуйн уудамд нэгдэхийн тулд чи хайлах ёстой. Хоосонд уусч чи хоосорно. Тэгээд хамгаар дүүрнэ. Чи үхнэ, тэгээд Бурхан болно. Чи арилна, тэгээд Бүхэл болно. Оршихуйн далай цэлийнэ /*Ошо Богдын тайлбар, П.Бадралын орчуулга, Чинадын чинадад, х 31-32/*.

## **МАЦАГ**

Пифагор 40 хоног мацаг барьж бясалгасныхаа дараа “Урьд нь би оюун ухаандаа хүлэгдсэн нэгэн байв. Энэ угаалгын хүчээр оршихуйн төв маань өөрчлөгдөж оюунаас зүрх рүү буулаа. Юмсыг зөвхөн толгойгоор цэгнэдэг байсан бол одоо зүрхээрээ мэдэрч байна. Миний хувьд философхоос илүүтэйгээр амьдрал чухал, хийсвэр үнэнээс илүүтэйгээр оршихуйн туршлага чухал болсон” /АГ цуврал, Нууцын ном, х 37/.

## **МЭДЛЭГ**

*Үзэх: Зэн*

Эхлээд мэдэхүй байна. Удаа нь мэдэхүй царцаад мэдлэг болж хувирах үе шат. Гуравт, мэдлэг нь хөлдөөд хэв завар болж хувирах. Гайхан бишрэхүйг мэдлэг хөнөөдөг. Гайхан бишрэхүй нь амьдралын хамгийн нандин эрдэнэ. Энэ чадвараа алдах нь амьдралыг алдаж байгаа хэрэг. Мэдлэгийн тоос сэрэхүйн толийг бүрхдэг. Бясалгал бол сэтгэлийн толио арчихуй юм. 20-р зуун мэдлэгт нэвширтлээ дарагдсан зуун. Тийм учраас шашин алга болсон. Шашин гайхан бишрэхүйд дулдуйддаг. Мэдэхүйгээ мэдлэг, загвар болохыг бүү зөвшөөр. Мэдлэг болмогц нь түүнийг орхиод эргээд хүүхэд бол. Бүгдийг мартаад урагшаа яв /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 128, 129/.

Хэт мэдэгсэд мэдлэгийн ханан дотроо хоригдол болсон байдаг. Амьдралд онол хэрэггүй, үнэнд нотолгоо хэрэггүй. Хуулмал мэдлэг, зээлмэл ухаан бүгд хог новш. Мэдлэгт донтох мархан. Энэ бол аюулт дон, хөнөөлт эмгэг /*Ошо Богдын тайлбар, П.Бадралын орчуулга, Чинадын чинадад, х 24/.*

## **МӨН ЧАНАР**

*Үзэх: Амьдрал, Зэн*

Хүний амьдрал 2 төвшинтэй. Эхнийх нь мөн чанарын, удаах нь тохиолдлын. Мөн чанар төрдөггүй, үхдэггүй. Харин тохиолдлын хорвоо төрж нөхцдөг. Мөн чанар үүрдийн бол тохиолдлын амьдрал зуурдын. Хүмүүн бээр тохиолдлын юмст автаж мөн чанараа умартдаг. Эд хөрөнгө, мөнгө төгрөг, гэр бүл, холбоо сүлбээ бүхэн зуурдын бөгөөд мөн чанарт маань хамаарахгүй. Хүмүүс гүн нойронд автаастай гэж үздэг нь шашны тулгуур үнэн. Энэ нойр биеийн биш дотоод ахуйн нойр. Хэдийгээр хөдөлж, ажиллаж, бодож төсөөлөх боловч хүний амьдрал турш зүүд нойр үргэлжилдэг. Сэрүүн тунгалаг агшин даанч ховор. Хүн робот шиг ажилладаг. Маш дадмаг механик мөртлөө ухамсар сэрэхүй үгүй. Эндээс л бүх зовлон зүдүүр үүсдэг. Хүний бүх зовлон түүний зүүд нойрны бүтээл /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 133/. Зуурдын юмстай ижилсэх хэрэггүй, зүгээр л ажигла /Тэнд, 137/. Юмстай ижилсэхээ болиод эхэлвэл нэг л өдөр мөн чанар лугаа цөмөрнө гэж Гүржиев хэлдэг байсан. Энэ бол ангижралын утга. Ангижрал – санъяас бол хорвоогоос зугтаж Гимлайд юмуу хийдэд бүгэхийн нэр биш. Энд байхдаа гэр орон, эхнэр хүүхдээ өмчилж байсан бол тэнд очоод сүм, шашин суртлыг өмчилнө. “Минийх” гэсэн үзэл хэвээрээ учир дүндээ дүн. Ангижралын жинхэнэ утга нь: Хаана ч байсан юмсыг орхих шаардлагагүй, учир нь анхнаасаа чи тэднийг эзэгнээгүй. Эзэгнэж байсан бол орхиж хаях нь учир утгатай. Угаасаа чинийх биш зүйлийг яаж орхих билээ? Юуг ч эзэгнэж чадахгүйгээ мэдэх нь жинхэнэ огоорол. Юуг ч эзэгнэж чадахгүйгээ мэдэх нь жинхэнэ огоорол. Сайндаа л чи юмсыг ашиглаж болох, түүнд талархах учиртай. Харин эзэгнэж чадахгүй. Тиймээс өмчөөс бус өмчирхөх сэтгэлээс салах нь ангижрал. Гүржиев үүнийг “үл ижилсэхүй” гэдэг /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 138/. Юмстай ижилсэхээ больчихвол тэмцэх ч шаардлагагүй /тэнд, х 140/. Ертөнц та нарын хүсэл зорилгыг биелүүлэх гэж оршдоггүй. Аминч зорилго бүхэн ертөнцийн зорилгод харшилдаг. Хувийн хүсэл бүхэн Бүхэлийн тааллаас гажууд. Ертөнц жамаараа оршиж, Бурхан тааллаараа үйлдэж байхад урсгал сөрж тэмцэлдэх хэрэг юу байна. Мөн чанарлиг хүн үйлээс ангид. Зуурдлаг хүн л үйлдэгч юм. Санасандаа хүрч, сарвайснаа авсан нь зүгээр л зүүдний аялал байдаг /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 139/. Та нарын хийж буй бүхэн хөзрөөр барьсан байшин, цаасан завь шиг л давалгаанд үйрч алдарна. Юмс чухал биш болсон цагт гагцхүү ухамсар – сүнс чухал болно. Гадна талыг хөөцөлдөхөө больсон хүн дотогшоо сэлж эхэлнэ. Бурханы орон дотоодод маань бий /Тэнд, х 140/. Амьдрал бол төгс, түүнийг хараад энд-одоо Бурхантай хамт гэдгээ ойлгоно. Бүхлийн хувь заяа чиний хувь заяа болно. Оршихуй хаашаа одно, чи тийшээ одно. Амин хувийн зорилго үгүй болсноор чи мугуйд мулгуу нэгэн байхаа болино /тэнд, х 141/. Амьдрах 2 зам: Нэг нь зуурдынх. Бурханы эсрэг Бүхэлийг сөрөх. Нөгөөх нь жинхэнэ амьдралын зам. Ямар ч үймрэл хямрал үгүй баярлаж талархах зам. Зуурдын хорвоод чи тэмцэлдэх хэрэгтэй бол мөн чанарын ертөнцөд зүгээр л бууж өгөх хэрэгтэй. Зуурдын хорвоод эргэлзэх хэрэгтэй. Мөн чанарын ертөнцөд зүгээр л итгэх хэрэгтэй, эргэлзээнээс бүрэн ангид цэвэр итгэл /тэнд, х 142/. “Амжилтанд хүрээгүй бол чи дутуу хүчилж, ахиад жаахан хүчлээд өг” – энэ бол зуурдын хорвоогийн логик. Мөн чанарлаг хүний хувьд хүчин чармайлтын тухай асуудал байхгүй. Оршихуйд хэрхэн итгэж, өөрийгээ хэрхэн сулласан бэ гэсэн л асуулт бий. Чиний талаас өөр хийх зүйл байхгүй /тэнд, х 143/. Ухамсраас бусад бүх юм зуурдынх гэдгийг санаж яв /тэнд, х 149/.

**НАРОВА БОГДЫН СУРГААЛААС**

- Юу ч эрэх хэрэггүй, хаашаа ч явах хэрэггүй. Бэлэн болох гэдэг нь юунд ч бэлдэхгүй, зүгээр л ухамсар сэргэг байх. Чамайг бүрэн сэргэг үед эго хулжина. Чамайг бэлэн болсон үед Бурхан өөрөө чам дээр ирнэ. Бэлэн болох гэдэг нь эргэлзэх сэтгэл огоот арилах юм. Эргэлзээг нухчин дарах гэж бүү оролд. Эрч хүч юу байгаа бүхнээ чин сүсэгт зориул. Бүхий л эрчим хүчээ хайрын зүг урсга. Ямар ч болзол нөхцөлгүйгээр үлэмжийн хайранд өргөл болго.

Боломж: Хэрвээ шавь өөрийн үзэл бодолд автаагүй бол, зөв бурууг дүгнэх өөрийн байр суурийг орхисон бол, хов хоосон, цэв цэвэрхэн болсон бол Боломж бий. Хэрвээ Багшдаа зүрх сэтгэлээ бүрмөсөн тушаасан бол, Түүнд бүрэн төгс бууж өгсөн бол, ямар ч болзолгүй юуг ч хүлээж авахад бэлэн бол Боломж бий /*Ошо Богдын тайлбар, П.Бадралын орчуулга, Чинадын чинадад, х 25/.*

- Зөвхөн чиний зүрх, итгэл, хайр л хэрэгтэй. Түүнийг хүлээж авах нээлттэй хаалга хэрэгтэй. Тархи мэдлэгийн орноос, бярман нарын орноос, номлогч нарын орноос зүрх олох хэцүү /тэнд, х 24/. Хайранд хүчлэл хэрэггүй. Хайрлахын тулд идэвх чармайлт бүхэн илүүц. Хайртай учрахаас биш түүнийг хийж бүтээдэггүй. Йог болохоор Би-г залах гэдэг, хүчил гэдэг. Тантр харин би-үгүйд чиглэдэг /тэнд, х 36/.
- Үл хайхрахуй – энэ бол Алтан түлхүүр.
- Чи үгүй болсон үедээ л Бүхэл болно. Чи байгаа л бол өрөвдөлтэй эго хэвээрээ үлдэнэ. Оршихуйн уудамд нэгдэхийн тулд чи хайлах ёстой. Ард үлдэх мөр, урд зурайх зам үгүй болно /тэнд, х 27/. Өөртэйгөө бүү зууралд /тэнд, х 33/.

## ***НИРВААН***

*Үзэх: Амьдрал, Барамид 10. Төгс ухамсар, Будда, Очир огтлогч*

Будда таны хийсвэр сэтгэлийн зорилт, тэмүүлэл, бүхий л ирээдүйг чинь авч хаяад, эцэст нь бидний салах нэн дургүй, хамгийн дотноссон “би” хүртэхүйг хүртэл үгүй болгодог. Ингээд танд дан ганц цэвэр ухамсар үлдэх ба та цэвэр ариун, гэм буруугүй, цагаан цайлган, онгон хоосон болдог ба Будда үүнийг Нирваан гэдэг. Нирваан нь аливаа зорилго, зорилт бус таны хоосон чанар юм. Хоосон чанар, нирваан, би-үгүй төлөв таныг орхиогүй, дотоодод тань байсаар байгаа /Ошо Гайхамшигт хүмүүстэй хийсэн уулзалтууд, 2014, х 33-34/.

Бүх зүүднээс сэрэхийг л Нирваан буюу гэгээрэл гэнэ /Нирваан, х 75/.

Нирваан гэдэг лааг үлээж унтраах гэсэн үг. Хэрэв бүх хүсэл тачаал байхгүй болвол лаа бас алга болно /Ошо Гайхамшигт хүмүүстэй хийсэн уулзалтууд, х 37-38/. Лааг үлээхэд гэрэл замхрах нь оршихуй үгүй гэсэн үг биш. Тэнгэр, газар шиг ялгааг бүү эндүүр АГ 13, Нирваан, х 140/.

Би үзлээс ангижирсан цагт орчил цуврил зогсож, чи ууршиж арилна. Энэ бол Нирваан /АГ 13, Нирваан, х 140/.

Гадаад, дотоод огторгуйн нэгдлийг Будда Нирваан гэдэг /АГ 13, Нирваан, х 137/. Аливаа юмс хэлбэр нь адилгүй ч чинадын агаарт адил. Түүнийг танин мэдэхийг Нирваан гэдэг /Нирваан, х 76/.

Бурхан Багш: Шороо ч биш, ус ч биш, гал ч биш, хий ч биш... Энэ хорвоо ч, өөр ертөнц ч, нар ч биш, сар ч биш тийм зүйл байдаг юм. Энэ бол ирдэг ч зүйл биш, нэгэн тийш оддогч ч зүйл биш... Түүнд суурь тулгуур гэж үгүй, үндэс язгуур ч гэж үгүй. Энэ бол чухамдаа шаналалын төгсгөл юм. Энэ бол, шавь гар минь Нирваан юм. Ошо: Нирваан бол унтраасан дөл. Нирваан бол оршихуй ба үл оршихуй. Одоо тэр хаа ч үгүй, эсвэл хаа сайгүй /Ошо Эзотерикийн сэтгэлзүй, х 114/.

## ***НОЙР***

Үзэх: Мөн чанар

## **НУЛИМС**

Талархлыг нулимснаас илүү гүн илэрхийлэх арга үгүй. Залбирлыг нулимснаас илүү өндөрт хүргэх жигүүр байхгүй /Ошо Очир огтлогч, х 78/. Нулимс бол дотоодоос чинь гарч буй халгиа цалгиа. Зүрхийг чинь эзэмдсэн их хүч багтаж ядахдаа халин дэвэрдэг юм. Нулимсаар хараа чинь тунгалагшина. Нулимс мэлмэрсэн нүд үнэнийг харах боломжтой /тэнд, х 79/.

## **НҮГЭЛ / БУЯН**

Тамхи угсруулж татдаг шавь зуршлаа хаяж чадахгүй нь, энэ нүгэл үү гэж Ошо Богдоос асуужээ. Ошо Богд: Сохор номингийн довыг уул болгож дөвийлгэх хэрэггүй. Чи угаа уушиглах болхи аргаар амьсгалын ёог хийж байна. Бүдүүлэг хэдий ч нүгэл лав биш. **Ертөнцөд ганцхан нүгэл бий: Үл сэрэхүй. Бас ганцхан буян бий: Сэрэхүй. Юу ч үйлдэж байсан түүндээ гэрчийн байр сууриа хадгалж чадвал тэр даруй үйлийн чанар хувирдаг. Үйл өөрөө гэм ч биш, буян ч биш.** Гадаад үйлдлээс бус үйлийн цаанах ухамсраас бүх зүйл хамаардаг. Ухамсар сэхээгүй үйлдсэн тохиолд нүгэл болно. Мөргөлийг ухамсар сэхээгүй үйлддэг бол мөргөл чинь гэм болно. Гэм нүгэл үйлдлээс бус ухамсаргүйгээс төрдөг. Би чиний тамхийг биш зуршлыг анхааран хэлж байна. Зуршилд авталгүй тухайн нөхцөлдөө зохирч үйлдэх нь эрх чөлөө юм. **Санаж яв: Сайн , муу зуршил гэж үгүй. Зуршил бүхэн муу. Учир нь зуршил чамайг дарангуйлдаг. Чи боол, зуршил эзэн болдог** /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 73-74/. Тамхийг хаясан ч бохь зажлаад эхэлнэ. Амьдрал чинь өөрчлөгдөхгүй. Жинхэнэ асуудал нь зуршил юм /Тэнд, х 75/. Ухамсарлахыг хичээлгүй орхихыг хичээсэн болохоор салж чадахгүй. **Миний зөвлөгөө бол: хүссэн зоргоор тамхил, харин бясалгаж тат.** Зэнгийхэн цайг бясалгангүй уудаг шиг тамхийг бясалгангүй тат /тэнд, х 76/. Юун түрүүн орон байрандаа тамхилах тусгай орчин – тамхины бясалгалын төвхөн, тамхины бурханд зориулсан сүм бий болго. Эхлээд тамхины хайрцгийн өмнө мөргөл үйлд. Түүнтэй мэндэлж сонин сайхнаа хуваалцаж болно. Хайрцгаас тамхиа аажуухан гарга. Яарч болохгүй. Асаагууртаа ч мөргө. Тэр чинь гэрэл шүү дээ, бурханлиг байж таараа. Тамхиа асаагаад аажуухан сор. Тайван ажигла. Энэ зөвхөн тамхинд биш амьдралыг бүх зүйлд хамаарах учир зүй /тэнд, х 77/.

## **ОГООРОГЧ / САНЪЯАСИН**

Үзэх: Амьдрал, Огоорол → Мөн чанар

Тэрээр хорвоогийн амьдрал үр шимгүйг ойлгосон хүн. Буруу замаар амьдарч ирснээ сэхээрсэн хүн. Ингээд яваад байвал амьдралын хамаг аз завшааныг үрнэ гэдгийг мэдээд өөр рүүгээ эргэсэн хүн. Дотогшоо эргэх нь санъяс юм. Энэ бол хорвоо ертөнцийг орхихын нэр биш. Хорвоод амьдрах боловч өөр замаар амьдарна. Надагш бус дотогшоогоо чиглэсэн амьдрал. Тэгснээр чи энергийн баян сан болно. Хангалуун жаргал дунд халгиж цалгисан эрчмээ түгээж эхэлнэ /АГ 14, Эртний сайхан аялгуу, х 176/. Гадаад ертөнцийн хувьд ядуу даржин байж болох ч дотоод баялагаараа чи хаадын хаан байна /х 177/. Сэхээлэг үедээ чи жам ёс, зам мөрт зохилдож таарна. Хэрэв ухамсрын дэнгээ барихгүй бол эргэн тойрондоо там бүтээсээр явах болно /х 177/. Санъясин у ч хийсэн дотоод гэрэлдээ л үйлдэнэ. Тиймээс юу сайн, юу муу гэхчилэн ёсзүйн талаар санаа үл зовно. Сайн нь сүүдэр мэт дагах болохоор дотоод гэрлээ л анхаар. Бясалгалын учир үүнд бий. Хуучин замаараа ухамсар сэхээгээ асааж явахад тэр зам шинэ зам болно. Сэхээлэг байвал улиг болсон хоол чинь амсаж үзээгүй зоог болно. Уйдаг болсон бүсгүй чинь шинэ өнгө гэрэл цацруулна. Дотоод ахуй өөрчлөгдөхөд бүх юм өөрчлөгддөг /х 177/. “Хорвоо” гэхдээ би дотоод харанхуйд чинь тусах ертөнцийг хэлж байгаа юм. Гэрлээ асачих юм бол хорвоо – сансара замхарч гагцхүү Бурхан тодорно. Хорвоо, Бурхан 2 тусдаа юм биш, нэг зүйлийн 2 өөр тусгал. Сэрэх эсэхээс чинь л бүх

зүйл хамаарна /X 178/. Бид төвдөө сүнс маань ив ижил, харин хүрээн тойрогтоо болохоор бие, сэтгэхүй маань анги ондоо. Хүрээ тойрогт биднийг ижил болгох гэж хүчлэх ёсгүй. Бурханаас заяасан хувь чанар хэзээ ч давтагдашгүй. Тийм баялаг чанарыг ухаарч, уг ялгамжааг хүлээн зөвшөөрөх учиртай. Христийнхэн “Цор ганц Бурхан, түүний цор ганц хүү бий” гэнэ. Тийм бол Бурхан туйлын ядмаг болох бус уу. Өөр иш үзүүлэгч, өөр хүү бүтээж чадахгүй юу, Тэр? Оршихуйг ганцаараа төлөөлөх оргил гэж үгүй /x 178/.

## **ОДОО ЦАГ**

*Үзэх: Зүгээр байхуй, Бясалгал*

Хэн нэгэн бус хоосон чанар мэтээр амьдраад үз. Одоод орших нь сэтгэлээс хэтийдэхүй юм / АГ 13, Нирваан, х 145/. Одоо цаг бол цаг хугацааны бус цаггүй мөнхийн хувь. Амьдрал энд одоод л бий. Бурхан энд, одоо л бий. Учир нь Бурхан бол гүн ханамжаас өөр юу ч биш. Хэн нэгэн бус хоосон чанар мэтээр амьдраад үз. Одоод орших нь сэтгэлээс хэтийдэхүй юм / АГ 13, Нирваан, х 149/.

Модыг харахдаа зүгээр л харц бол. Жиргээг сонсохдоо зүгээр л сонор бол. Тэр дууг зүрхэн тольтдоо хүргэж бүх оршихуйдаа түгээ. Далайн нүргээнтэй нэгд, нэгэн хэмнэлд ор. Модыг тэврээд ногоон өнгө, гэрэл эрчмээр амьсгал. Газар хэвтээд хорвоог март. Голыг дотуураа урсга. Аливааг таашаах хором бүрдээ бүрэн төгс уусч бай. Хотол ертөнц өөрөө Бурханы илгээлт. Түүнийг тайлж үнш. Түүний хэлэнд суралц. Энэ бол энд – одоо байхуйн хэл /АГ 13, Нирваан, х 151-152/.

Зорилгогүй амьдарч сурах хэрэгтэй, энэ бол ер бусын сайхан амьдрал. Бүх зорилго замхарч, хүслийн хүлээс алдарч, амьдрал чинь ажил хэрэг биш наадам цэнгүүн болох үед чи гэртээ ирсэн байна /АГ 13, Нирваан, х 157/

Хүн аниргүмийн төлвийг огт тас мартсан. Нам гүмийг таалан баяс. Түүнийг хоосрол биш дүүрэлтээр мэдэр. Энэ бол чиний ухамсрын дүүрэлт, оршихуйн тэлэлт юм /АГ 13, Нирваан, х 159/.

## **ОРШИХУЙ**

*Үзэх:Бясалгал, Зэн*

Бурханаас өөр оршихуй үгүй атал бид Бурханаас бусдыг л тэмтэрч явдаг /АГ 11, х 55/. Оршихуйн замаас өөр суралцах зам байхгүй /АГ 11, х 27/. Би үзэл нь орох зам бол би-үгүй нь гарах зам. Хүсэл шунал орох зам бол хүсэл шуналгүй нь гарах зам /АГ 11, х 36/. Зам мөрийг дадуулахад эхлээд хүсэл үгүй, шунал үгүй, хорсол үгүй зам мөрийг таних ёстой. Эерэг бүхэн чинь хорвоод орох зам. Гарах замын хувьд тэр бүхний үгүйсгэл. Үргэлж шунаж явсан нэгэн шуналгүйг дадуулах бэрх. Хүчлэхээс аргагүй. Ийм идэвхийлэгч нэгэн сайн боловч агуу биш гэж Будда хэлжээ. Жинхэнэ агуу бол тэмцлээс хөндий, сахилаас чөлөөт нэгэн. Тэрээр зөнгөөрөө бодь мөртэй зохилдогч. Зохилдох нь хүчлэлгүй байх. Жирийн хүн хүчлэлгүйгээр хүсэлд автдаг бол тэрээр хүчлэлгүйгээр хүсэл-үгүйд оршдог: Энэ бол Луузын Дао, Буддагийн дхамма. Зохицол найрсалд орсон хүн ертөнцийн хамгийн агуу цэцэглэгч. Тэрээр ухамсрын бадамлянхуа юм /АГ 11, х 37-38/.

Үүний тулд эхлээд сахил дэглэм барьж, дараа нь түүнээс хэтийдэх учиртай. Эхлээд бясалга, хожим нэг өдөр бясалгалаа тайл. Бясалгах сайн, түүнээс хэтийдэх нь агуу. Сайн хүн, буянтан байх сайн, хутагт болох нь агуу. Сайнд ханалгүй агуу ихийг зорь. Би замхарч бүхэлд ууссан нэгнийг агуу гэнэ. Тусдаа хэн нэгэн байхаа больж гагцхүү Бурхан л дотор чинь заларна. Чи тэнд байхгүй,

зөвхөн дао, дхамма л үлдэж буй. Энэ бол Сатчидананда буюу үлэмжийн амар амгалан /АГ 11, х 38/.

Оршихуй нэг атал хорвоо ертөнц олон. Тэр хоёрын дунд хуваагдмал оюун санаа бий. Зүйрлэвэл, аварга модны нэгэн голоос 2 мөчир салаалж, тэдгээрээс үй түмэн жижиг гишүү салбарлах шиг. Оршихуй бол гол мод шиг хоёргүй нэгдмэл. Оюун санааны төвшинд арга билиг – ин ян, эр эм, өдөр шөнө, бурхан чөтгөр, Зэн Ёог гм эсрэг тэсрэг талд хуваагддаг. Хоёрдмолын уг үндэс рүү орох юм бол нэгэн бүхлийг нээнэ. Түүнийг Бурхан, Нирваан... юу ч гэж нэрлэж болно. Харин хоёрдмолын үзүүр рүү явах юм бол тоо томшгүй гишүүт ертөнцөд орно. Оюунаар харж, хүртсэн бүхэн 2 талд хуваагддаг. Цагаан гэрэл призмээр ормогц солонгын 7 өнгөнд задрах мэт. Хорвоо ертөнц бол солонго, оюун санаа бол призм, оршихуй бол цагаан гэрэл юм /Эртний сайхан аялгуу, АГ 15, П.Бадралын орчуулга, УБ, 2016, х 3/.

Чиний оршихуй бол эс оршихуй. Оршихуй гэж хэлэх нь буруу. Учир нь энэ бол ямар нэг юм биш. Ямар нэг юм тэнд байхгүй. Зүгээр л хил хязгааргүй хоосон. Энэ бол анатта буюу би-үгүй. Дотоодод чинь би гэх юм огтоос үгүй. Хоосонд тулгуур хэрэггүй. Энэ бол ухамсрын хамгийн гүнзгий төвшин /АГ цуврал, Чинадын чинадад, х 26/.

Угтаа бол чи нэр ч биш, дүрс ч биш, нэрлэшгүй, дүрслэшгүй цэвэр тунгалаг ухамсар. Энэ бол Оршихуйн жинхэнэ мөн чанар. Дасаж уягдахаараа л чи сэтгэл болчихдог. Дасаж уягдахаараа л чи бие махбод болчихдог / АГ цуврал, П.Бадралын орчуулга Чинадын чинадад, х 51/.

### ***ОЧИР ОГТЛОГЧ***

Гаутама Будда бол буддизмыг үндэслэгч биш харин шашингүйн шашныг үндэслэгч. Шашин биш атлаа шашинлиг чанар. Будда тэр үед балчир байсан хүн төрөлхтөнд эрийн цээнд хүрэх гарцыг нээжээ. Бүх хүн тэр гарцаар нэвтрэхгүй ч нялхасын тойргоос гэтлэх зам буюу хаалгагүй хаалгыг Будда зааж өгсөн юм. Ердийн ухамсар буюу хүний ахуй руу үнэнийг буулгах бус харин хүний ахуйгаас үнэний зүг асах учиртай. Энэ бол Буддагийн эгнэшгүй үйлсийн утга учир.

Очир огтлогч билгийн чинад хүрэх судар бол чинад билгийн аянга мэт хүчээр бут ниргэхийн нэр. Хэрэвзээ өөрийг чинь зөвшөөрвөл Будда энэ аянгыг дээрээс чинь буулгана. Будда өршөөлгүй алуурчин, элбэрэлт эх хоёулаа мөн. Нэг гараараа чамайг хөнөөж, нөгөө гараараа шинэ амь соёрхоно. Хуучин хүн үнс чандруу болж байж л шинэ бодьгал мэндлэх учиртай. Жинхэнэ мөн чанар тодрохын тулд эго үхэх ёстой. Очир огтлогч чинад билгийн утга энэ юм /Ошо Очир огтлогч, х 3-4/. Будда зуурах сэжүүр, барих барьц бүхнийг чинь үгүй хийнэ. Эцсийн эцэст өөртөө хоргодох эго буюу би үзлийг чинь хурааж авна. Цэвэр хоосон чанараас өөр юу ч чамд үлдэхгүй /тэнд, х 4/. Будда бидний өтчирхөл бүхнийг тасар татаж, үзэл суртал бүхнийг хуулж хаяна. Алдаж асгахаас айн дагждаг би-г маань хүртэл хуу хамахад онгон дагшин хоосон чанар л үлдэнэ. Үүнийг Тэр Нирваан гэж хэлдэг. Нирваан бол бүтээж босгодог зүйл биш. Зүгээр л чиний хоосон чанар. Хурааж хумисан бүхнээ алдах агшинд түүнтэй учирна. Өмчлөгч эзэн байхаа больсон цагт хоосон чанарыг нээнэ. Хоосон чанар хаашаа ч хулжаагүй, тэр угаасаа тэнд байсан, гагцхүү та нарын хураасан үй түмэн үйл түйтгэрт хучигджээ. Нирваан хутаг – хоосон чанар чамаас нэг ч агшин холдоогүй. Тиймээс Будда хаа нэг тийшээ хүрэх бус харин энд-одоо л хэрхэн сэхээлэг амьдрахыг заадаг. Сэхээлэг байх нь явах зам, хүрэх зорилго хоёулаа мөн. Чи сэтгэлийг эрхшээж, түүнээс хэтийдсэн цагт л шинэ учралыг үзнэ. Ухамсар сэхээгээ алдах юм бол Оршихуйг ч алдах болно. Тиймээс Буддагийн бүх захиас сэхээлэг байхыг онцолдог. Цэвэр мөн чанартаа орь ганцаар үлдэх энэ бясалгалыг Будда “үнэн зөв бясалгал” /саммасамади/ гэж нэрлэсэн. “Ганцаараа”. Энэ бол “бүгд”, “нэг” гэсэн үгийн нийлбэр. Нэг өөрөө бүхэл болж, бүхэл өөрөө нэг болно /тэнд, х 6-8/. Орь ганцаар үлдэхдээ чи бүх ертөнцтэй нэгддэг гэсэн үг. Хоосон чанарт уусахад хил хязгаар алга болно.

Хоосон чанарт угтаа уягдах томъёо, барьцалдах дүр хэлбэр байхгүй. Тэр бээр өнгөгүй тунгалаг. Жингүй хоосон. Буддагийн бүх гэрээс саммасаммади гэдэг үгэнд товчоологддог. Бясалгагч оршоор байгаа бол хуурмаг бясалгал. Бясалгагч бясалгал дундаа арилах юм бол үнэн бясалгал. Энэ бясалгал чамайг хоосон чанар, орь ганцаар ахуйн төлөвт хүргэнэ /тэнд, х 9/.

Очир огтлогч судар бүхэлдээ үнэмлэхүй хоосон болох аргыг зааж байгаа юм

## **ОЮУН САНАА / ОЮУН УХААН**

Үзэх: *Сэтгэл*

Ошо Богд: “Эгогоос ангижир, оюун ухаанаас гэтэл” гэхдээ арш нар оюун ухааныг огт хэрэглэж болохгүй гэсэн утгаар бус түүнд уягдахаа больсон үед л түүнийг зүй ёсоор, илүү чадварлаг ашиглаж чадахыг онцолдог /АГ 15, х 24/. Оюун ухааныг ашиглах хэрэггүй гэж би хэлдэггүй. Харин оюун ухаандаа бүү ашиглуул гэж хэлдэг. Яг одоо бол оюун ухаан чинь эзэн, чи боол байна. Өөрийгээ оюун ухаан, бие цогц төдийхнээр бодох юм бол боол болж байгаа нь тэр. Чи бол тэдгээр юмсаас хэтийдсэн сүнслэг ухамсар. Бясалгал чамайг эзэн, оюуныг чинь албат болгоно. Оюун ухаан зүгээр л машин шүү дээ. Машиныг эзэн бус эд хэрэгсэл утгаар ашиглах учиртай. Эгогийн хувьд ч адилхан. Түүнтэй бүү ижилс. Тэгээд л гүйцээ. Өөрийгээ бүхэл оршихуйн хувь хэсэг, түүнээс ангид биш гэдгийг санаж бай. Энэ нь танай гэрээс хүн хулгай хийж байхад зүгээр хараад сууна гэсэн үг биш. Халааснаас чинь мөнгө суйлж байхад өөрийн гараас ялгаа юу байхав гээд хэрэггүй царайлахын нэр биш. Харин амарч тавирахаа л бүү март. Бүхлийн хувь хэсэг гэдгээ сэхээрсэн цагт чи оршихуйнд уусан хайлж чадна. Үр дүнд нь чи шинээр төрж, эргээд хүүхэд болж, эрч хүч, баяр жаргалаар дүүрнэ /АГ 15, х 24-25/.

Би та нартай ярилцахдаа оюун ухаанаа хэрэглэдэг. Хэрэглэхээс ч аргагүй. Гэвч өрөөндөө орохдоо түүнийг тайлж цэлмэг хоосон болдог. Хүмүүстэй харьцахдаа үг хэл хэрэглэнэ. Өөртэйгээ байхад үг хэлний хэрэг юун. Нам жимхэн дотоод ахуйдаа уусна. Ямар ч асуулт хариулт хөврөхгүй. Энэ бол ухамсрын ондоо төлөв. Яг одоо миний ухамсар – сүнс оюун ухаанаар урсаж, оюуны механизмыг ашиглан та нартай харьцаж байна. **Бие цогц, оюун ухаан, эго, үг хэл гээд бүх юмыг ашиглаж болно. Гэхдээ ганцхан болзолтой: “Өөрөө эзэн байх”** /АГ 15, х 25/.

Хүн биеийн хувьд өсөвч оюун санааны хувьд нялхас хэвээр үлддэг. Хүний оюун санааны насыг арван гурваас хэтэрдэггүй гэж сэтгэлзүйн ухаанд тогтоожээ. Гаднаа 70 настай өвгөн, дотроо 13-тай жаал хэвээр явдаг гэсэн үг. *Сургуулийн хичээл шиг Зэнгийн ном заах болов уу гэж шавь горилсоор байлаа...* Энэ бол хүн бүрийн түүх. Надад ямар ч үзэл номлол байхгүй. Тиймдээ л ийм олон ном байгаа. Тодорхой нэг үзэл номлолтой бол нэг хоёр ном гаргаад л болооо биз дээ. Гэтэл минийх үргэлжлээд л байна. Номлол бүхэн нэг цагт шавхагддаг. Харин минийх үргэлжлээд л. Намайг шавхаж дуусахгүй. Энд эхлэл ч үгүй, төгсгөл ч үгүй. Та нар үргэлж тэг дунд орших болно. Учир нь би номлогч биш /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 65/. *Сургуулийн хичээл шиг Зэнгийн ном заах болов уу гэж шавь горилсоор байлаа... Гэтэл Дого түүнд ямар ч ном заасангүй...*

**Угаасаа тийм ном байхгүй** /тэнд, х 66/.

Дого шавьд: *“Ирсэн цагаас чинь хойш л би чамд Зэн Зарчмыг зааж байна. /Ном гээгүй зарчим гээжээ/. Өглөө цай авчрах бүрд чинь хүлээж авдаг. Хоол хийж барихад чинь хүртдэг. Өвдөг сөгдөхөөр чинь хариу толгой дохидог. Өөрөөр яаж Зэнг заалгах гээв? Үйлдэл бүрээ ухамсарлаж, тохиол дутамд зохирч байгааг минь анзаарахгүй нойрмог явдаг юмуу чи? Бүх оршихуйд талархаж, учрал бүрийг бүрэн дүүрэн хүлээж авдгийг минь хар л даа. Намайг хараад Зэн зарчмыг аяндаа ойлгоно. Үүнээс өөр ном үгүй. Үлгэр жишээ авч өөрөө түүнчилэн үйлдэх учиртай. Үүнээс*



өөр яаж Зэнг заалгах гээв” гэж Багш хэлсэн байна.. Чи намайг ажигладаг уу гэсэн асуулт ажээ. **Ажиглах, сэхээрэх – Энэ бол Зэнгийн зүрхэн тольт.** Багш: “өглөө бүр цай авчрахад чинь ямар талархалтай хүлээн авч, ямархан бишрэлтэйгээр хүртдэгийг минь анзаардаг уу?. Энэ бол зүгээр нэг цай биш” гэж хэлжээ. Зэнгийн мэлмийд ердийн юм нэгээхэн ч үгүй. Бүх юм ер бус, бүх оршихуй бурханлиг. Зэн мастерууд цай уухыг хүртэл номын хурим болгодог /тэнд, х 67/. Багш: “Хармаар байвал шууд л хар. Бодоод эхэлвэл төөрнө шүү” гэжээ. Бодолд автах нь үнэнээс алдуурч одох зам. Үнэнтэй учирсан бол шууд хар. **Жинхэнэ бодь мөрөөр замнагч бол үйл бүхнээ бясалгал болгодог хүн.** Тэгэж гэмээнэ бясалгал амьдралд чинь түгнэ. **Амьдралын чинь хэмнэл болно. Үүнийг л Зэн зарчим гэдэг /тэнд, х 68, 70/.**

## **ӨГЛӨГ**

Үзэх: Барамид I. Өглөг

Бурхан Багш: "Бурханы төгс бэлгэ билиг нь буяны чуулган, аргын мөр лүгээ шүтэн барилдаж бүтдэг. Иймд бодисадва зөвхөн хоосон чанарт шүтэх учиргүй. Өглөг буян тэргүүтэн арга талд ч дулдуйдах учиртай" /АГ 11, х 139/.

Гагцхүү аргад дулдуйдвал бодисадва эгэл ертөнцийн хүлээсэнд үлдэх болно. Тиймд билиг ухаанаар жолоодсон аргад шүтэх хэрэгтэй. Тийн бодисадва нар аргын увдисаар орчлонг үл орхих атлаа билгийн хүчээр юунд ч үл барьцалдана. Аль ч туйлд үл орших бурханы хутаг эндээс ургадаг” /АГ 11, х 140-141/.

Бурхан Багш: “Бясалгалын амгаланд нэвтрэх аваас тэр даруй бусдад өглөг болгон түгээ. Дэргэд хүнгүй байсан ч нүдээ аниад гэгээн жаргаланг ертөнцөд цацраах хэрэгтэй. Бясалгал, гэгээрлийн тухайд ч өмчлөгч байж болохгүй. Юуг ч өмчлөхөө больсон цагт л үнэний замаар явж чадна” /АГ 13, х 41/.

Бясалгалаа тараахгүй бол алдана гэж Бурхан Багш үздэг. Хэрэв түүнийг түгээж чадахгүй бол бясалгалын төлөвт хүрээгүйн шинж. Бясалгагч төлвийн мөн чанар нь хуваалцах буюу түгээхүй юм. Хэн нэгэнтэй хуваалцаж буй нь бурхантай хуваалцаж буй хэрэг. Учир нь буй бүхэнд бурхан чанар бий.

Эрчим хүчээ бүү шамшигдуул, хуримтлуул гэхдээ Бурхан Багш харамч занг бус билиг ухааныг хэлж байгаа юм. Тэрээр үүнийг хэлэхдээ өөрт байгаа бүхнээ өглөгт зориул, гэхдээ цоорхой сав шиг байж болохгүйг ухааруулжээ. Цоорхой үедээ чи зүгээр л алддаг. Харин өглөг өгөх үедээ эглийг өгөөд энгүй дээдийг хүртдэг /АГ 13, х 48/.

Хотэй Зэн бишрэлтэн, бясалгагчтай таарвал “ганц зоос хайрлаач” гэнэ. Бясалгал бол өглөгт суралцахуй юм гэдгийг үүгээрээ сануулдаг байж. Хэрэв чи бясалгагч бол юуг өмчилж харамлахгүй өглөг болгон түгээх учиртай. Үнэн бясалгагч болох юм бүх амьдрал чинь өглөг болно. Өөрийн нинж хайр, ухаарал сэхээрэл, бие оюун, сүнс гээд л өгч чадах бүхнээ түгээж, түүндээ баясан цэнгэх учиртай. Өгч байгаа нь авч буйгаасаа илүү зол буян хүртдэг. Хотэйн бүх амьдрал өглөг болж хувирсан болохоона. Түүнээс өөр диваажин, тэнгэрлиг амьдрал гэж үгүй р агшин хором бүртээ диваажинд амьдарна /Эртний сайхан аялгуу, АГ 14, х113/.

Гуйранчийн өмнө хааны алтан сүйх зогсоод хаан бууж ирж. Гуйранч юм хайрла гээд алгаа тосоход нь хаан зөрүүлээд юм хайрла гээд өөдөөс нь алгаа тосжээ. Уутаа тэмтрэн байж хааны гар дээр ширхэг будаа тавьжээ. Эрхэм дээдэст үгүй гэж хэлж зүрхэлсэнгүй. Илүүг өгөх боломж байсан ч өгч сураагүй сэтгэл нь өрцөнд зангирчээ. Орой нь олзоо бүртгэхэд будаан чинээ алтан үрэл гарчээ. Өгснийх нть хирээр алтан үрэл хайрлагч хаантай ахин яахин таарах билээ /Эртний сайхан аялгуу, АГ 14, х113/.

Өгснөөрөө улам баяжина, өмчилж харамласнаараа улам ядуурна. Өмчирхүү харамч хүн шиг ядуу гуйрамч энэ хорвоод үгүй. Түүнд хичнээн юм байлаа ч үнэндээ юу ч үгүй. Учир нь өглөг чиний

жинхэнэ баялаг. Өглөг үйлдсэнээрээ чи баялагийн эзэн болно. Тийм болохоор болзол нөхцөлгүй түгээж яв. Харамлаж хав дарсан ч нэг цагт үхэл хуу хамна. Үхэл саналыг чинь асуухгүй, гуйж гувшихгүй, шууд л дээрэмдэнэ. Үхэл хаалга тогшихоос өрсөж өөрт буй бүхнээ түгээ. Дуулж чадах бол аялгуу дуугаа түгээ. Зурж чадах бол уран зургаараа хотлыг баясга. Бүжиглэж чадах бол бүжгээрээ хорвоог дайл. Өөрт чинь юу л байна, ертөнцөд өргө. Сэтгэл байвал өгөх юм мундахгүй /Эртний сайхан аялгуу, АГ 14, х115/.

Хотэй шүтэн бишрэгч, сургаал ном заахыг гуйсан хүний өөдөөс “ганц зоос хайрлаач” гэнэ. “Өг, түгээ” гэхийг өөрөөр яаж ойлгуулах билээ дээ /тэнд, х 115/. Энэ нь түүний бүх сургаал ном ажээ.

Зэн багш таарч Хотэйгээс Зэнгийн утга учир юу вэ гэхэд хүүдийгээ хөсөр хаяад чимээгүй зогсов. Зэн бол яг үүнтэй адил ангижрал гэхийг илэрхийлжээ. Өмчирхөл бүхнээс хэтийдэхийн нэр. Хотэйд уутнаас өөр өмч байсангүй. Хүүдий бол түүний мөн чанарт үл хамаарах зуурдын юм. Тэгвэл Зэнгийн биелэл /Зэнгийн амьдралд хэрэгжсэн байдал/ юу вэ гэхэд нь хүүдийгээ мөрөндөө тохоод аяны замаа хөөжээ. Үүгээрээ тэр хорвоог огооровч хорвоогийн амьдралаас зугтахгүй. Ертөнцөөс ангижравч ертөнцдөө үлдэнэ. Энэ бол жинхэнэ Зэнгийн биелэл гэдгийг дохиолоод хөсөр хаясан хүүдийгээ эргээд үүрчээ. Тэр хүүдийндээ хүлэгдсэнгүй. Дотоод гүндээ тэр хүүдийнээс хол хөндий. Гэсэн ч хорвоод амьдарч байхдаа хүүдийгээ үүрсээр л явах болно/тэнд, х 116-117/.

Зугтах нь ангижрал биш /х 116/. Бүү үягд, гэхдээ эндээ бай. Учир нь энд-одоогоос өөр тохиол үгүй. Энэ ертөнцөөс ангид ертөнц үгүй. Ангижир, гэхдээ зугтах хэрэггүй. Хорвоод атлаа хорвоод бүү хамаар. Олны дүнд мөртлөө оршихуйдаа бай. Хийх ёстой үй түмэн үйлийг хийх мөрдлөө үйлдэгч бүү бол. Эго бүү хураа. Тэгээд л гүйцээ /х 117/.

Зэнгийн биелэлийн мөн чанар нь ангижрал. Биелэл буюу хэрэгжилт нь хорвоод амьдрах мөртөө түүнд үл харъяалагдах юм /х 117/.

Хорвоогийн амьдрал дунд л эсрэгцэл бий, хар захын шуугиан дунд л сорилт бий. Гимлай руу зугтвал жаахан тайврах л байх. Гэхдээ түүнтэй зэрэгцээд ухаан сэхээ чинь бүүдийнэ. Чиний мэдрэх нам гүм Гимлайд хамаарахаас чамд хамаарахгүй. Хорвоо бол сорилго. Зугтахын оронд эндээ байж аяс аясаар аниргүмд нэвтэр. Гимлай явах хэрэггүй, Гимлай өөрөө чам дээр ирэг. Тэгэж хүртсэн амар амгалан чинийх байна /тэнд х 118/. Хорвоогийн хүн байхад ямар ч буруу юм байхгүй. Хорвоогийн хүн мөртлөө хорвоолог бус бай Энэ бол эсрэг тэсрэг туйлын дунд тэнцвэртэй амьдрах ур ухаан. Хутганы ир шиг нарийхан ч гэлээ цорын ганц зам. Тэнцвэрээ алдах юм бол чи үнэнийг ч алдах болно /тэнд, х 118/. Энд-одоо энэ ертөнцдөө оршоод үнэний мөрийг хөө. Дотоод гүнд чинь инээд хөөр үргэлжилсээр байг. Бурхан зүг бүжиж яв. Бурхан зүг инээж яв. Бурхан зүг дуулж яв /тэнд, х 119/.

Нэгэн	ядуу	хүн	Бурхан	Багшаас	асуужээ.
Би	яагаад	ийм	ядуу	байна	вэ?
Бурхан	Багш:	Та	өгөхийг	сураагүй	байна.
Ядуу	хүн:	Надад	юу	ч	байхгүй бол яах вэ?

Бурхан Багш: Өгчхөөр юм танд бий. Тухайлбал танд нүүр царай байна. Та инээмсэглэл өгч болно. Танд ам байна. Амаар бусдад сайхан сэтгэгдэл төрүүлэхүйц магтаал хэлж болно. Танд сэтгэл байна. Бусдад та сэтгэл зүрхээрээ өглөг өгч болно. Танд нүд байна. Нүдээрээ бусдыг сайхан харж болно. Танд бие байна. Биеэрээ бусдад туслах хэрэгтэй. Тиймээс бид бүгд үнэндээ ядуу биш юм. Жинхэнэ ядуу хүн гэдэг бол оюун санаа буюу сэтгэлээрээ ядуу хүнийг л хэлнэ.

**ӨМЧЛӨЛ**

Энэ хорвоог хэн эгээ л усны хөөс, зэрэглээ шиг харна, түүнийг эрлэгийн элч олж үздэггүй. Өмчлөх мэдрэмж эд хогшлоор бус харин бодол санаагаар хэмжигддэг. Эд хөрөнгөтэй мөртөө өмчлөгч биш байж болно.

## **ӨРНӨ**

Өрнө бол сүнслиг ертөнцийн хувьд балчир хүүхэдтэй адил /АГ 13, Нирваан, х 124/.

## **САМАДИ**

*Үзэх: Барамид 4. Эрч хүч, зориг самбаа*

Бурхан Багшийн 8 зөвийн нэг:

### **8. Зөв самади**

Буруу самади байх боломжтой учраас “зөв” гэж тодотгожээ. Ухамсраа алдаж тасрах юм бол буруу самади. Дотоод руугаа гүн орох үед гадна талыг умартаж ухамсраа алдах нь бий. Ердийн үед гадна талаа ухамсарлаж дотоодоо умартаж явдаг. Дотоодоо ухамсарлаад гадна талыг мартвал хөл толгой л солигдсон болохоос нөгөө л хүн хэвээрээ. Энэ бол буруу самади / *Зам мөр, жам ёс*, 108/.

Будда: “Аль нэг туйлд автахгүйгээр гаднаа ч, дотроо ч бүрэн ухамсарлиг байх нь зөв самади” /х 108/. Дотоод ухамсрын чинь гэрэл туяарч, тэрхүү гэрлээр гадна тал чинь дүүрэх учиртай. Чухамдаа зөв саматид гадаад, дотоод гэсэн зааг арилдаг. Хуваагдал буюу хоёрдмол байдлаас даван гарах нь зөв самади” гэжээ / *Зам мөр, жам ёс*, х 108/.

Ошо Богд: “Нүдээ нээж чадахаа болив. Яг мансуурчихсан мэт. Үүнийг нойр гэхэд хэцүү. Самади бол зүүдтэй адилхан гэж Патанжалийн хэлснийг тэгэхэд ойлгосон. Нойрноос ялгаатай нь саматид байхад нэгэн зэрэг унтаа ба сэрүүн байдалд байдаг. Унтсан мөртөө унтаагүй байдалд. Бие чинь бүрэн тавирч, махбодийн чинь эд эс унтаж байдаг. Гэвч ямар ч тоос тортоггүй ухамсрын гал дүрэлзэж л байдаг. Чи туйлын анхааралтай хирнээ бүрэн тайвширсан байдалд, хүчилж хичээгээгүй хирнээ бүрэн ухамсарласан байдалд байдаг. Бие махбод чинь гүн нойрссон, ухамсар чинь идэвхжлийнхээ дээд цэгт тулсан үе. Ухамсрын оргил үе бие махбодийн гүн цэгтэй ингэж хосолдог юм /Ошо Эр хүний тухай, х 100/.

Патанжали гүн нойр, самади хоёрыг төстэй гэдэг. Аль алинд нь хувь чанар – эго замхардаг. Гүн нойронд хам ухамсаргүйн хэсэг болдог. Өвс ургамал, мод мэт болно. Хувь бодгаль чанар тэнд байхгүй. Саматид чи мөн л хил хязгаараа гэж бүхэлд уусах боловч бүрэн сэргэг байна. Зовлон зүдгүүр, ачаа дарамт үгүй сэрүүн тунгалаг /АГ 13, х 87/.

## **САНЪЯАСИН**

*Үзэх: Огоорогч, Амьдрал*

## **САМАДИ**

*Үзэх: Сэтгэл*

## **САММАСАМАДИ**

*Үзэх: Очир огтлогч*

## **САТОРИ**

Үзэх: Сэтгэл

### **САТЧИДАНАНДА / ДАО / ДХАММА**

Үзэх: Хүсэл

### **САХИЛ**

Үзэх: Барамид 2. Сахил, Будда

### **СОНГОЛТ**

Хэрэв шийдвэр гаргахгүй бол нь амьдрал хялбар болно /Ошо Зэн буюу гэгээрэхүйн бясалгал, х 39/. Сонголт хийхгүй бол амьсгалах ч хялбар болно /тэнд, х 40/. Сонголт хийхгүй гэдгээ ухамсарласан ухамсар томхон эрх чөлөө өгдөг. Та Будда, Сосан болно. Тод Сосан болж чадахгүй, харин Сосан мод шиг байж чадна. Тэрээр сонголт хийхгүй гэдгээ бүрэн ухамсарласан нэгэн /тэнд, х 41/. Дотоодод тань сонголт байхгүй болсон цагт оюун ухаан байхгүй болно. Танд ямар нэг илүүд үзэх юм байгаа нь л бэрхшээл /тэнд, х 43/. Ямар нэг санал бодолгүй, илүүд үзэх юу ч үгүй бай /тэнд, х 44/. Дуртай дургүйн тэмцэл бол оюун ухааны өвчин. Иймд дурлал, шашин, эд зүйл, ер юуг ч өөрөөсөө ангид байлга. Хэлсэн болгон чинь гүнзгий хүсэл тачаал болох болно. Бурхан байдаг, байдаггүй ч гэж бүү хэл /тэнд, х 44/.

Сонгохгүй гэх нь өөрөө сонголт, иймд зүгээр л ойлго, ойлгох нь огоорол болно /тэнд, х 46/.

### **СОНСОХУЙ / ХАРАХУЙ БУЮУ ЧИХ / НҮД**

Сонсох нь Бурханы сүмд нэвтрэх үндсэн нууцын нэг. Сонсох нь хүлээцтэй, нээлттэй байхын нэр. Өөрийгөө бүрэн мартагын утга. Бусдыг анхааралтай сонсож байхдаа чи өөрийгөө мартдаг. Өөрийгөө мартаж чадахгүй бол сонсож чадахгүй. Өөрийн би-д баригдсан цагт сонсож буй дүр эсгэхээс биш сонсохгүй. Сонсох үедээ чи нээлттэй үүд, хүлээн авах сав болно. Халдан довтолох, түрэмгийлэх замаар Бурханд хүрэхгүй. Гагцхүү эмэгтэйлиг буюу ин-билиг эрчим болсон үед л Бурханд хүрэх үүд нээгдэнэ. Сонор буюу чих бол бэлгэ тэмдэг. Чих бол нэвт хонгил. Нүд эрэгтэйлиг бол чих эмэгтэйлиг. Нүд аргын тал болох янд, чих билгийн тал инд хамаарна. Бусдыг харах үедээ чи халдан довтолдог бол сонсох үедээ хүлцэж хүлээн авдаг. Хэн нэгэн рүү удаан харах нь бүдүүлэг үйл болдгийн учир энэ. Сэтгэлзүйд үздэгээр 3 сек-ээс илүү харвал нүдээрээ бусад руу хадан довтолсон хэрэг болно. Тэгвэл сонсоход хязгаар байхгүй. Учир нь чих бусад руу халдан довтолдоггүй. Нүдэнд амралт хэрэгтэй учир шөнө аньдаг. Харин чих амрах шаардлагагүй, 24 цаг нээлттэй явдаг. Түрэмгийлэх довтолох нь энерги шаарддаг тул нүд амсхийх хэрэгтэй. Тэгээд л байнга анивчдаг. Харахаа багасгаж сонсохоо нэмэх нь зөв /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 178/. О-Нами бөхөд Багш хэлжээ: “Өнөө шөнө энэ сүмд хонож далайн давалгааг анирд”. Энэ нь сонор болж хувир. Өөр юу ч хийх хэрэггүй. Сэтгэлийн татлаа түтлээ үгүй зүгээр л анирд гэсэн үг ажээ. “Өөрийгөө тийм давалгаан хэмээн төсөөл. Бөх гэдгээ мартаж, өмнөө байгаа бүхнийг хамагч хүчит давалгаа бологтун гэж Багш хэлжээ.

### **СҮНС / УХАМСАР**

Үзэх: Ухамсар

Бие ч биш, сэтгэхүй ч биш атлаа хоёуланг нь тольдогч нэгэн зүйл бий. Энэ бол сүнс буюу ухамсар. Чи бие цогц биш бол яаж эрэгтэй эмэгтэй байх вэ, яаж хар цагаан арьстан байх вэ? Чи оюун ухаан

биш бол яаж Хинду, Христиан болох вэ? Цэвэр ухамсар л байх аваас өөр юутай ч ижилсэх боломжгүй /АГ 14, Ай даа, энэ л шүү дээ, х 34-35/.

## **СЭТГЭЛ**

*Үзэх: Барамид /Өглөг барамид, Бодол, Бясалгал, Би*

Чиний ганцаар байхуй бол өнө мөнхийнх. Ганцаар байхуйдаа орших нь уяа холбоосоос ангижрахын утга. Хорвоогоос зугтах хэрэггүй. Зүгээр л уягдах сэтгэлээс ангижир /Жам ёс, зам мөр, х 24/.

Амьдралын түг түмэн зовлонг чи тоочиж чадна. Гэвч тэр бүхний үндэс нь мөнөөх зовлонг тоочоод байгаа сэтгэл чинь өөрөө юм шүү дээ. Сэтгэл гэж юу вэ? Тэр юунаас бүтсэн юм бэ? Ямар нэг цул биет үү, эсвэл урсгал үйл явц уу? Бодит үзэгдэл үү, зүүд зэрэглээ юу? **Сэтгэлийн мөн чанарыг ойлгохгүй бол чи амьдралын нэгээхэн ч асуудлыг шийдэж дөнгөхгүй.** Тухайн асуудлыг дангаар шийдэх гэж чармайх л байх. Эцсийн бүлэгт санаа тэнгэрт, сачий газарт хэвээрээ үлдэнэ. Яагаад гэвэл **сэтгэлээс тусдаа асуудал байхгүй. Сэтгэл өөрөө жинхэнэ асуудал, жинхэнэ гамшиг. Сэтгэлээс тусдаа гамшиг гэж хорвоод үгүй. Сэтгэлийн асуудлаа л шийд. Сэтгэлээс ангижрах нь амар амгалан.** Эхлээд сэтгэлээ таньчих. Ажигла. Сэтгэл гэж юу юм бэ, хаана байна гээд ажиглаад бай. Зөвхөн бодлын урсгал л байна. Удаан ажиглавал бодлын хооронд зай завсар байгааг олж харна. Гүнд нь орох тусам энэ зай улам цэлийнэ. Бодол, бодол үгүй хоосон... Ухамсар назгай байвал энэ зайг олж үзэхгүй, бодлоос бодол руу үсчинэ. Ийм чөлөөнд л сатори буюу агшин зуурын гэгээтэй учирдаг. Ийм чөлөөнд л эрхэм дээд зочин /Бурхан/ морилно. Бодлын үүлэн сиймхийгээр дотоод чинадын огторгуйгаа олж хар. Энэ бол сатори. Цэв цэнхэр тэнгэр болох нь самади. Саторигаас самади хүртэлх бүх үйл явц зөвхөн сэтгэл рүү хандсан билгийн хараа. Сэтгэл бол цул нэгэн бус, гагцхүү бодлын цуврал. Сэтгэл бодигүй хоосон. Үүнийг ойлгомогц асар их юм өөрчлөгдөнө /Ошо Богдын тайлбар, П.Бадралын орчуулга, Чинадын чинадад, х 47-49/. Угтаа бол чи нэр ч биш, дүрс ч биш, нэрлэшгүй, дүрслэшгүй цэвэр тунгалаг ухамсар. Энэ бол Оршихуйн жинхэнэ мөн чанар. Дасаж уягдахаараа л чи сэтгэл болчихдог. Дасаж уягдахаараа л чи бие махбод болчихдог. Бодол гадных, бодол үгүй нь чинийх. Бодол үгүй нь Буддагийн мөн чанар. Будда болсон хүн бодол үгүй амьдардаг. Тийм болохоор хариуцлага үүрэхгүй. Үйлийн үр хураахгүй / АГ цуврал, П.Бадралын орчуулга Чинадын чинадад, х 51/.

Мөн чанараа танихын тулд сэтгэлээ барьж тогтоох хэрэгтэй. Тэгэж байж чи боол биш эзэн заяагаа ухаарна /АГ цуврал, Нууцын ном, х 66/.

Мил Богд: “Сэтгэлийг хурааваас бүхнийг хураана” /Бүх ном нэг ном гэдэг энэ болой/.

Данзанравжаа хутагт: Энэ сэтгэлийг таньвал гуйранч боловч жаргалтай.

## **СЭТГЭЛЗҮЙ**

*Үзэх: Эртний сайхан аялгуу х 63*

## **СЭХЭЭЛИГ ОРШИХУЙ**

*Үзэх: Ганцаар оршихуй, Очир огтлогч*

Бурхан Багш бээр “Субуди, надад сэхээрэл төрөвч хуран мэдэл нгүй. Учир нь сэрсэн билигтэн хуран мэдэл бүхнээс ангид билээ” /Ошо Очир огтлогч, х 68/.

## **СЭХЭЭРЭЛ**

Үзэх: Түүнчилэн чанар

## **ТАЛАРХАЛ**

Үзэх: Нулимс

## **ТАМ**

Тамд хүрэх зам нь бүхий л хүслээр, сайн хүсэл, итгэл, мөрөөдлөл, янз бүрийн юм, зорилгуудаар дүүрэн байдаг.

Диваажинд хүрэх зам бол төгс хоосон юм.

Сэтгэлээ бүрэн төгс уудалж, бүрэн чөлөөтэй байх ёстой. Бүх дарамтыг хая. Эврестэд хүрэх үедээ бүгдийг хаяж нүцгэрсэн байх ёстой.

Хамгийн жижиг ялгаа, ялимгүй сонголт, тэгээд та хуваагдана. Там, диваажин хоёр бий болно. Үнэнийг харъя гэвэл ямар ч халхавчгүй, байгаагаараа бай /Ошо Зэн – Гэгээрэхүйн бясалгал, х 44/.

## **ТАНТРА**

Хүчлэн чармайх хэрэггүй

Энгүүн тааваараа бай

Хүлээс бүхэн алдрахад

Эрх чөлөөг чи олно /Чинадын чинадад, х 12/. Энэ бол тантрын онцгой зарчим /тэнд, х 35/.

Хар цагааны 2 туйлаас ангижирч, сайхан муухайн зохиомол загвараас салж, огторгуй мэт бүгдэд тэгш түгээмэл орших атлаа эс оршихуйн нууцад нэвтрэх нь тантрын үзэл санаа /тэнд, х 9/.

Тантра бол амьдралыг хэв загварт баригдалгүй чөлөөтэй харах хараа. Сэтгэхүйн оролцоогүйгээр амьдралтай нүүр тулсан уулзалт. Тантра бол аугаа хүлээн зөвшөөрөгч. Юм бүхэнд “тийм ээ” гэж хэлдэг. “Үгүй” гэж хэлдэггүй. Үгүйгээс тэмцэл тулаан эхэлдэг. Чи эго болж хувирдаг. Үгүй байхгүй бол чи юутайгаа байлдах билээ. Зүгээр л даган хөвөх болно. Тантра бол зөвхөн хүлээн зөвшөөрөх, болзол нөхцөлгүй хайрлах юм. Чин сэтгэлээсээ “тийм ээ” гэсэн үг Бурханыг бүтээдэг, Бурханыг гэрчилдэг. Чин сэтгэлээсээ “тийм ээ” гэж хэлэхэд чинь бүх ертөнц гайхамшигт урвалд орно. Тэнд мод чулуу, хүн амьтан, уул ус ч байхгүй болно. Ганц Бурханд бус бүх зүйлд “тийм ээ” гэж хэл. Бурханд тийм гэгчхээд ертөнцөд үгүй гэж хэлдэг. Сая сая хүн үүнээс л болж амьдралаа алдсан юм даа. Тэд Бурханыг хүлээн зөвшөөрөхийн тулд ертөнцийг үгүйсгэдэг. Ертөнцийг үгүйсгэх бус үхүүл /Чинадын чинадад, АГ цуврал, х 127/.

Нэг хөдөө нутагт удтал хур бороо оролгүй байснаас ган гачиг нүүрлэжээ. Нутгийн хүмүүс цөхрөнгөө барж мэргэн ардад хандахаар шийджээ. Мэргэн ард тэдний гуйлтыг сонсоод:

-Надад задгай асар барьж өг. Гурав хоног би тэнд ганцаар сууна тэрээд юу болохыг харъя, хоол унд ч хэрэггүй гэжээ. Гурав дахь өдрийн орой хур бороо асгартал оржээ. Баярлаж хөөрсөн хүмүүс Мэргэн ард дээр ирэн гайхан бахдаж:

-Та үүнийг ямар ид шидээр хийчихвээ, хэлж өгөөч гэхэд нь Мэргэн ард:

-Ид шидсээд байх юм байхгүй ээ. Энэ гурав хоногт би өөрийгөө л эмхэлж цэгцэллээ. Намайг эмх цэгцэндээ орвол хорвоо ертөнц ч эмх цэгцэндээ ордог юм. Тэгээд л ган тайлагдсан байх гэжээ.

**Энэ бол тантрын үг: Чи л өөрөө цэгцэрвэл бүх ертөнц цэгцэрнэ. Чи л эмх цэгцээ алдвал бүх ертөнц эмх цэгцээ алдана.** Гэхдээ эмх цэгцийг хүчээр тогтоох боломжгүй. Хүчээр тогтоосон эмх цэгцийн цаана үймээн хямрал үргэлжилсээр байх болно. Өөрийгөө сайтар ажигла. Хэрэв чи ууртай бол уураа хүчээр барилаа гээд юу өөрчлөгдөж байна. Гаднаа уургүй царайлж хүчлэн инээмсэглэж

болох юм. Гэлээ ч дотор гүнд чинь уур буцалсаар байгаа. Хэзээ нэгэн дурын агшинд дэлбэрч таараа. Ийм аюултай нөхцөлд чиний инээмсэглэл яаж үнэн байх вэ. Энэ чинь өөрийгөө эсэргүүцэж байгаа хэрэг. Өөрийгөө эсэргүүцдэг хүн оршихуйг эсэргүүцдэг.

Ямар ч дүрэм журмаар өөрийгөө бүү дарамтал, энгүүн тааваараа бай. Ийм байхын тулд их зүрх зориг хэрэгтэй. Учир нь энгүүн тааваараа байхыг нийгэм зөвшөөрдөггүй. Үхээнц олонхын адил хэв загвартаа барьж байхыг л хүсдэг. Түүнээс жаахан гажих юм бол ад үзэн хавчих болно.

Тантар бослогоч шашин. Хувьсгалч гэж би хэлэхгүй. Энэ бол нийгэмч улс төрч тэмцэл биш. Зөвхөн хувь хүн өөрөө өөрийгөө чөлөөлөх тэмцэл. Хэв загвар бүхэн боолын дөнгө юм. Боолын дөнгөнөөс мултарсан агшинд чиний өмнө цоо шинэ ертөнц нээгдэнэ. Харалган сохор хүн хараа орох шиг болно. Харалган гэж чиний бодол төсөөлөл, онол таамаг, мэдлэг шүтлэг бүхнийг хэлж байгаа юм. Энэ бүхэнд нүд чинь хаагдаж чих чинь бөглөрсөн. Амь голтой үхдэл болсон. Тантар чамайг амьдруулахыг хүсч байна. Хүн ургамал мод шиг, ус мөрөн шиг, наран саран шиг амьдрах учиртай. Хэв загварын бүрээсийг ярсан агшинд чиний амьдрал эхэлнэ. Жинхэнэ амьдралыг ганц агшин ч атугай амсахад төгс таашаал хүртдэг. Боолын дөнгөнд мянга мянган амьдралыг элээвч юун таашаал байх вэ.

Тантарын ертөнцөд ороход үнэхээр эр зориг хэрэгтэй. Энэ бол аз эз сорьсон алхам. Өдий болтол цөөн хэдхэн хүний явж одсон харгуй. Тантар бол улс төрийн хувьсгалд биш, хувь хүний бослогод уриалдаг. Бослогыг чи орь ганцаараа хийж чадна. Энэ бол нийгмийг эсэргүүцэх биш зүгээр л нийгмийн чанадад гарах алхам. Хэнтэй ч дайтах хэрэггүй. Өөрийн эрх чөлөөг өрөөлөөс бүү эр.

Чи эрх чөлөөт хүн мөн үү? Амьдралаа хар л даа. Мянга нэгэн хүлээс хэрж багласан байна. Гүн гүнзгий шигдсэн болохоор өөрийн салшгүй цогц шигээр ойлгодог байх. Тантрын хэмжээс рүү орж байж л боолчлолын мөн чанарыг танина. Хичнээн гүнд үндэслэснийг нь ухаарна. Энэ ухаарал чинь эрх чөлөөнд тэмүүлэх жигүүр юмаа.

Бүх юм зүгээр байна гэж өөрийгөө хуурах хэрэггүй ээ. Бүх юм чинь зүгээргүй болчхож. Амьдрал чинь нилдээ хар дарсан зүүд болжээ. Ямар ч аялгуу, бүжиг, уянга найраг, талархал, залбирал алга. Хайр, бурхан, баяр баясгалан, амар амгалан... Энэ бүхэн зүгээр толь бичиг дээр байдаг үгс үү? Чи тэр тухай сонсдог ярьдаг болохоос юу гэдгийг нь огт мэдэхгүй. Хамгийн учир утгатай юмс хадны цуурай болж, хамгийн утгагүй юмс чиний амь амьдрал болжээ. Өнгө шилж, мөнгө тоолж явах чинь л утгатай байна уу? Хүний мунхаглалд даан ч хязгаар үгүй. Сэхээрэхгүй бол бүх амьдралаа харанхуй мананд тийн элээнэ. Сая сая хүний золгүй тавиланг давтаад яах вэ. Эцэс төгсгөлгүй мунхагийн тойргоос гарах цорын ганц боломж бол сэхээрэл юм шүү */Ошо Равжниси Тантрын дуудлага номоос/.*

Юу ч хийхгүй энгүүн тааваараа бай */Ошо Богдын тайлбар, П.Бадралын орчуулга, Чинадын чинадад, х 36/:*

- *Өөртэйгөө битгий байлд.*
- *Мөн чанараа бүү багла.*
- *Эргэн тойрондоо зан суртал, ёс журмын хана бүү босго.*
- *Сахилга бат чангарах тусам эго чангардаг. Сайн дурын шоронд өөрийгөө бүү хорь.*
- *Нөхцөл байдалд зохицож сур. Мөс шиг бүү хөлд. Энгүүн дүр чинь, мөн чанар чинь хаашаа хөтөлнө, тийшээ урс.*
- *Загвараасаа бушуу салж өөрийгөө чөлөөл.*
- *Агшин агшинд амьдарч сур.*
- *Авхаалжтай сэргэлэн /соргог/ бай.*
- *Энгийн чөлөөт ухамсраа хадгал. Энгийн тааваараа байх нь ямар ч орчин нөхцөлтэй зохирч, түүнтэй хамт урсаж чадах нууц.*
- *Зүсэн зүйлийн багаа хуулж хая.*
- *Элдэв маягаа тасар тат. Элдэв бүрхээс хучаасаа тайлах л хоосон чанар /Ошо Богдын тайлбар, П.Бадралын орчуулга, Чинадын чинадад, х 38/.*

## **ТАРХИ**

Орчин үеийн судалгаа нэгэн чухал баримтыг нээжээ. Энэ зууны хамгийн чухал нээлтийн нэг. Хүний тархи баруун, зүүн тал бөмбөлгөөс бүрдэг. Буруун тал нь зөн совинч, логик бус, иррациональ, яруу найрагч, төсөөлөгч, романтик, шашинлиг. Зүүн нь тооцоологч, логикч, рациональ, математикч, шинжлэх ухаанч. Энэ 2 тал үргэлж зөрчилддөг. Энэ дэлхийн хамгийн айхтар улс төр чиний дотор өрнөдөг. Анзаарч харвал бүх зүйл энэ 2 талын л хаа нэгтээ шийдэгддэг. Уг хуваагдлыг ойлговол олон зүйлийн учрыг тайлна. Отог омгийн, ядуу буурай хүмүүст ихэвчилэн тархины баруун тал давамгайлдаг. Сэтгэн бодох тал дутмаг байдаг нь ядуу буурай байхын шалтгаан байж магадгүй. Баян хөрөнгөлөг хүмүүст зүүн тал нь давамгайлдаг. Тооцоологч оюун ухаан, олзны шалтгаан буйза. Тэгэхлээр хөрөнгөтөн, пролетари хоёрыг коммунист хувьсгалаар арчиж чадахгүй. Өнгөн тал нь өөрчлөгдөхөөс дотоод агуулга хэвээр үлддэг учир хувьсгал бүхэн хуудуутай. Эзэн хааны үед ч, хувьсгалчдын үед ч нөгөө л зүүн талын оюун санаа жолоог атгасан хэвээр. Эмэгтэй хүн баруун тал, эрэгтэй зүүн талын ухаанд суурилдаг. Зуун зуунаар эрчүүд эрхийг атгаж ирсэн. Орчин үед эмэгтэйчүүд эрх мэдлийн төлөө тэмцэхдээ эмэгтэйлиг шинжээ алдаж зүүн талын ухаанд шилжсэн байдаг. Дарангуйллын эсрэг тэмцээр яваад өөрсдөө дарангуйлагч болдог нь хүн төрөлхтний асар том бэрхшээл. Хувьсгалчид нэг л мэдэхэд дарангуйлагч болдгийн учир энэ. Зөрчилдөөн хүний дотоод ертөнцөд бий. Хүний дотоод зөрчилдөөн арилаагүй цагт гадна талд юу ч шийдэгдэхгүй. Ухааны 2 талын дунд улс төр өрнөдөг. Энд бяцхан гүүр бий. Тэр гүүр ослоос болж, сэтгэцийн эмгэгээс болж эвдрэхэд хүн 2 тусдаа бодгаль болж хуваагддаг. Өглөө ялдам хайр найр мөртөө орой нь ууртай догшин болчих жишээтэй. Өглөөний хүнээ чи огт санахгүй. Учир нь тэр үед ухааны өөр тал ажиллаж байсан. Гүүр холбоос үгүй болоход 2 тусдаа хүн шиг л байна. Харин холбоос идэвхжих юм бол 2 ухаан салангид байхаа болино. Гүжиев үүнийг “оршихуйн тунгалагшил” гэдэг. Энэ бол эр эм, арга билиг, зүүн баруун, логик ба логик бус 2 талын нэгдлийг хэлсэн санаа. Зүүн баруун талын тэмцэл шийдэгдээгүй цагт хүн хайрлан жаргаж чадахгүй. Дотоод тэмцэл гадна талд туссаар байна. Хэрэв чи зүүн талтайгаа ижилсэж баруунаа дарангуйлдаг бол хайртай бүсгүйдээ ч тэгэж загнана. Эмэгтэй хүн дотоод учирзүйч ухаантайгаа дайтдаг бол хайртай залуутайгаа ч мөн байлдах болно. Амрагийн холбоо жаргалаар эхэлж зовлон дарамтаар дүүсдгийн учир энэ /Эртний сайхан аялгуу, АГ 15, П.Бадралын орчуулга, УБ, 2016, х 3-4/.

## **ТЕОЛОГИ**

Үзэх: *Шашин*

## **ТӨВ / ХҮРЭЭ**

Хүний төвийн шилжилт хүйснээс зүрхэнд, зүрхнээс тархинд шилжсэн /Ошо Эзотерикийн сэтгэлзүй, х 62/. Эмх замбраагүй аргаар тархи тэг цэгт очно. Тэнд түүнд хийгээд байх юм байхгүй болно. Тархи зүрх рүү шилжинэ. Зүрх ачаалалгүй болж хөнгөрвөл ухамсрын төв хүйсэнд буудаг /тэнд, х 63/. Зэн хуврагаас та хаагуураа боддог вэ гэж асуувал гэдсээ заана. Хүйс нь анхдагч эх булагтай ойролцоо төв юм. Тархи түүнээс хол оршино. Ухамсар биеийн аль ч хэсгийг ажиглаж чадна. Амьдралын эрчим хүч гадагш урсаж байвал ухамсрын төв нь тархи, дотогш урсаж байвал төв нь хүйс болж хувирдаг /тэнд, х х 65/.

Шавь: Би зарим талаар гадаад орчноос холбоо тасарсан мэт. Бие өвдөж байхад хүртэл.

Ошо Богд: Бясалгалын аян дунд ийм эмгэг тохиолддог. Дотоод талаа гадна талын эсрэг тавьж сонголт хийснээр ийм эмгэг болдог. Учир нь чи тэнцвэрээ алдаж байгаа хэрэг. Тэнцвэр бол эрүүл төлөв. Бясалгагч болох үед дотогшоо түйлшрэх аюул бий. Бясалгал чамайг төв рүү хөтөлнө /АГ



14, Ай даа, энэ шүү дээ, х 125/. Уян чанараа алдах юм бол чи хүрээндээ эргэж ирж чадахаа болино. Энэ бол эмгэг. Өнгөрсөн түүх ийм хүмүүсээр дүүрэн. Сэрэмжтэй бай. Бясалгагч болсон үед хүрээгээ мартаж болохгүй. Зам жим чинь бүдгэрч балрахгүй байхаар хүрээ, төв хоёрынхоо дунд нүүж бай. Өглөө бясалгачхаад ажилдаа яв, олны дунд ор. Бясалгалын дараа амраг хайранд умба. Хайрын харьцаа, бясалгал хоёрыг бүү зөрчилдүүл. “Би бясалгагч хүн. Яаж бусадтай хутгалдах юм бэ” гэх хэрэггүй. Эс бөгөөс чи нэг цагт хүрээнээсээ холбоо тасарч төвдөө царцах болно. ***Ертөнцөд 2 төрлийн үхмэл хүмүүс бий. Нэг хэсэг нь төвдөө хөлдсөн, нөгөө хэсэг нь зах хүрээндээ царцсан.*** Амьд бодьгал байхын тулд төвөөс хүрээ рүү, хүрээнээс төв рүүчөлөөтэй нүүж бай. Тэд бие биенээ тэтгэн баяжуулж, хурцалж өгдгийм. ***Зүгээр л ажигла.*** Амьдрал бол өдөр, шөнийн хэмнэл, өвөл, зуны орчил гэдгийг бүү март. Үргэлжийн орчил учраас хаана ч бүү уягд. Амьдрал бол аялал, чи аянчин. Аялал зугаалгаа баясан таашаа. Бясалгахдаа хүрээг март. Хүрээ огт байхгүй мэт бясалгалдаа уус. Дотоод ахуйдаа аль болох гүнзгий нэвтэр. Түүгээр баяжиж дэлгэр. Тэр анхилгаа зах хүрээндээ тээж авчир. Гэрэл гэгээ, сүр жавхлан, ивээл хайраа хорвоо ертөнцөд цацраа. Их хөлийн газраар Будда шиг алх. Хорвоо дэлхий чамайг бас л баяжуулна. Бусадтай харьцах нь өөрийгээ таних, ухаарах чухал боломж. Бусдын толинд чи өөрийнхээ олон дүрийг олж харна. Бусдын нүд шиг толь өөр хаанаас олох билээ. Амраг хайртан, андын нүднээс өөр нэг талаа хар. Хөндлөнгийн хүний нүднээс бас нэг дүрээ хар. Тэр бүхэн чиний оршихуйн хэлбэрүүд. Ондоо орчинд тэр бүх баялагийг цуглуул. Ухаарал, санамж сэхээг хураа. Тэр ухаарлаа өвөрлөн төвдөө эргэн ир. Төвөө хүрээнд, хүрээгээ төвд юүлэх, үүнийг байнга дадуулж бай. Хайраа бясалгалд шингээж, бясалгалаа хайранд цутга. Би үүнийг л заадаг. Эрчимт амьдрал бол энэ /тэнд, х 127/.

## ***ТӨВЛӨРӨЛ***

Ошо: Ийм зүйл надад тохиолдсон. Эхлээд төвлөрөл замхарсан. Харин одоо бол би дурын зүйлдээ төвлөрч чадна. Гэхдээ түүнд уягдахгүй. /Эртний сайхан аялгуу, АГ 15, П.Бадралын орчуулга, УБ, 2016, х 150/. Хэрэгцээ гүйцсэн хойно зүгээр л сул амгалан байдаг. Бясалгал чамд хэрэгтэй үед төвлөрөхийг зөвшөөрнө. Харин хэрэгцээ гараагүй бол зүг бүхэнд халгих ус шиг тавиун бай.

Үзэн ядалт, дурлалд чи өөрийгөө мартаж тухайн хүнд төвлөрдөг. Асуудлын учиг тэр хүмүүнд бус өөрт чинь буйг сана. Хэн нэгэнд чиглэсэн дурлал, хорсол үүсэхэд тухайн хүмүүнд бус дотоод ахуйдаа төвлөр /АГ цуврал, Нууцын ном, х 83/. Хүмүүс сэтгэл хөдлөлөө бусад руу тусгадаг. Гадна тал бол зүгээр л дэлгэц. Дэлгэц дээр чиний сэтгэлийн тусгал буудаг. Иймд дотоод ахуйдаа л төвлөр. Эх сурвалж ямагт дотоодод чинь байдаг. Доромжлуулсан Будда элбэрлээр харна, христ нөгөө хацраа өгнө, Бодидарма чанга инээнэ. Уур бухимдал мэт сэхээрэх боломж өгсөн хүмүүнд талархаад нүдээ анин дотогшоогоо нүү /тэнд, х 84/.

Хувь хүний маягаар алга болох хоёр аргын нэг нь төвлөрөл. Тэнд юу чбайхгүй боловч чухамхүү байдаг. Ямар нэг хүнгүй тэрхүү цэг дотор төвлөрлийг ашиглаж ордог. Бодидарма нарын олсон зүйл нь хэн үгүй тийм төгс эзгүй газар байсан ба тэр байтугай хайж байсан эзэн нь ч өөрөө байхгүй, хайлгаж байсан юм нь ч, хайгч нь ч байхгүй, гагцхүү төгс чимээгүй, амьд, бас өөрийн гэсэн хөгжим, бүжгээр дүүрэн төгс чимээгүй /Ошо Зэн буюу гэгээрэхүйн бясалгал, х 60/.

Бясалгал бол ердөө л таны дотоод дахь аниргүй юм /тэнд, х 63/.

Алга болох удаах арга нь grounding буюу үндэслэх гэдэг нь чиний доторхи амьдралын төвийг таталцлын хүчтэй холбоно, тэгээд таталцлын хүчээр амьдралын төвийг дүүргэнэ гэсэн үг /тэнд, х 61/. Энэ хэлбэрийн төвлөрлийн үед чи газар дэлхийн бараг л хэсэг нь болж, таталцал чам руу урсан орж эзэмдээд, тухайлбал хүйсний чинь доогуур, нарийн яривал хүйснээс 2 инч /1 инч = эрхий хурууны хир зай, 2-3 см/ доогуур мэдрэгдэхийг хэлнэ. Таталцал чиний дотор эргэн тойрон бий болоод хүйснээс 2 инч доогуур байрлана. Чамайг ну сумаа бай руу харвахаас өмнө тэр мөч

ирнэ. Чи хараалах боловч сум өөрөө харвана. Таталцлын хүч /дотоод хүч/ сумыг байнд хүргэнэ /тэнд, х 61/. Энэхүү төвлөрлийн үед чи газартай үндсээрээ гүн бэхлэгсэн мод шиг, тэгээд газраас ирэх хүчийг бие чинь хүлээн авснаар чи амар амгалан болж, тэр хүчээр амьдралынхаа төвийг дүүргэх үед оюун ухаан ажиллахаа больж, цаг хугацаа зогсоно. Энэ нь нэг талаас бясалгал болж байна гэсэн үг. Асуудлын гол нь оюун ухаан зогсох, цаг хугацаа зогсох ёстой. Чи тайвширч, амьдрал чамайг эзэмдэх юм /тэнд, х 62/. Оюун ухаанаас ангид байхдаа хүн биш, бүхлийн хэсэг учраас юу ч хийсэн алдахгүй. Бүхэл хэзээ ч алддаггүй, хэсэг л алддаг. Ямар нэгэн дүгнэлтгүй хоосон чанарт байхдаа хүн алддаггүй. Та бүхий л дүгнэлтээс зайлсхийснээрээ /дүгнэлтгүй хоосон/ бүхий л хязгаарлалтаас зайлсхийж чадна. Тэгээд та хязгааргүй оршихуйд бий болохын цагт хэзээ ч алдахгүй. /тэнд, х 65/. Бүх зүйл ухамсар учраас юуг ч бясалгалд шилжүүлж болно, юуг ч бясалгал болгож болно. Сэлмийн тулаанд илүү их ухамсар шаардлагатай. Учир нь амьдралаараа дэнчин тавьж байна. Сэлмийн тулаанд бодох хугацаа байхгүй. Бодож тооцоход хугацаа ордог тул үхэх болно. Сэлэмчинд бодох нь боломжгүй зүйл. Ямар ч бодолгүй үйл. Энэ нь бясалгалын тухай яриа юм. Хэрэв бодлоос ангид байж чадвал, бүрмөсөн нэгдмэл байж чадвал, толгойгоор бус совингоороо байж чадвал бясалгаж чадна /тэнд/.

### ***ТҮГЭЭХҮЙ / ӨГӨХҮЙ***

*Үзэх: Эртний сайхан аялгуу АГ 14→ х 21-22*

### ***ТҮҮНЧИЛЭН ИРСЭН***

*Үзэх: Түүнчилэн чанар*

### ***ТҮҮНЧИЛЭН ЧАНАР***

*Үзэх: Би*

Хоёрдмол бүхнээс салж нэгэн чанарт орших нь сэхээрэл /Ошо Очир огтлогч, х 80/. “Надад сэхээрэл төрөвч үнэндээ хуран мэдэл үгүй. Учир нь сэрсэн билигтэн хуран мэдэл бүхнээс ангид билээ” /тэнд, х 68/. Будда нар үзэл баримтлалаас ангид оршдог. Чамайг зүгээр л байхад оршихуй та хоёрын дундах хөшиг ярагдана. Арилсан сэтгэлийн тэр чанарыг Түүнчилэн чанар гэдэг. Түүнчилэн ирсэн бээр үнэн учраас хэлж, үнэн бус учраас хэлэхгүй гэсэн үзэл бодлоос ангид. Тэр бээр сонголтгүй ярьдаг. Түүнчилэн ирсэн үнэнийг хэлдэг юм биш. Үнэн өөрөө Түүнчилэн ирсэнээр хэлэгддэг юм. Оршихуй түүгээр дамжуулж дуугаа дуулдаг. Үнэн түүгээр хөлөглөж дэлхийд газарддаг. Тэр юу ч нэмж хасалгүй буй чанараар нь тусгадаг. Толь мэт тусгах чанарыг Түүнчилэн чанар гэнэ. Үнэн Түүнчилэн чанар сонголтоос ангид. Чи зүгээр л Оршихуйн зэмсэг байх болно. Байгаагаараа байж, арилсан сэтгэлээрээ орших юм бол Түүнчилэн чанар болно /Ошо Очир огтлогч, х 86-87/.

### ***УЛС ТӨР***

*Үзэх: Эртний сайхан аялгуу, АГ 14, х 147, Шашин*

Улс төрч бол сүйтгэгч оюун. Сүйтгэгч оюун хэзээ ч гэгээрэхгүй /АГ 14 Эртний сайхан аялгуу, х 148/.

### ***УРАН БҮТЭЭЛ***

*Үзэх: Бүтээл*

### ***УХАМСАР***

*Үзэх: Нирваан, Очир огтлогч*

Оюун ухааныг ухамсарлах аргаар, махбодийг асана, пранаяна йогийн аргаар өөрчилнө /тэнд, х 60/. Ямар нэг тодорхой юмыг ухамсарлахгүйгээр орших цэвэр ухамсрын төлөв буюу нэгэн агшнаа оюун ухаан, махбод нэг болж хоорондоо ямар ч зөрчилгүйгээр синхрон төлөвт очиход та махбод ч биш, оюун ухаан ч биш болно /Ошо Эзотерикийн сэтгэлзүй, х 60/. Энэ бол бясалгал-үгүй амьдрал, хэл яриа-үгүй амьдрал /тэнд, х 11/.

Ухамсар танд эд зүйл өгөхгүй, аливаа зорилтоо биелүүлэх арга хэрэгсэл болохгүй, зөвхөн тэдний хэрэгцээ шаардлагыг үгүй болгодог. Будда танд ухамсартай амьдрахыг зааж өгч байна. Энэ бол ухамсрын бодит үнэ цэн юм. Ухамсартай байх нь таны оршихуйн хүртэхүйд шууд нөлөөлж таныг бий болгодог. Таны би гэсэн хүртэхүй болон “өөрөө” хэмээх мэдрэхүй үгүй болж, таныг юу ч тодорхойлохоо больж, оронд нь цэвэр ариун, эцэс төгсгөлгүй, юунд ч хоргодохгүй хоосон чанар гарч ирдэг. Та зөвхөн төрөл бүрийн элементүүдийн бүрдэл байж байгаад тэдгээр бүрдүүлэгч элемент, эд, эс бүр өөрийн ундаргадаа буцаж, таны “би” бутран алга алга болдог. Таны хувь хүн гэсэн мэдрэхүй үгүй болж цаашид огторгуй болон орших болно /Ошо Гайхамшигт хүмүүстэй хийсэн ярилцлагууд, 2014, х 37-38/.

Бид нэгэн бүхэл. Хүн төрөлхтөн төдийгүй даяар оршихуй нэг. Гэвч нэгдмэлийг 2 төвшинд мэдрэх боломжтой. 1 нь гүн ухамсаргүй төлөвт /чи мод шиг болж/ бүхэлтэй нэгдэнэ. Эсвэл ухамсраас хэдийдэн Будда шиг болж нэгдэнэ. Ухамсар нь хувийн, харин ухамсаргүй болон хэтийдсэн төлөв нь хотол чанартай /АГ 13, х 86/.

*Даяар оршихуй болохын тулд улам бүр ухамсарлиг болж, эцэст нь ухамсраас хэтийдэх учиртай /АГ 13, х 87/.*

Ухамсартай, ухамсаргүй нь бие биедээ шүтсэн хоёр туйл. *Хоёулангаас нь гэтлээгүй цагт Үнэмлэхүйд хүрэхгүй. Ухамсарт ч бүү уягд, ухамсаргүйд ч бүү авт. Зүгээр л бай. Энэ бол хоёрдмол чанараас гэтлэх - Бхарав. Бүгдээс хэтийдсэн сургаал. Хүмүүний туршилага дотроос гагц хайр л хоёрдмолоос хэтийдсэн гялбааг амсуулж чадна. Хайранд уусах тусам хоёр хүний хил зааг арилж, нэгэн бүхэл болдог. “Бурхан бол хайр гэсэн Есүсийн үг ийм утгатай /АГ, Нууцын ном, х 12/. Тэгэхээр өөрийгөө яаж хүртэх вэ? Энэ бол бхарав төлөв. Висьяан Бхарав Тантар хэмээх өнө эртний судар: Висьяан бол ухамсар. Бхарав бол хэтийдсэн буюу ухамсрын чинад төлөв, ухамсрын чинад халих арга /тэнд, х 12/. Ухамсар хийгээд ухамсаргүйн тэртээд, бие хийгээд сүнсний чинадад, сансар хийгээд нирваанаас хальсан дээдийн дээд оргил /тэнд, х 12/. Хайр Шивагийн оршихуй нь болсон учраас хайрыг Тэр үл ухамсарладаг. Хүмүүс харин хайргүйн дунд амьдардаг учраас хайрыг ухамсарладаг. Шива өөрөө хайр болчихсон учраас хайрыг ч үл ухамсарлана / АГ, Нууцын ном, х 14/. Шива бол бие буюу хэлбэр биш. Хайранд умбах үед бие цогцос ууршиж, биегүй чанар тодорно. Хэлбэр замхарч, хэлбэр үгүйн үүд нээгдэнэ. Угтаа хүн бүхэн хэлбэргүй чанартай. Дотроос нь харах үед хэлбэр замхарна. Та бол хэлбэргүй оршихуй /тэнд, х 15/. Хэлбэр замхарч хил зааг арилснаар хамаг ертөнц нэгэн бүхэл болдог /тэнд, х 16/.*

Буддагийн үйлдэл ухамсрын төвөөс ургаж байдаг бол хүмүүнийх ухамсаргүйгээс төрж буй. Ухаарч сэхээрч чадахгүй бол нэг алдаанаас нөгөөд, нэг нүхнээс нөгөөд ойчсоор явна. *Амьдралдаа олон юм сурдаг ч өөрсдийг чинь хувиргаж чадах цорын ганц ухаан болсон ухамсар сэхээнд суралцдаггүй /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 70/.*

## **УХАМСАРЛАХ**

*Үзэх: Ажиглах, Ухамсар*

## **УЯА ХҮЛЭЭС**

Лан Ен уулын даяанч Хүй Чүнд нэгэн эмэгтэй шавь оржээ. **Багш түүнд “Юу ч тохиолдсон битгий тоо” гэжээ.** Нэг өдөр байшинд нь гал авалцахад тэр “Битгий тоо” гэжээ. Хүүхэд нь усанд унахыг харсан хүн хэлэхэд “Битгий тоо” гэжээ. Тэрээр багшийн заавар ёсоор бясалгаж үймрэл бүхнээс ангижирч байлаа. Ямар гээч чин сэтгэл, бүрэн зориулга вэ. Юу ч болж байсан тоохгүй – ийм энгийн бясалгал.

**Энэ хорвоод 2 том бэрхшээл бий: Эд юмст уягдах болоод хүмүүст уягдах.** Эмэгтэй 2 сорилтыг хоёуланг нь даван гарчээ. **Юуг ч өмчлөх аргагүйг сэхээрвэл хорвоогоос гэтлэх болно** /АГ 14, Ай даа, энэ л шүү дээ, х 92-93/. Заяамал чанар амгалан бол зохиомол ахуй үймээн шуугиан. Бодол замхрахад бодь чанар тодордог. Энэ бол хорвоогоос гэтлэх нирвааны туршлага /тэнд, х 95/. Үнэмлэхүй сэрэлт, оршихуйн дээд туршлагыг Зэнгийхэн бодь үр гэдэг. Гэхдээ энэ цэцэглэл агшин зуур тохиодгийг сана. Энэ олон арга дасгал бол дурсамж, мөрөөдөл дундаа алсарч одсон чамайг одоо-д авчрах арга хэрэгсэл /тэнд, х 97/.

## **ҮГ ХЭЛ**

Үзэх: Будда, Оюун санаа

Хүмүүс ухамсаргүй төлөвт оршдог. Ухамсрын оргилоос ярьсан нэгний үг мунхагийн хөндийг туулан ирэхдээ хэдийн уг эхээсээ гажиж гуйваад тэс өөр зүйл болсон байдаг.

## **ҮЙЛИЙН ҮР / КАРМА**

Үзэх: Үнэмлэхүй

Угтаа бол чи нэр ч биш, дүрс ч биш, нэрлэшгүй, дүрслэшгүй цэвэр тунгалаг ухамсар. Энэ бол Оршихуйн жинхэнэ мөн чанар. Дасаж уягдахаараа л чи сэтгэл болчихдог. Дасаж уягдахаараа л чи бие махбод болчихдог. Бодол гадных, бодол үгүй нь чинийх. Бодол үгүй нь Буддагийн мөн чанар. Будда болсон хүн бодол үгүй амьдардаг. Тийм болохоор хариуцлага үүрэхгүй. Үйлийн үр хураахгүй. Тэр бээр сансрын гинжин хэлхээнд орооцолдохгүй амьдарч, нүүж сууж, идэж ууж, ярьж хөөрдөг. Өчнөөн юм хийх мөртлөө үйлийн үр хураахгүйн учир юу вэ? Учир нь үйл үр – карма бол идэвхийлэл. Будда идэвхийллээс ангижирсан нэгэн. Тэр юунд ч сэтгэл уягдаж, юунд ч бодол ороогдохгүй, хоосон чанар лугаа оршдог. Будда хүн алсан ч үйлийн үр хураахгүй. Будда үйлээс ангид, эгогоос тусдаа учраас үйлдэгч биш. Түүнд бүх юм ая зөнгөөрөө учирна. Ертөнц зөвшөөрсөн бол тэр ч бас зөвшөрнө. Энэ бол хоосон чанарын оршихуй, би үгүй анатта юм. Хоосон чанарт ямар ч үйлийн үр, нисваанисын буртаг байхгүй /АГ цуврал, П.Бадралын орчуулга Чинадын чинадад, х 56/.

## **ҮЙЛДЭГЧ**

Үзэх: Мөн чанар

## **ҮЙЛЭЭС АНГИД ҮЙЛ**

Үзэх: Мөн чанар

## **ҮЛ ИЖИЛСЭХ**

Үзэх: Эго, Мөн чанар

## **ҮЛ МЭДЭХҮЙ**

Үзэх: Бүхэл/Нэгдэл

## **ҮНЭМЛЭХҮЙ**

Үнэмлэхүйд хүрэх 2 зам бий. **Эхнийх нь зорин хатамжлах зам.** Энэ бол цаг хугацааны зам. **Удаах нь агшин зуурын гэгээрэл.** Эхнийх нь хязгааргүй их цаг хугацааг элэнэ, гэвч цаг хугацааны дотор тохиож буй бүхэн чамайг хэзээ ч цаг хугацааны чинадад хөтлөхгүй. Гэгээрэгсэд цаг хугацааг өнгөрсөн, ирээдүй хэмээх хоёрхон хэмжээст хардаг. Одоо бол цаг хугацаанаас чинадад хамаарна. Бодит оршихуй одоо л юм. Одоо нь цаг хугацааны хувь хэсэг биш, үүрд мөнхийн хувь. Үнэн үүрд мөнх. Удаах нь зам биш мэт боловч жинхэнэ зам. Удаах гэгээрлийн замыг Зэн багш нар “**зам биш зам**” гэдэг /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 81/. Эртний мэргэд ийн өгүүлжээ: “Өөрийгээ засахад төсөөлшгүй хугацаа орно. Харин Үнэмлэхүй гэгээрэл агшин зуур ирдэг”. Төсөөлшгүй хугацаа орохоос аргагүй. Учир нь чи сүүдэртэйгээ байлдах болно. Сүүдрээ ялах аргагүй. Ангижрах ганц л зам бий: Тэнд юу ч үгүй хоосон болохыг харах. Сүүдрийг сүүдрээр харсан цагт гэтэлнэ. Өөрийгээ засах биш, зүгээр л харах. Сүүдрийн ертөнц замхрахад амьдрал чинь жам ёсоороо гэрэлтэн гийх болно /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 84, 85/.

Яаж агшин зуур гэгээрэх юм бэ, өнгөрсөн бүх үйлийн үр-кармаг барагдуулах ёстой шүү дээ гэгцээнэ. Урьдын хорвоо чинь хир уртыг мэдэх үү, та нар. Тэргүүлшгүй цагаас хураасан үйлийн үрийг яаж барагдуулах юм бэ? Өдөр бүр үйлдэл дутмаараа та нар түүнийг баяжуулж яваа. Энэ бол үзүүр мухаргүй тойрог. Хэрэвзээ өнгөрсөн цагийн үйлийн үрийг барагдуулж байж гэгээрдэг гэвэл энэ ертөнцөд нэг ч Будда байх ёсгүй. **Үйлийн үрийг цэвэрлэх асуудал угтаа байхгүй.** Өглөө сэрээд урд шөнийн зүүдээ арилгаж цэвэрлэдэг үү, чи? Зүүдэндээ хулгайч, алуурчин, хүчирхийлэгч, гэгээнтэн байсан. Гэвч сэрэх үед зүүд замхарна. Түүнийг хаяж гээх ажил байхгүй. **Энэ бол Зэнгийн гол мессеж: Өнгөрсөн цагийн үйл түйтгэрт санаа зовох хэрэггүй. Тэр бүхэн зүүдний тохиолдол. Зүгээр л сэр.** Зүүдэн дотроо гэмтэн байснаа больж гэгээнтэн болж байж л сэрнэ гэж бүү маанат. Шуудхан сэрж болно шүү дээ. Зүүдэндээ хүн алж хүрээ талж байхдаа ч сэрж болно. Ямар ч асуудалгүй /тэнд, х 89/. Гэнэтийн гэгээрлийг заадгаараа Зэн гажууд харагддаг. Яг одоо, энэ агшинд гэгээрч болно гэж цохон хэлдэг өөр шашин суртал байхгүй. **Хэрэв бэлтгэл ханасан бол хуруу инчдэх төдийд гэгээрнэ тэнд, х 91/.** Бэлтгэл гэдэг нь зан суртахуунд биш, гадаад хэлбэрт биш, дотоод ухамсарт хийх зүйл. Унтаж буй хүнийг сэрээе гэвэл түүнд нүглийг тэвчих, буян үйлдэх тухай номлол тус болохгүй, харин хүйтэн ус тус болно. Зэнгийн бүх арга нүүр лүү чинь ус цацах, толгой руу чинь цохихтой адил.

## **ҮНЭН**

Үзэх: Инээд, Там, Түүнчилэн чанар

Үнэн чиний дотор ч, гадна ч түгээстэй. Үнэнээс холдох боломжгүй. Харин түүнийг сэрж мэдэхгүй унтаа л байж болно. Үнэнийг мэдрэхээс биш мэдэх боломжгүй. Үнэнийг тархиар биш зүрхээр л мэдрнэ. Тодруулвал зүрх төдийгээр биш бүхий л бие цогцос, буй ахуйгаар хүртэнэ /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 107/. Буддист хэллэгт Будда гэдэг “Үнэн” гэдэгтэй ижил /тэнд, х 108/. Есүсээс Иерусалимын мяндагтан Ниходэм “Бурханыг танихын тулд юу хийх вэ” гэж асуужээ. Есүс: “**Та дахин төрөх ёстой. Цоо шинэ хүн болж байж л үнэнийг харна. Баг өмсгөлөө тайлж, үзэл суртал, нэр төрөө огоорч бүрэн нүцгэрэх хэрэгтэй. Би үзлээ хаях учиртай. Дахин төрөхийн утга нь тэр юм**” гэжээ /тэнд, х 108, 109/. Яруу найраг бол оршихуйн цэцэглэл. Шашин бол гүн ухаанаас илүүтэй яруу найрагтай адил. Гүн ухаан амьдралыг тайлбарлах гэж оролдох тусмаа амьдралаас холддог. Шашин амьдралыг тайлбарлах гэж оролддоггүй. Зүгээр л амьдралыг амтлах гэдэг. Амьдрал бол шийдэх ёстой асуулт биш, харин нэн бишрэлтэйгээр амтлах ёстой гайхамшиг /тэнд, х 110/. Өрнө, Дорно хоёрт Үнэний тодорхойлт зөрүүтэй. Өрнийн гүн ухаанд Үнэн нь бодит гэсэнтэй эн тэнцүү.

Харин Дорнын хувьд Үнэн нь өнө мөнхтэй тэнцүү. Учир нь Дорнын ойлголтоор түр зуурын зүйл ч бодит. Гэхдээ үүрдийн биш учраас Үнэн биш. Энэ бол харьцангуй тусгал. Харьцангуй тусгал ч гэсэн бодит юм. Сар тэнгэрт байвч тусгал нь нуурын мандалд байхтай адил. Сарны тусгал сар биш ч бодит үзэгдэл. Зүүд ч бодит үзэгдэл Үүрдийн үнэн, зуурдын хуурмаг ахуй аль аль бодит. Гэхдээ зуурдын хорвоод уягдахаараа чи зовлон нажид эдэлдэг. Харин үүрд оршихуйн үүдийг нээвэл Үнэн, гэгээн амар амгаланг нээнэ /тэнд, х 149/.

Үнэнийг сургуулиар олдоггүй /Ошо Очир огтлогч, х 69/. Үнэнд хүрэх зам мөр бол суралцах бус үл суралцахуй юм /тэнд, х 71/. Үл суралцахуйн амтыг мэдэрч мэдлэгийн хүлээсээс салах тусам цагаан цайлган болно. Энэ зан л чамайг гэрт чинь хүргэнэ /тэнд/.

## **ҮХЭЛ**

*Үзэх: Айдас*

Амьдрал, үхэл 2 оршихуйн шүтэн барилдсан 2 тал. Үхэл үгүй бол амьдрал үгүй. Төрөл, үхэл бол хос жигүүр. Үхэл дайсан биш анд нөхөр. Оюунаас хэтийдсэн 3 нууцлаг юм бий: амьдрал, үхэл, хайр. Үхэл нэн тодорхой. Бусад бүх юм тодорхойгүй. “Үхэл тодорхой” гэж хэлэхэд айдас замхарч буйг харав уу? Үхлээс зугтах газаргүй. Түүнийг хүлээн авч тэвэрч элгэмс /Эртний сайхан аялгуу, АГ 14, х 181-183/. Үхлийг хүлээн авч чадахгүй бол чи амьдарч амжаагүй л байна. **Жинхэнэ амьдралаар амьдрах аваас ганц хором ч хангалттай. Тэр ганц хором өнө мөнхтэй тэнцэнэ** /х 184/. Тэрхүү ганц хором уртын биш гүний асуудал. Тооны биш чанарын хэрэг. Мянган жил үр хэвээрээ цэцэглэн дэлгэрч чадахгүй явж болно /х 184/. Амьдралын уртад утга байхгүй /х 185/. Сэтгэгдлийн тоосыг арчиж хая. Өглөө бүр гэрээ цэвэрлэдэг шиг дотоод гэрээ хором бүр өнгөрсөн улбаанаас цэвэрлэж бай /х 185-186/. **Өөрөөсөө түрүүлж ирээдүй рүү үсчих хэрэггүй. Амьдралд өөрийгээ нээж өг. Өнгөрснөөс ангижир. Энэ бол хором дутам нөгчих зам. Ирээдүйг бүү таамагла. Энэ бол амьдралд өөрийгээ нээх зам.** Тэгэж гэмээнэ хөлдөж ягшихгүй урсмал байх болно. **Өнгөрсөн, ирээдүйгээс ангид энэ агшиндаа эрч хүч дүүрэн, үзүүр ёзоор хоёроосоо зэрэг дүрэлзэх бамбар шиг бай. Зөнгөөрөө байх гэж үүнийг хэлнэ** /х 186/.

Үхэлд яарах юун, аяндаа ирнэ. Чиний дэм тус түүнд хэрэггүй. Тэр хэдийн айсуу. Үхэл үнэхээр амьд сэрүүн хүмүүст бус үхмэл хүмүүст, хэдийн үхдэл болчихсон хүмүүст тохиодог юм. Будда шиг, Есүс шиг хүнийг үхэл яаж хөнөөх юм бэ. Уруулаа лимбэнд наасан Кришнаг үхэл яаж зогсоох юм. Амьдралын учрал бүхнийг таашааж сур. Өвчин ирсэн ч таашаа. Таашаах урлаг бол амьдрах урлаг юм. Жинхэнэ ном, амьд ном болох амьдралын судрыг уншиж таашааж суухын оронд Библи, Крон, Гитаг уншиж суудаг. Зав гарвал тэдгээрийг унших сайхан л даа. Гэхдээ бүү амьдралынхаа орлон тоглогч болго. Амьдралтай харьцуулахад тэр бүхэн юу ч биш. Амьдралын шастирыг унших боломжтой үедээ түүнийг амьгүй номоор бүү орлуул /Аг 14, х 94/. Миний бүх онцлол бол тухайн мөчдөө бүрэн дүүрэн байх. Амьдралын сайхныг амталсан хүн үхлийн сайхныг ч амтална. Үхлийг таалан амталсан хойно үхлээс хэтийдна. Хичээл сургуулиа бүрэн дүүргэсэн тул чамд үхэл ч үгүй, төрөл ч үгүй болно. Амьдралын сургуулийг төгссөн хүн үйл үрийн хорвоогоос гэтэлдэг. Үүнийг бид бодь хутаг буюу Нирваан гэдэг /тэнд, х 95/. Талийгаач бүр амгалан харагддаг ч тэр нь амар амгалан нөгчсөн гэсэн үг биш. 99% нь аймшигтай зовлон нажид, тэмцэл хямралтай өнгөрдөг. Бие сүнс 2 хагацахыг төсөөл дөө. Чи бие цогцосдоо хэт автчихсан, ижил дасал болон уягдаж, сүнс гэдгээ ор тас мартчихсан явдаг. Тэгээд биеэсээ салах болоход ямар их зууралдан чаргууцалдаж, тулалдаж, гасалж шаналах вэ. Үхэл амгалан бол самади болж хувирдаг. Дотоод гүндээ чи бүрэн өуж өгч, уриалгахан байж уусан хайлна. Үхлийг элгэмсүү найрсгаар угтана. Ямарваа тэмцэл тулаангүй нөгчиж чадах юм бол чи дахин төрөл авахгүй. Биеийн хязгаарлалтаас чөлөөлөгдөнө. Хэлбэрт үл уягдах хил хязгааргүй амьдрал. Бие чамд хил хязгаар тогтоодог Үхэл чамаас хил

хязгаарыг хурааж авна. Бие чамайг эр эм, сайхан муухай, цэцэн тэнэг болгож ялгамжаа хүртээдэг. Үхэл тэр бүх ялгамжааг цуцалдаг. **Ялгаа зааг үгүй амьдрал** л үлдэнэ. **Тэр бол Бурхан юм**. Хором бүхнийг гүн талархлаар хүлээн авч бууж өг. Хором бүхэн сайхан /тэнд, х 98/.

**Үхэл юуг ч шийдэхгүй, чиний ухамсар л шийднэ**. Сэрсэн ухамсар үхлийг эрхэм сайхан учрал болгоно. Амьдралаас юу ургуулах нь чиний л дур таалал. Гэгээрсэн ухамсар үхлийг хүртэл сайхан болгодог. Гэгээрээгүй ухамсар амьдралыг хүртэл муухай болгодог. **Сэрсэн ухамсрын хувьд гагцхүү амар амгалан, гоо сайхан оршдог** /тэнд, х 99/. Тэгэхээр **муухайг сайханд, зовлонг жаргалд, шаналгааг таашаалд яаж хувиргах вэ гэсэн асуудал байхгүй**. Харин **ухамсаргүйг хэрхэн ухамсарт шилжүүлэх вэ, сөрөг хандлагаас салж амьдралд өөрийгээ хэрхэн нээж өгөх вэ гэсэн асуудал л бий** /тэнд, х 100/. Гагцхүү ухамсарлаг үхэл чамайг ухамсарлаг төрөлд хүргэнэ /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 82/.

## **ФИЛОСОФ**

Үзэх: *Үнэн, Шашин*

Зэн хандлагад хамгийн их ойртсон Өрнийн философим Витгэнштэйн өөрийгээ философийн асуудлыг шийдсэн бус зүгээр л сарниасан гэдэг байсан. Тэрээр: “Бид юмсыг зөнгөөр нь орхичих юм бол анх удаа тэднийг бодитоор харах байх шүү” гэж хэлсэн. Бүх юм нээлттэй, урд чинь байна. Зүгээр л учран золго, уусан хайл. Амьдралыг тайлбарлах шаардлагагүй. Зүрх зоригтой бай. Энэ бол зэн юм /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 111/. Шинжлэх ухаан эргэлзээнд, шашин гайхан бишрэхэд дулдуйддаг. Энэ хоёрын дунд гүн ухаан бий. Гүн ухаантанд эргэлзээ давамгайлвал шинжлэх ухаанч болно. Бишрэл нь дийлвэл шашинлаг болно. Харамсалтай нь философчдын 99% нь шинжлэх ухаанч болжээ /тэнд, х 128/. Сэрэмжтэй байхгүй бол мэдэхүй нь мэдлэг болж хувирна. Мэдэхүй бол уремал үйл явц, мэдлэг бол тогтонги зүйл. Мэдлэгт автсан хүн бодит байдлыг тусгах тунгалаг чанараа алддаг. Мэдлэгээрээ бүх юмыг гуйвуулж тусгана. Тэр цагт мэдэхүй мөхнө /тэнд, х 127/.

## **ХАЙР**

Үзэх: *Эртний сайхан аялгуу АГ 14: х 30-35*

Хайр бол хүсэл тачаал биш, сэтгэл хөдлөл ч биш, дотоод ахуйдаа илүү нэвтэрч, илүү төвлөрч, хэлбэрэлтгүй болох нь хайр юм /АГ 13, х 99/.

Хайр бол логик биш. Хайр бол иррационал. Хайр бол амьдрал. Хайр бол зэрлэг онгон амьдрал. Тиймээс Есүс: “Бурхан бол хайр” гэсэн. Энэ нь хайрлах юм бол чи чөтгөрийг хүртэл хүлээн зөвшөөрч чадах, сөргүүг хүртэл агуулж чадах аугаа оршихуйг ухаарна гэсэн үг. Дайсан ч гэсэн андын төрөл, үхэл ч гэсэн амьдралын хэсэг болохыг танина гэсэн үг. Бүхэл бол эсрэг тэсрэгийн нэгдэл төдийхэн биш, түүнээс ч үлэмж /Эртний сайхан аялгуу, АГ 15, х 172/.

Хайр гэж юу вэ? Энэ бол ертөнц дээрх хамгийн агуу амиа хорлолт. Эгогийн егүүтгэл. Хайр эгог ална гэсэн үг. Хайр бол үнэмлэхүй егүүтгэл. Эгогийн хувьд чи хэдийчинээ үхнэ, төдий хирээр амьдрал дэлгэрч, хайр жаргалаар бялхана. Хайр бол сэтгэлийн егүүтгэл. Бясалгал бол сүнслэг егүүтгэл. Хайран дунд сэтгэлээс ангижирч, бясалгал дунд бодьгал буюу эзэн биеэс чөлөөлөгддөг. Чи зүгээр л хоосон чанар болж хувирна. Тэр хоосон дунд Буддагийн лянхуа дэлгэрдэг юм /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 78/.

**Дээд оргил бол үнэн, хайр, ухамсар сэхээ, бүрэн дүүрэн байхуй гэхчилэн үнэт зүйл бүхний нэгдэл юм. Оргилд тэдгээр юмс хуваагдашгүй болдог**. Хайр дээд шатандаа буюу гүн ёроолдоо сэтгэлээс

хальж сүнслэг болдог. *Хайр 100% шижир болсон нөхцөлд чи энэрэл нигүүсэл, ухамсар билгийг ялгаж чадахгүй. Бурхан, хайр хоёрыг салгаж чадахгүй.* Иймд Есүс “Бурхан бол хайр” гэсэн. Өнгөн гадаргууд юм бүхэн тусдаа оршдог. Төв рүү ойртох тусам ялгаа замхарсаар дотоод цөмд хүрэхэд бүгд нэгэн чанартай болдог. Тиймээс Вирэндра: чиний асуулт хайр, ухамсрыг ялгаагүй үед зөв асуулт. Харин оргилыг таньсан үед утгагүй болно. Тэнд дээд, доод гэсэн ялгаа байхгүй. Чухамдаа 2 тусдаа эрхэм чанар байхгүй. Гэхдээ бэлээс өгсөх 2 зам бий. Нэг нь ухамсар буюу бясалгалын зам. Зэн бол ухамсрын зам. Нөгөө нь хайрын харгуй, бишрэгч буюу Бакта, Суфичүүдийн зам. Оргилд дөхөх тусам зам мөрүүд уусалдсаар эцсийн бүлэгт нэг болно. Ухамсрын замыг дагасан хүн түүний дагуул хайрыг олно. Хайрын замыг дагасан нь түүний дагуул билгийг хүртдэг. *Ухамсар, хайр 2 нэг зоосны 2 тал. Хэрэв ухамсар чинь хайраар дутаж байвал цэвэр билиг болоогүйн шинж. Дотор чинь мунхагийн түйтгэр ноёлсоор байна. Хэрэв хайр чинь ухамсар сэхээгүй бол жинхэнэ хайр биш. Залбирал, талархлаас хол, шунал тачаалд ойр байна.* Тиймээс *ухамсрын замыг дагаж байгаа бол хайраар хэмжүүр хий. Нэг л мэдэхэд хайрын анхилга тохиох юм бол билиг тохиож, самади биелсэн гэж ухаар. Хайрын замыг дагаж байгаа бол ухамсраар хэмжүүр хий. Гэнэт энд-одоогоос хайрын зүрхэнд билгийн гэгээ ургаж эхэлвэл баясан таларх. Чи гэртээ иржээ /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 98-99/.*

Ошо: Хайр бол амьдралын өөр нэг нэр юм, оршихүйн өөр нэг нэр юм, Бурханы өөр нэг нэр юм. Хамгийн доод түвшний хайрыг хүртэл бүү буруутга. Яагаад гэвэл, буруутгаад байвал тэр хувирч өөрчлөгдөж чадахгүй. Хайрыг байгаа тэр чигээр нь л хүлээж ав. Ойлгох гээд оролдоод үз. Ингэж ойлгох явцад чинь хайр өөрчлөгдөж эхэлдэг. Тэр хуял тачаалаас дээд юм болж хувирдаг. Хайрыг хэдийчинээ гүн ойлгоно, төдийчинээ хайр өндөр түвшинд хайр дүүлдэг. Хайр ойлгохуйн даль жигүүр, сэрэхүйн даль жигүүр, бясалгалын даль жигүүрийг ашиглан дээш хөөрдөг. Хайр дээр нэмэх бясалгал бол авшиг юм. Өөрийнхөө хайрыг аль шатанд байсан ч бай улам бүр бясалгагч чанартай болго. Бясалгал хайрыг чинь өөд нь өргөнө. Бясалгал дангаараа байх үедээ эрчим хүчгүй байдаг. Хайр дангаараа байхдаа ухамсаргүй байдаг. Энэ хоёр хамтрах ёстой, гүн түншлэх хэрэгтэй...

## **ХООСОН ЧАНАР**

*Үзэх: Барамид 5. Дияан, Будда, Очир огтлогч*

Аливаа юмс уг чанартаа ив ижил. Өнгөн талдаа л ялгаатай. Мод, чулуу, од, гараг, чи, бид... Адилгүй мөртөө нэгэн адил чанартай. Анги ялгаа бүхэн зүүд зэрэглээ. Тэр адил чанарыг физикчид эрчим буюу энерги гэнэ. Материалистууд матери, идеалистууд оюун санаа, егүзэрүүд сүнс /ухамсар/, харин уг түгээмэл ахуйг Будда бээр “хоосон чанар” гэжээ /Нирваан, х 76/.

Бодол айдсаас ургадаг. Дотроо ялихгүй айдас, шалихгүй бодолд ээдрэх юм бол хоосон чанарт үйлдэж чадахгүй /Эртний сайхан аялгуу АГ 14, х 81-83/.

Лууз: Дао /хоосон чанар/ нэгийг төрүүлнэ, нэг нь хоёрыг, хоёр нь гурвыг төрүүлдэг. Нэг үгүй бол хоёр ч, олон ч үгүй, мөн эсрэгээрээ энэ бол шүтэн барилдлага. Бас бүгд хоосон гэсэн үг.

Күнз: Үүр цайхад Даог таньчихвал нар мандмагц үхэхэд гомдолгүй.

Хоосон чанарын хос жигүүр: - үл дасах буюу үл ижилсэх; -үл ялгаварлах /АГ цуврал, Чинадын чинадад, х 158/.

## **ХУВЬСГАЛЧ**

*Үзэх: Тархи*



## **ХУРАН ЭС ҮҮДСЭН /ХООСОН**

Үзэх: *Хутагт /ХУтагтын чанар*

## **ХУТАГТ /ХУТАГТЫН ЧАНАР**

Хуран эс үүдсэн /хоосон/ гэдэг нь бүх шалтгаацлаас хэтийдсэн гэсэн үг. Дурлал - хорсол, амьдрал – үхэл, агуу – өчүүхэн, өдөр – шөнө, эр – эм, там – диваажин гээд хоёрдмол бүхнээс хэтийдсэн үнэмлэхүй чанар л хутагтын ялгарах чанар /Ошо Очир огтлогч, х 48/.

## **ХҮСЭЛ**

Үзэх: *Би, Би үзэл*

## **ХҮЛЦЭЛ**

Үзэх: *Барамид 3. Хүлцэл тэвчээр, Эго*

Бурхан Багш: Хар бор санаагүй хүлцэл хамгаас хүчтэй. Хэдийчинээ амирлана, төдийчинээ хүчтэй болно”.

Ошо: “2 янзын амьдрал бий. Нэг нь байлдагчийн зам буюу 99,9% нь ялагдлын зам. Учир нь тэд амьдралтай тулалдана. Нөгөө нь санъясины зам. Өөрийгээ бүхлээс тусдаа гэж боддоггүй амьдралд уусдаг. Хүлцэнгүй нэгэн хэнтэй ч байлдахгүй учир хэнд ч ялагдахгүй. Тэр бүхлээс тусдаа эс орших учир бүхнээс хүчтэй. Лууз: “Би аль хэдийн бууж өгсөн болохоор хэн ч намайг дийлэхгүй”. Ялалтанд шунадаггүй хүнийг яаж дийлэх вэ. Олзонд шунадаггүй хүн дампуурдаггүй. Үгээгүйг баялаг болгосон хүнээс юуг нь дээрэмдэх вэ.

Александр энэтхэгээс даяанч авч явах гэжээ.

Даяанч: Би гэртээ байна.

А: Зочин болж явахгүй бол хоригдол болж явна даа.

Д: Хүлээсээ тайлчихсан намайг хэн ч хорьж чадахгүй.

А: Толгойг чинь авна.

Д: Үнэндээ би толгойгоо хэдийн авчихсан.

Будда “хүлцэнгүй чанар хамгаас хүчтэй гэдгийг би үзлээс ангид утгаар хэлж байна. Эгогоос гэтэлсэн хүн үхлээс ч хэтийддэг, хүч чадлын хэмжээнээс ч хэтийддэг. Энэ хүч найрсал зохирлоос ургадаг /Өөрөө өөртөө гэрэл бол, АГ 11, 2013, х43/.

Хүлцэл бол хүч чадал, бясалгал бол гэрэлтэхүй. Нэг зоосны 2 тал. Аль аль талд нь хичээвээс шүтэн барилдлага тодорно /АГ 11, х 51/.

## **ХҮЛЦЭНГҮЙ**

Күнз: Бүхий л амьдралыг жолоодогч ганц үг байж болно. Тэр бол хүлцэнгүй.

## **ХҮН**

Үзэх: *Огоорол*

Будда: “100 муу хүнийг хооллосноос ганц сайн хүнийг хооллосон нь дээр” /Ошо Зам мөр, жам ёс х 81/. Буддагийн “сайн”, “муу” хүн:

Муу хүн: Өөрийгээ ертөнцийн төв гэж боддог, өрөөлийн эрх ашгийг хайхардаггүй, бусдыг хувийн эрх ашгаа хангах хэрэгсэл болгодог хүн. Муу хүнийг гэмт хэрэгтэн л гэж ойлгодог. Гэмт хэрэгтэн бүр муу хүн биш. Будда өөрийн төлөө бусдыг золиослох хандлагаар нь тодорхойлж байна.

Сайн хүн: Зөвхөн өөрийгээ ертөнцийн төв гэж боддоггүй, бодгаль бүхнийг тийм төв гэж ойлгодог, бусдыг өөртэйгээ адил хайхарч үздэг, амин хувийнхаа төлөө бусдыг золиослохыг хүсдэггүй хүн /х 81/.

Хүрээ тойрогтоо хүн бүр ондоо ч чанагуух төвдөө ив ижил. Бясалгалын гүн агшинд бүх ялгаа зааг замхардаг. Хувь хийгээд хотол чанар хоёулаа чамд бий. Энэ хоёрынхоо дунд энгүүн чөлөөтэй аялж бай. Гэрт сэрүүн бол гадаа гарч нарлах, гадаа халуун бол гэртээ орж сэрүүцэх шиг. Хорвоогийн амьдралаас дотоод аглагтаа, дотоод аглагаас ертөнцийн амьдралд тааваараа нүүж, аялж сурвал чи амьдралыг бүрнээр нь амтална /АГ 14, Эртний сайхан аялгуу, х 180/. Хүн бол тааварлашгүй оршихуй /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 153/.

## ***ХҮРЭЭ / ТӨВ***

*Үзэх: Төв / хүрээ*

## ***ХҮСЭЛ***

*Үзэх: Амьдрал, Гэтлэх, Эго*

Будда: “Хүсэлд автсан хүн зам мөрийг олохгүй. Хүслийн хирийг арилгавал зам мөр өөрөө тодорно. Тийм учир хуврагууд аа, хүслээс гэтлэгтүн”. Зам мөрийг харах нь харанхуй өрөөнд бамбартай орохтой адил. Гэрэл гиймэгц түнэр харанхуй агшин зуур сарнина. Түүн лугаа үнэнийг үзвээс мунхагийн түйтгэр арилж, билгийн гэгээ өнө үүрд гийнэ /АГ 11, х 52/.

Ошо: Хаа нэгтээ холхон байгаа гэж хайсаар байсан юм маань яг хажууд байсан юм. Би хэтэрхий холыг харсаар байсан болохоор нүд маань хажуудахаа анзаарахаа больжээ. Хүч чармайлт алга болох үед би өөрөө ч алга болсон. Хүн чинь зөвхөн хүч чармайлт, хүсэл зорилгоос л тогтдог юм билээ. Эго одоогоор бус ирээдүйгээр амьдардаг. Хүслийг зогсоох аргагүй. Түүнд зөвхөн хүрч болно. Хүрнэ ээ гэдэг нь алга болгоно оо гэсэн үг /Ошо Эр хүний тухай х 94-95/.

Хамаг итгэл найдвар тасрах үед цорын ганц найдвар чинь биелдэг юм билээ. Юу ч хүсэхээ болих үед цор ганц хүсэл чинь биелдэг юм билээ. Надад итгэл найдвар гэдэг үйл оргүй болсон. Гэхдээ би гуниж гутраагүй, харин ч аз жаргалтай, тайван, намуун дөлгөөн, сэрэмж анхааралтай байсан. Итгэл найдвар алга болохоор үүний нөгөө тал болох итгэлгүй, найдваргүй нь ч алга болсон. Ямар ч итгэл найдваргүй амьдарна гэдэг цоо шинэ мэдрэмж байлаа. Энэ ямар нэг юмаа алдаж гэсэн мэдрэмж биш харин ч шинээр олж авсан мэдрэмж байлаа. Ямар нэг үл мэдэгдэх зүйл намайг бүрхэж, надаар дүүрч байлаа. Би гэдэг амьтан одоо байхгүй болсноо зүгээр л хүлээн зөвшөөрчихсөн. Одоо би өөрийн хүчинд найдаж бие даан оршихоо больсон /Ошо Эр хүний тухай х 98/.

Орчил дунд чи биш чиний хүслийн эрчим л дахин төрж буй. Хүслээс ангижрах юм бол үйлийн хорвоод дахин төрөхгүй гэж Будда хэлдэг /АГ 13, Нирваан, х 138/.

Хүсэл зогсоход хорвоо зогсдог. Өнгөрснийг зүүд гэж ухаарахад хүсэл шуналын хүч алдуурна. Хүслийн хүч алдрахад ирээдүй ч замхардаг. Өнгөрсөн ба ирээдүй замхрахад чи сансрын хүрднээс гэтэлнэ /АГ цуврал, Нууцын ном, х 80/.

## **ХҮЧЛЭЛГҮЙ БАЙХ**

Үзэх: Хүсэл, Бясалгал

## **ЦЭВЭР СЭТГЭЛ**

Цэвэр сэтгэл бол ёс суртахуун биш, бодлоос ангид ухамсар. Ямар нэг агууламжгүй сэтгэл, зүгээр л байхуй юм /АГ 11, х 61/.

## **ШАШИН**

Үзэх: Үнэн

Шашин бол хамгийн агуу бүтээлч чанар. Энэ бол өөрөө өөрийгээ дахин төрүүлэхүй. Яруу найранг, уран зураг сайхан л даа. Гэхдээ дотоод ухамсартаа амьдрал бэлэглэхтэй зүйрлэшгүй. Бүтээлийн шатны дээд гишгүүр нь шашин юм. Энэ бол үнэмлэхүй урлаг, оргил алхими юм /Эртний сайхан аялгуу, АГ 14, х 147/. Шашинлиг соёл иргэншил нэг ч үүсээгүй. Энэтхэгийн соёл иргэншил ч улс төр. Шашинлиг улс үндэстэн нэг ч үгүй. Зөвхөн Будда, Есүс, Заратустра, Лууз гм хувь хүмүүс энд тэнд, тэд бол тусгаар арлууд. Хүн төрөлхтний эх газар улс төрөөрөө үлджээ. Улс төрийн үндэс нь амбиц. Амбиц буруу болохоороо улс төр тэр чигээрээ буруу /Эртний сайхан аялгуу, АГ 14, х 148/. Хөгжимчний сонор маш мэдрэг. Зураачийн хараа сэргэг. Ногоон өнгөний мянган төрлийг анзаарна. Яруу найрагч үг бүхэнд буй тэрхүү уянгыг нээнэ. Шашинд мэдрэхүйн бүх төрөл хэрэгтэй. Үзэх, сонсох, үнэрлэх, амтлах, хүрэлцэхүй гм. Учир нь шашин бол амьдралын өрөөл хэсэг биш бүхэл оршихуй /Эртний сайхан аялгуу, АГ 14, х 159/. Сайхан бүсгүйг харж мэдэрч байгаа бол нүд чинь мэдрэг байна. Тэндээс чи Бурханы гялбааг хүртсэн хэрэг. Бүх сайхан, бүх дүр Бурханых. Ямарваа зүйлийг эсэргүүцэхдээ Бурханыг эсэргүүцдэг /х 161/. Шашин итгэл үнэмшил бус гайхан бишрэхүйд л харгалздаг. Дуулж бүжих, хайрлан жаргах, энгүүн байх боломжоо алдсан цагт шашин амьгүй цогц, шимгүй суртал болдог. Баруунд шашныг теологи орложээ. Теологи нь шашин биш, философ маягтай. Гэхдээ бас цэвэр философ ч биш. Философ эргэлзээнд үндэслэдэг, теологи итгэл үнэмшилд суурилдаг. Шашин итгэл үнэмшилд биш гайхан бишрэхүйд л харгалздаг Хүрээлэн буй гайхамгийг харах нүд, сэрэх зүрх л хэрэгтэй /АГ 14, Ай даа, энэ шүү дээ, х 110/.

## **ЭГО**

Үзэх. Хүлцэл, Бясалгал, Оюун ухаан

Идэвхийлэл үгүй, алдар нэр үгүй, олз омог үгүй, шунал хүсэл үгүй тэр газар эго амь тавина. Тэнд бие, хэл, сэтгэлийн үйл хязгаарлагддаг. Амьдрал үндсэндээ энд зогсоно. Хүсэл зогсоход хорвоо зогсдог. Өнгөрсөн ба ирээдүй энд зогсоно. Эндээс гайхалтай ирээдүйг олж харахгүй. Энд бас бусдыг, алдаа дутагдлыг шүүмжилдэггүй /Нууцын ном, АГ 10, х 80/. Эго, хувь хүн, “би” гэдэг бол тогтмол үзэгдэл биш, үйл явц. Бид түүнийг агшин бүрд шинээр бий болгож байдаг. Энэ чинь ямар нэг хөдөлшгүй субстанц биш. Дөрөөгөө жийхэд явж, болиход зогсдог дугуйтай л адил. Хүслийн дөрөөгөө жийж байхад эго оршдог. Эго ямар нэг юманд тэмүүлж, ямар нэг юм хийхийг хүсдэг. Эгогийн мөн чанар энэ. Маргааш руу үсрэх, одоо байхгүй юм руу үсрэн ороход эго бий болдог. Эго нь байхгүй юмнаас тогтдог тул зэрэглээ мэт. Эго одоогоор бус ирээдүйгээр амьдардаг. Хүслийг зогсоох аргагүй. Түүнд зөвхөн хүрч болно. Хүрнэ ээ гэдэг нь алга болгоно оо гэсэн үг /Ошо Эр хүний тухай х 94-95/. Өөрөө буюу эго чинь бүх тамыг бүтээдэг /АГ 13, Нирваан, х 140/.

Эгогоос болж л эцэс төгсгөлгүй шаналж буйгаа анзаар. Хэн нэгэн бус хоосон чанар мэтээр амьдраад үз. Одоод орших нь сэтгэлээс хэтийдэхүй юм / АГ 13, Нирваан, х 145/.

Үнэн хэрэгтээ эгогоос гэтэлдэг хэн ч үгүй. Учир нь эго угаас оршдоггүй. Эгогоос гэтэлнэ гэдэг нь түүний оршин тогтдоггүйг л ухаарна гэсэн үг /АГ 13, х 92/.

Үйлдэгч байх юм бол чи байсаар л, эгогоос салахгүй, үйлдэгч эгог тээж явдаг юм. Эс үйлдэгч болох үед л Буддагийн “зам мөр” /дарма/ гэж нэрлэдэг бүхэл оршихуйтай нэгэн хэмнэлд орно / АГ 13, Нирваан, х 104/.

Аугаа байх нь эгогийн зорилго. Жинхэнэ хүн байх нь оршихуйн зорилго. Аугаа байхын хүсэлд автвал чи мөнхийн тэмцэл дунд амьдарна. Хүн бүхэн чамайг гэмтээж шархдуулна. Энэ галзуу уралдаан тэмцээнээс зүгээр л гарчих. Эс бөгөөс гэмтэж шархдахдаа бэлэн бай. Хүмүүс чам руу дайрч довтлоод байвал зүгээр л амаа нээчих. Чи сэг зууж яваа юмсанж. Түүнийгээ л хаячих. Тэд чамайг тайван орхих болно. Эго бол сэг юм /Эртний сайхан аялгуу, АГ 15, х 90/. Эгого нийгмийн харилцаанд хэрэгсэл маягаар ашигла. “Би” гэдэг үгийг хэрэглэхгүй бол яаж энэ хорвоод амьдрах вэ. Гэхдээ энэ бол үг төдийхэн гэдгийг сана. Хэрэгтэй үед ашиглаад хэрэггүй үед далд хийчиж сурахыг “үл ижилсэх” гэж байгаа юм /АГ 14, Ай даа, энэ л шүү дээ, х 25/.

Жа Жоу бээр хаанд: “Би бол хүний хаадаас ч илүү, номын хаадаас ч үлэмж” хэмээн харилжээ. Жинхэнэ Зэнгийн хүн даруу зангаас ангид. Зүгээр л байгаагаараа байж, хачир чимэггүй үнэнийг өгүүлдэг. Жа Жоу өөрийнхээ тухай яриагүй, бодит баримтыг л хэлжээ: “миний оршин буй юмсаас ангид энэхүү төлөв бол үнэхээр дээд. Хүний хаан, номын хааны аль ч төвшнөөс хэтийдсэн” гэж. Тэр өөрөө хэдийн замхарсан. Бардамнах хүн байхгүй, даруу загнах хүн ч байхгүй. Бардамнах, даруу загнах нь бүгд эгогийн тоглоом. Эгогоос гэтэлсэн хүн зүгээр л тунгалаг толь шиг үнэмлэхүйг тусгадаг. Жа Жоу үнэмлэхүйтэй нэгдсэн аж /АГ 14, Ай даа, энэ л шүү дээ, х 38/. **Эрхэм дээд хүмүүнд эго буюу би-гийн үзэл үгүй. Тийм болохоор л түүнийг эрхэм дээд гэнэ** /тэнд, х 41/.

## **ЭРЧИМ ХҮЧ**

Үзэх: *Кундалин*

## **ЭРХ ЧӨЛӨӨ /ХООСОН**

Эрх чөлөө гэж Будда аливаа хүсэл үгүй, дур хүсэлд автаагүй, шуналд баригдаагүй, хэрэгцээ шаардлага огт үгүй ухамсрыг, оюун ухаан үгүй ухамсар, сэтгэхүй үгүй төлвийг хэлдэг. Энэ нь тэр чигээрээ хоосон төлөв. Бүхэлдээ хоосон. Хоосонд хил хязгаар гэж үгүй, агуу том, юунд ч баригдахгүй. Зөвхөн ийм л газар эрх чөлөө боломжтой. Тэр хоосон энгийн нэг хоосон зай биш. Харин үл харагдагч ямар нэг юм бий. Гэрээсээ эд зүйлийг зайлуулвал зай нь томорно. Энэ бол бясалгалын үйл явц. Бүхнийг зайлуулах, бүхнээс ангижирч ардаа орхих, юу ч үлдэхгүй, бүр та өөрөө ч байхгүй болох явдал /Ошо Гайхамшигт хүмүүстэй хийсэн ярилцлагууд, Будда, х 63/.

## **ЭРЭЛ /ЭРЭЛЧИН**

Үнэний эрэлчин алга болоход Үнэн л үлдэнэ. Бясалгагч алга болоход бясалгал л үлдэнэ. Эрж байгаа цагт чи хэзээ ч олохгүй. Бүү эр, тэгвэл олно. Хэдийчинээ эрж хайна, төдийчинээ төөрнө. Хэдийчинээ үр дүн горилно, төдийчинээ саад тотгор учирна. Юу ч эрэлгүй сул уужим суу. Хаашаа ч явах хэрэггүй. Хэн ч Бурханыг хайж олоогүй. Хэн ч Бурхан дээр хүрч очоогүй. Чи бэлэн болмогц Бурхан чам дээр өөрөө ирнэ. Бэлэн болно гэдэг нь юунд ч бэлдэхгүй, зүгээр л ухамсар сэргэг байхыг хэлнэ. Чамайг бүрэн сэргэг үед эго хулжина. Бэлэн болох гэдэг нь чиний эргэлзэх сэтгэл огоот арилахыг хэлнэ /Чинадын чинадад, х 17-18/.

## **ЯЛАГЧ**

Хамгаас агуу ялагч бол өөрийгөө ялагч болой.

## **ЯРУУ НАЙРАГ**

Үзэх: Үнэн, Шашин

**Хятадын их найрагч Ян Ван-лигээс яруу найраг гэж юу болохыг асуухад тэрээр: “хэрэв чи түүнийг үг гэж байгаа бол би яруу найраг гэж үгээс ангижрахуй гэж хэлнэ. Хэрэв утга гэж хэлвэл би яруу найргийг утгаас ангижрахуй гэнэ. Үг, утга үгүй бол яруу найраг хаана байх юм бэ гэж гайхах байх. Үг, утгын цаана байгаа нь л яруу найраг юм шүү дээ” /тэнд, х 109/. Гийм ээ, үг, утга хоёулаа замхрах агишинд яруу найраг тэсэрнэ.**

Леополд Стаффын Гүүр шүлэг /АГ 14, х 111/:

*Итгэж яднам, би  
Түргэн урсгалт, өргөн мөрний хөвөөнд зогсож байсандаа,  
Туйхан зэгсний гөрмөл гүүрээр гарч явсандаа.  
Эрвээхэй шиг хөнгөхөн атлаа заан шиг хүндхэн алхсаар  
Бүжигчин шиг цолгин мөртөө сохор хүн шиг тэмтэчсээр  
Тэр гүүрээр гарч явсандаа  
Тэртээх эрэг дээр одоо зогсож байгаадаа  
Итгэж яднам.  
Жан Пиэн /тэнд, х 119/:*

*Агшин зуурын аянга  
Сэтгэлийн хаалгыг зад ниргэв.  
Ай, буурал\* минь та  
Гэртээ л байж шүү дээ.  
\* Буурай гэдгээр Зэн хүмүүс Бурханыг илэрхийлдэг.*